

“Баяр”  
хөөр

# ИОХАН

## Библи судлал

*Үнзгүй-Зарахыг хориглоно*



*“Тэр өөрийн хоньдыг нэрээр нь дуудаж,  
тэднийг гадагш дагуулж гарна”...*

ИОХАН 10:3Б

## ЯАГААД ИОХАНЫ САЙН МЭДЭЭ БИЧИГДСЭН БЭ?

Мөн энэ номд бичээгүй өөр олон тэмдгийг Есүс (Өөрийн) шавь нарын өмнө үзүүлсэн юм. Харин эдгээр нь Есүс бол Христ, Бурханы Хүү мөн гэдэгт та нарыг итгүүлэхийн тулд бичигдсэн бөгөөд ингэснээр итгэлээр дамжуулан та нар Түүний нэрээр амьтай болох юм.

**Иохан 20:30, 31**

Иохан өөрийгөө "Есүсийн хамгийн хайртай дагалдагч" гэж нэрлэжээ.

Есүс бусад дагалдагчдаасаа илүү Иоханыг хайрласандаа биш, харин тэднийг хайрласан Есүсийн хайрыг Иохан бусдаасаа илүү ихээр мэдэрч байсан байх. Тийм ч учраас тэр Есүст чин сэтгэлээсээ талархаж, Түүнийг хайрладаг байсан төдийгүй энэ дэлхийн төлөөх Христийн үйл ажиллагаа ба зорилгыг ойлгон мэдэрдэг байсан.

Матай, Марк, Луксийн баярын мэдээний номнууд бичигдсэнээс хойш олон жилийн дараа Есүс зөвхөн хүн байсан гэсэн худал сургаалууд тархсан байна. Тийм учраас Иохан Есүс бол Бурханы бүтээсэн бие махбодь байсан гэдгийг илэрхийлж харуулахын тулд энэ онцгой номыг бичжээ. Тэрээр Есүсийн үйлдэж байсан олон зуун гайхамшигууд дундаас Есүс бол дуудагдсан Нэгэн байсан гэдгийг баталдаг гайхамшигуудыг Иохан онцолж тэмдэглэсэн байдаг. Иохан эдгээр гайхамшигуудыг "тэмдгүүд" хэмээн нэрийдсэн байна.

Түүнчлэн Иохан тухайн үед шашны удирдагчид юуны учир Есүсийг үзэн ядаж, Түүнийг цовдлохыг шаардаж байсныг гэрчилдэг. Учир нь Есүс Өөрийгөө Бурхантай адил хэмээн тунхагласан байна. Мөн тэрээр Есүс хэрхэн энэ дэлхийг гэмээс чөлөөлөх "Бурханы Хурга" болон төлөвлөгдсөн ба Тэрээр хүн төрлөхтний гэмийн цагаатгалын төлөө Өөрийгөө Бурханы хүссэн төгс тахил болгон өгснийг өгүүлсэн байна.

Иоханы зорилго нь өөрийнх нь *түүний* Баярын мэдээний (сайн мэдээ) номыг уншсан хүмүүс Есүст итгэж мөнхийн амьдралыг хүлээж авахын тулд байсан юм.

Энэхүү Сайн Мэдээгээр дамжуулан Иохан таныг Есүст итгэж, Түүнийг өөрийн амьдралдаа Аврагч Эзэнээр хүлээн авхад чинь удирдаасай хэмээн би залбирч байна. Есүс бол Амь бөгөөд Тэрээр Өөрийн энэхүү мөнхийн амиа тантай хуваалцахыг хүсэж байна. Та өнөөдөр хуучин амьдралаа орхиж Түүнийг хүлээн авч яагаад болохгүй гэж? Танд өгсөн шинэ амьдралын төлөө Түүнд талархаарай. Өдөр бүр Түүнтэй нөхөрлөж баяр хөөртэй байгтун. Мөн өдөр бүр Түүнд таалагдахын төлөө амьдарч гайхамшигтай Есүсийн тухай бусдад яригтун. Учир нь Есүс бас тэдэнд хайртай.

—(Mrs.) Vicky R. Benson

## БУРХАНЫ ҮГИЙГ ХЭРХЭН СУДЛАХ ВЭ?



**1. Бурханаас тусламж гуйх.** Бурханы үгийг судлаж ойлгохын тулд та Бурханаас тусламж гуйх хэрэгтэй. Дуулал 119:18-р ишлэлийн дагуу гуйж болно. "Таны хуулиас гайхамшигт зүйлсийг Надад харуулахаар нүдийг минь нээгээч"

**2. Чимээгүй газар очоод Библийн хэсгээс анхааралтай унш.** Хамгийн ихээр танд хүрч буй үгсийн доогуур зур. Учир нь Бурхан тантай Үгээрээ дамжуулан ярьдаг гэдгийг та санаарай.

**3. Библийн хэсэг дэх асуултанд хариул.**

**4. Зөв хариулсан эсэхээ номын арын хавтаснаас харж шалга.**

**5. Ишлэлүүдийг цээжилж тогтоо.** Цээжлэх ишлэлээ дахин дахин харж, харахгүйгээр хэлж чаддаг болтлоо чангаар унш. Хэрвээ та хүсвэл ишлэлээ хуудсан дээр бичээд үргэлж авч явж болно. Үүнийгээ та өдөр бүр чангаар унш. Тэгэх юм бол та уг ишлэлийг маш амархан цээжлэх болно. Цээжилсэн ишлэлээ найздаа хэлж алдаагаа засуулах эсвэл, харалгүйгээр цаасан дээр бичээд дараа нь үг нэг бүр нь зөв эсэхийг Библи тэйгээ харьцуулан шалга. Ингээд та ишлэлээ цээжилчихвэл эхлээд 7 хоногт нэг удаа, дараа нь сард нэг удаа дахин дахин шалгаж үз. Энэ "үнэт эрдэнэс" зүрх сэтгэлд чинь хадгалагдах үед таны яриа болон үйлдэл чинь өөрчлөгдөх болно. Үүний дараа сайн цээжлэхээр дахин нэг ишлэл сонго.

**6. Та уншсан, судалсан, цээжилсэн Бурханы Үгийн тухай бод.** Бурхан Өөрийнх нь үгийг өдөр шөнийн туршид судалсан хүнд онцгой амлалтуудыг өгсөн байдаг:

Хуулийн энэ номыг амнаасаа салгалгүй, харин түүн дотор бичигдсэн бүхнийг сахин биелүүлэхээр өдөр шөнөгүй түүнийг бясалгаж яв. Тэгвэл чи хөгжин дэвшиж амжилтад хүрэх болно.  
-Иошуа 1:8

“Харин тэрээр Эзэний хуульд баярлаж, Түүний хуулийг өдөр шөнөгүй тунгаан бясалгадаг. Тэрээр урсгал усны дэргэд тарьсан мод адил билээ. Тэр мод цагтаа үр жимсээ ургуулдаг бөгөөд навчис нь ч хатдаггүй. Тэр хүний үйлс бүхэн нь өлзийтэй”  
-Дуулал 1:2,3

**7. Бурханы хэлснийг хэрэгжүүл.** Иаков 1:22 бидэнд хэлэхдээ “Гэхдээ өөрсдийгөө хуурдаг зүгээр нэг сонсогчид биш үгийг хэрэгжүүлэгчид бологтун гэсэн байдаг. Есүс үгийг сонссон хирнээ хэрэгжүүлдэггүй хүнийг элсэн дээр байшингаа барьсан тэнэг хүнтэй зүйрлэсэн байдаг. Салхи, бороо орж, үер болох үед элсэн дээр барьсан байшин нурах болно. Харин эрэгтэй, эмэгтэй хүмүүс эсвэл охид хөвгүүдийн хэн ч гэсэн Есүсийн үгийг сонсоод дуулгавартай дагадаг бол хадан дээр байшингаа барьсан ухаантай хүн шиг байх болно. Учир нь байшин нь хадан дээр баригдсан тул салхи, бороо, үерийн аль нь ч ирсэн нурж унахгүй байх болно. Зөвхөн Бурханы үгийг хэрэгжүүлсэнээрээ л бид сүнсээр өсдөг төдийгүй Бурханыг илүү их таньж мэддэг. Тиймд та яг юу хэрэгжүүлэхээ төлөвлөөд дараа нь үүнийгээ үйлдэгтүн. Бурхан тантай хамт байж танд туслах болно.

**8. Бурханы Үгийг хэн нэгэнтэй хуваалц.** Та сурсан зүйлсээ гэр бүлийнхэнтэйгээ хуваалцахыг хүсэж байж болох юм. Дэд хууль 6:7 дээр “...хөвгүүддээ хичээнгүйлэн зааж, гэртээ сууж байхдаа ч замд явж байхдаа ч, хэвтэж байхдаа ч, өндийн босохдоо ч түүний тухай ярьж бай” гэсэн байдаг.

## ТҮҮХ 1. ЕСҮС ХРИСТИЙН ГАЙХАМШИГТАЙ ТАНИЛЦУУЛГА



### Иохан 1:1-18

Эхэнд Үг байсан, Үг Бурхантай хамт байсан ба Үг нь Бурхан байсан. Энэ нэгэн эхэнд Бурхантай хамт байсан. Бүх юм Түүгээр бий болсон. Бий болсон юмсаас Түүнгүйгээр бий болсон юмсаас нэг ч байхгүй. Түүнд амь байсан бөгөөд амь нь хүмүүсийн гэрэл байв. Гэрэл харанхуйг гийгүүлэхэд, харанхуй түүнийг дийлсэнгүй.

Бурханаас илгээгдсэн нэгэн хүн байсан ба нэр нь Иохан юм. Иохан гэрлийн тухай гэрчилж, бүгдийг оорөөрөө дамжуулан итгүүлэхийн тулд гэрчлэл хийхээр иржээ. Тэр бол оноох гэрэл байсангүй, харин гэрлийн тухай гэрчлэхээр ирсэн ажээ.

Ертөнцөд ирсэн хүн бүрийг гэгээрүүлдэг жинхэнэ гэрэл байв.

Тэр ертөнцөд байсан. Ертөнц Түүгээр бий болсон атал, ертөнц Түүнийг таньсангүй. Тэр оорийнхондоо ирсэн боловч, оорийнхон нь Түүнийг хүлээн авсангүй. Харин Өөрийг нь хүлээн авсан болгонд, Өөрийнх нь нэрд итгэдэг хүмүүст Бурханы хүүхэд болох эрхийг Тэр өгөв. Тэд цусаар биш, махан биеийн хүслээр ч биш, харин Бурханаар торөгсөд билээ.

Үг нь махан бие болж бидний дунд оршин, бид Түүний алдрыг харцгаасан. Энэ нь Эцэгийн цорын ганц Хүүгийн алдар бөгөөд нигүүлсэл ба үнэнээр дүүрэн байсан юм. Иохан Түүний тухай гэрчлэн хашхирч

- “Миний араас Ирэгч нь надаас эрхэм. Учир нь Тэр надаас урьд оршиж байсан” гэж би Түүний тухай хэлсэн юм гэлээ. Учир нь Түүний дүүриээс бид бүгдээрээ нигүүлсэл дээрээ нигүүлслийг хүлээн авсан. Яагаад гэвэл Хууль Мосегээр өгөгдсөн бол, нигүүлсэл ба үнэн нь Есүс Христээр дамжуулан ирсэн билээ. Бурханыг хэн ч хэзээ ч хараагүй бөгөөд Эцэгийн овор дэх цорын ганц Хүү болох Бурхан нь түүнийг таниулсан юм.

## Хийх Зүйлс.

А. Асуулт бүрт хариулан бичнэ үү. Хэрвээ чадахгүй бол Библийн түүхийг дахин нэг уншаарай.

1. Хэн "Үг" байсан бэ? \_\_\_\_\_ (1-р ишлэл)
2. "Үг" хаана байсан бэ? \_\_\_\_\_ (1)
3. "Үг" нь юу байсан бэ? \_\_\_\_\_ (4)
4. Гэрэл юуг гийгүүлсэн бэ? \_\_\_\_\_ (5)
5. Гэрлийг гэрчлүүлэхээр Бурхан хэнийг илгээсэн бэ? Нэр нь \_\_\_\_\_ (6)

\Энэ нь Баярын Мэдээний зохиолч Иохан биш Иохан Баптист байсан юм.\

6. Хэн Есүсийг хүлээж аваагүй вэ? \_\_\_\_\_ (11)  
\Израиль нь Бурханы сонгосон ард түмэн байсан боловч тэд Христийг хүлээж аваагүй\

7. Христийг хүлээн авсан хүнд ямар эрх өгөгдөх вэ?  
\_\_\_\_\_ болох эрх (12)

8. Бурханаар төрөгсөд нь " \_\_\_\_\_ , \_\_\_\_\_ ба \_\_\_\_\_ хүслээр төрдөггүй. (13)

\Хэн нэгэн хүн Бурханы хүү болно гэдэг нь Бурханы хийдэг гайхамшиг юм. Энэ нь

Христчин эцэг эхээс төрсөнөөр юм уу эсвэл та өөрөө хүссэнээр зүгээр нэг болчихдог зүйл биш. Мөн хэн нэгэн таныг дахин төрөөсэй гэж хүссэнээр ч болохгүй. Шинэ төрөлт нь Бурханы ажил юм.\

9. "Үг" нь юу болсон бэ? \_\_\_\_\_ (14)
10. "Үг" нь хаана оршсон (амьдарсан) бэ? \_\_\_\_\_ (14)

11. Бид Христийнх болсоноор ямар хоёр зүйлсийг хүлээн авсан бэ? "Түүний \_\_\_\_\_ -ээс бид \_\_\_\_\_ дээрээ \_\_\_\_\_ хүлээн авсан."

\ивээлийн дараахь ивээл\ (16)

12. Учир нь хэн ч хэзээ ч Бурханыг хараагүй, харин хэн Түүнийг таниулахаар ирсэн бэ?

...цорын ганц \_\_\_\_\_ болох... (18)

\Учир нь Есүс бол Бурхан бөгөөд Тэр дэлхий дээр байх үедээ мөнхийн улсад байгаа Эцэгтэйгээ ч бас нэгэн цагт хамт байж болох байсан./ (18 болон 1-р ишлэлийг хооронд нь харьцуул.)

Б. Иохан 1:12-р ишлэлийг бичиж аваад цээжил.

## Есүс бол Бурхан – Тэр Хүн болон Ирсэн

Бид Есүсийг хүлээн авч Түүний нэрэнд итгэхээсээ өмнө Түүнийг хэн болохыг мэдэх хэрэгтэй. 18-р ишлэл дээр Есүс бидэнд Бурханыг харуулахын тулд ирсэн гэж байдаг. Хэн ч Бурханд ойртон очиж, Түүнийг бүрэн дүүрэн харах боломж байгаагүй. Учир нь Бурханы алдар маш хурц гэрэлтэй бөгөөд Тэр туйлын ариун билээ.

Харин хүн гэмтэй учир сүнсний харанхуй байдалд амьдардаг. Энэ дэлхийн харанхуй байдал нь Бурханыг үгүйсгэж биднийг Түүнгүйгээр амьдруулахыг хичээдэг.

Гэвч бид 5-р ишлэлээс харанхуй гэрлийг дийлсэнгүй гэдгийг харж болно.

Библи хэлэхдээ: **“Бурхан бол гэрэл” бөгөөд түүний дотор ямар ч харанхуй байдаггүй**” (Иохан 1:5) гэсэн байдаг. Есүс бол Бурхан төдийгүй **“Жинхэнэ Гэрэл”** (9-р ишлэл) гэж нэрлэгдсэн байдаг. Тиймд хүн өөрийгөө **Жинхэнэ Гэрлийн** тусламжтайгаар гэм нүгэлтэн гэдгээ харж чадах төдийгүй Бурхан гэж хэн болохыг үнэнээр нь мэдэж чадна. Мөн түүнчлэн хүн ямар байх ёстой вэ гэдгээ ч мэдэх болно.

Бидний амьдардаг энэхүү харанхуй дэлхийд Бурханыг харуулахаар **Жинхэнэ Гэрэл** (Есүс) гэрэлтдэг нь ямар гайхалтай вэ! Нэгэн бяцхан охины хэлснээр бол **“Есүс бол Бурханы авсан хамгийн сайн зураг юм”**. Есүс бол Бурханы дүр зураг буюу хүмүүс бид Түүнийг харж, сонсож, хүрч болох Нэгэн билээ. Есүс хүмүүсийн дунд амьдарч байсан. 14-р ишлэл дахь **“оршсон”** гэдэг үг нь **“байрласан”** гэсэн утгатай. Есүс бидний дунд байрласан. Израилийн түүхийн эхэн үе буюу Хуучин Гэрээний үед Бурханы зохиож өгснөөр Майхан сүмийг Израилийн ард түмэн нэг газраас нөгөө газар уруу нүүж явдаг байсан. Майхан сүм дараа нь Иерусалем дэх сүм буюу Бурхан өөрийн сонгосон хүмүүсийнхээ дунд амьдардаг газар болжээ. Сүүлдээ Израилчууд гэм үйлдэхэд Бурханы оршихуйн алдар сүмийг орхисон байна. Харин одоо Бурхан Есүсээр дамжуулан өөрийн хүмүүсийн дунд **“майхан сүмийг”** эргүүлэн авчирсан! Үүнийг олон хүн ойлгохгүй байгаа

нь муу хэрэг биш гэж үү? Есүсийг ирэхэд Түүнээс Бурханы алдрыг харсан (14-р ишлэл) бүх хүмүүс үнэхээр итгэсэн.

### **Есүс бол Бурханы Үг.**

Библи дээр “Таны үг бол муний хөл дэх дэнлүү, зам дахь гэрэл юм” (119:105) гэсэн байдаг. Есүсийн өөр нэг нэр бол “Бурханы Үг”. (1, 14-р ишлэлийг харьцуул) Библи бол Бурханы бичигдсэн Үг, харин Есүс бол Бурханы Амьд Үг юм. Учир нь Бурхан Есүсээр дамжуулан өөрийгөө хэн болохыг хэлдэг.

**“Эрт үед эш үзүүлэгчдээр дамжуулан эцэг өвгөдөд олон хэсгээр болон янз бүрийн арга замаар айлдсан Бурхан, эдгээр эцсийн өдрүүдэд Өөрийн Хүүгийн дотор бидэнд хандаж айлдав. (Еврей 1:1, 2а).**

### **Есүс бол Бурханы Амь.**

Бид Есүсийг зүрхэндээ хүлээж авах үедээ бид яагаад Бурханы хүүхэд болдог юм бол гэж та гайхаж байсан уу? Яагаад гэвэл **“Түүний дотор амь байдаг юм”** (4-р ишлэл)

Бүх амьд зүйлсийг Есүс бүтээснийг бид хардаг. (3, 10-р ишлэл) **“Бүх юмс Түүгээр болон Түүн дотор бүтээгдсэн. Тэр бүх юмсын урьд байж, Бүх юмс Түүний дотор оршин тогтнодог.”** (Колоссой 1:16 б, 17). Есүс Бурхан шиг бүх амийн хүч бөгөөд түүнчлэн тэднийг бүгдийг нь тэтгэж байдаг Нэгэн юм.” **Тэр Өөрөө амь амьсгал хийгээд хамаг юмсыг бүгдэд өгдөг..... бид Түүний дотор амьдарч, хөдөлж, оршин тогтнодог”.** (Үйлс 17:25а, 28б).

Бурхан хүнийг бүтээгээд биенд нь амьсгалыг үлээн оруулсанаар тэрээр амин сүнстэй болсон ба Есүс ч гэсэн мөнхийн амьдралыг хүнд өгөхөөр ирэхдээ бүх махан биеэс дээгүүр байх эрх мэдлийг Түүнд өгчээ. (Иохан 17:2) **“Хүүтэй хүнд амь бий. Бурханы Хүү байхгүй хүнд амь байхгүй. (1Иохан 5:12).**

Та Есүсийг хүлээн авч Түүний нэрэнд итгэлээ бүрэн дүүрнээр тавьснаар шинэ амьдрал болох сүнслэг амьдралаа эхэлсэн үү? Хэрэв тийм бол та Бурханаар төрсөн төдийгүй Түүнээс мөнхийн амьдралыг хүлээн авсан Бурханы хүү болсон байна. Та Бурханы гэрэл дотор алхаж явахдаа Түүний амь таны дотор бүрэн



дүүрнээр бялхаж байгааг харах бөгөөд нэг ивээлээс нөгөө ивээлийг хүртэж Түүнд үнэхээр баярлах болно. Хэрэв та Түүнийг хүлээж аваагүй бол яг одоо Түүнээс шинэ амьдрал буюу мөнхийн амьдралыг өгөөч хэмээн та гуйх хэрэгтэй.

Та урьд нь хаалга тогшихыг сонсоод хариу өгч байсан. Тийм биш гэж үү? Үүнчлэн Есүс яг одоо таны өмнө зогсоод зүрх сэтгэлийн чинь хаалгыг тогшиж байна. Тэрээр ийнхүү амласан: “Хэрэв хэн нэгэн нь Миний дууг сонсоод хаалгаа нээвэл, Би түүний дотор орно” (Илчлэлт 3.20)

## БҮЛЭГ 2. ИОХАН БАПТИСТ ЕСҮСИЙН ИРЭХ ЗАМЫГ БЭЛДЭВ



### Иохан 1:19-34.

Иоханаас “Та хэн бэ?” гэж асуулгахаар нудейчүүд Иерусалемаас тахилч нар болон левичүүдийг илгээхэд түүний


хийсэн гэрчлэл ийм байлаа. Тэр үгүйсгэлгүй хүлээн зөвшөөрч  
-Би Христ биш гэж зөвшөөрөн хэллээ. Тэд түүнээс  
-Тэгвэл та хэн юм бэ? Та Елиа юм уу? гэж асуухад, тэр  
-Би биш гэсэнд,  
-Та оноох Эш үзүүдэгч үү? гэхэд тэр  
-Үгүй гэлээ. Тэгтэл тэд түүнд -Та хэн бэ? Биднийг явуулсан хүмүүст бид хариу огох учиртай. Та өөрийнхөө тухай юу —хэлэх вэ? гэв. Иохан  
-Эш үзүүдэгч Исанагийн айлдсан “Эзэний замыг шулуун болгогтун” гэж цөлд хашгирах нэгний дуу бол би билээ гэж хэлэв.  
Фарисайчуудын явуулсан хүмүүс бас байлаа. Тэд түүнээс  
-Хэрэв та Христ биш, Елиа ч биш, оноох Эш үзүүдэгч ч биш юм бол

яагаад баптисм хүртээнэ вэ? гэж асуусанд Иохан

-Би усаар баптисм хүртээдэг, харин дунд чинь та нарын үл таних Нэгэн зогсож байна. Миний араас Ирэгч нь Тэр бөгөөд Түүний шаахайн сурыг ч тайлах нь надад зохисгүй гэж хэлэв.

-Энэ явдал Иоханы баптисм хүртээж байсан Иордан голын тэртээх Бетанд болсон юм. Дараа өдөр нь Иохан өөр уруу нь ирж яваа Есүсийг хараад

- Ертонцийн нүглийг үүрэгч Бурханы Хургыг харагтун! Энэ бол Түүний тухай “Миний араас ирэх хүн миний тэргүүн байсан. Яагаад гэвэл Тэр надаас урьд оршиж байсан” гэж миний хэлсэн Тэр мөн. Би Түүнийг таниагүй. Гэвч Тэр Изриальд илчлэгдсэн байхын тулд би усаар баптисм хүртээхээр ирсэн гэв.



Иохан гэрчилж

- Сүнс тэнгэрээс тагтаа мэт буун ирж, Түүн дээр тогтохыг би харсан. Би Түүнийг таниагүй. Харин усаар баптисм хүртээлгэхээр намайг илгээсэн. Тэр “Хэний дээр Сүнс тагтаа мэт буун ирж тогтохыг чи харна, Тэр бол Сүнсээр баптисм хүртээгч мөн” гэж надад айлдсан юм. Би харсан. Энэ бол Бурханы Хүү мөн гэдгийг би гэрчилж байна гэв.

### Хийх Зүйлс.

Хоосон зайнд зөв үгийг нөхөж бич.

1. Иохан баптист \_\_\_\_\_ хашгирах нэгний \_\_\_\_\_ бол билээ гэв. (23)
2. Иохан баптист Эш үзүүлэгч Исаиагийн айлдсан “Эзэний \_\_\_\_\_ болгогтун” гэсэн зөгнөлөөс иш татсан. (23).
3. Миний \_\_\_\_\_ Ирэгч нь миний \_\_\_\_\_ байсан (27,30)

/ Энэ нь Есүс хамгаас чухал Нэгэн байсан учраас Иохан Баптисм Түүний замыг бэлдэхээр ирсэн гэсэн утгатай. Тэр ч бүү хэл Иохан өөрийгөө Есүсийн шаахайн сурыг ч

тайлах зохисгүй хэмээн хэлж байсан. Учир нь тэр Есүсийг ямар агуу хүн байсныг мэдэж байсан юм./

4. Иохан олон хүмүүсийн дундаас Есүсийг олж хараад Түүнийг \_\_\_\_\_ гэж дууджээ. Учир нь Есүс \_\_\_\_\_ үүрэхээр ирсэн юм. (29)
5. Есүс \_\_\_\_\_ байхын тулд Иохан усаар баптисм хүртээхээр ирсэн (31)
6. Иохан Есүсийг Бурханы Хүү гэдгийг мэдэж байв. Учир нь Бурханы Сүнс тэнгэрээс \_\_\_\_\_ мэт буун ирж, Түүн дээр тогтохыг тэрээр харсан ажээ. (32)  
Энэ нь бас Есүс \_\_\_\_\_-ээр баптисм хүртээхээр ирсэн гэдгийг батлах тэмдэг байв.

### **Есүсийн Ирэх Замыг Бэлдсэн нь.**

Бурханы сонгосон ард түмэн болох Изриальчуудад 400 жилийн турш Бурханы үгийг дамжуулах эш үзүүлэгч байсангүй. Тэдэнд Бурханы шаардлага болон амлалтуудыг өгүүлсэн Хуучин Гэрээг бөгөөд тэд Бурханаар тослогдсон чөлөөлөгч Мессиа нэгэн өдөр Изриалийг захирахаар ирнэ гэдгийг мэдэж байв. Исаиа "Нэгэн онгон бүсгүй хүүхэд төрүүлээд түүнийгээ Иммануел гэж нэрлэнэ" хэмээжээ. (Исаиа 7:14) Энэ нь "Бурхан бидэнтэй хамт" гэсэн утгатай аж. Харин Мика Түүнийг Бетлехемд төрж Изриалийг захирах болно гэдгийг урьдаас мэдэж байв. (Мика 5:2)

Эзэн ирэхэд бэлэн бай гэж Иохан Баптист хүмүүст заан, тунхаглаж байхад тэд үүнийг сонсоод гайхаж, баярлаж байсан болов уу? Хүмүүс хэрхэн бэлэн болсон бэ?

Иоханы хэрхэн тунхагласныг Матай бидэнд өгүүлсэн. "Гэмшицгээ! Тэнгэрийн хаанчлал ойрхон байна" гэж байлаа. (Матай 3:2) Үүний дараа олон хүмүүс "гэмээ гэмшсэн" бөгөөд Иохан тэднийг Иордан Голд баптисм хүртээв. Та эндээс хүмүүс зүрх сэтгэлдээ Есүсийг хүлээн авахаасаа өмнө гэмээсээ эргэнэ гэсэн (гэмших) хүсэлтэй байх ёстой гэдгийг харж байна.

Та бид нар өөрсдийн гэм нүгэл, буруу хандлага, бодол санаа, үйлдлээсээ Бурхан руу эргэх үедээ Бурхан дээр очих "цорын ганц зам" нь Есүс юм байна гэдгийг ойлгож, Түүнийг өөрийнхөө

Хаан Эзэнээр хүлээн авахад бэлэн болдог. Иоханы усан баптисм нь хүмүүсийг гэмээс нь угааж цэвэрлэхийг харуулсан бол Есүсийн Ариун Сүнсний баптисм нь галаар биднийг гэмээс ариутгаж, (Матай 3:11,12) бидэнд зөвт байдлын шинэ амьдралыг өгөхийн тулд байсан юм. (Христ Өөрөө бидний дотор амьдардаг).

*Та Бурханы өмнө гэмшиж байсан уу?*

### **Бурханы Хурга болох Есүс.**

Изриалийн ард түмэн Бурхантай харилцахад хурга ямар чухал болохыг мэддэг байлаа. Хэдэн зууны тэртээ Изриалийн үр удам Египетийн боолчлолд байх үед Бурхан Өөрийнхөө хүмүүсийг чөлөөлөхийн тулд Фараоны зүрх сэтгэлд ажлаа хийжээ. Бараг 2 сая гаруй хүмүүсийг чөлөөлж явуулахыг Фараонаар зөвшөөрүүлэхийн тулд Бурхан 10 гамшигийг бий болгожээ. Хамгийн сүүлчийн бөгөөд аймшигтай гамшиг нь Эзэн Египетийн газар нутаг дээгүүр өнгөрөхөд тэнд байгаа ууган хүүхдүүд нэг шөнийн дотор үхэх ёстой байлаа.

Харин энэ гамшигт өртөхгүй байх ганцхан арга зам байсан юм. Энэ нь Бурханы тушаалыг дуулгавартай дагасан бүх гэр бүлийн хүүхэд эсэн мэнд үлдэх байлаа.

Бурхан тэдэнд ямар ч сэвгүй хурга нядлаад, цусыг нь хаалганыхаа хажуу болон дээд талд нь түрхэхийг тушаажээ.

Бурхан тэр шөнө хаалган дээрээ цус түрхсэн айлыг хараад, Тэр тэдний "дээгүүр нь өнгөрч" тэднийг үхлийн гамшиг устгасангүй. Ямар гайхамшигтай төлөвлөгөө вэ! Бурханы шүүлт хаалганыхаа тотгонд цус түрхсэн айлын "дээгүүр нь өнгөрөөд" явсан тэр цагаас хойш т үүнийг дурсамж болгон Изриалын ард түмэн жил бүр



“Дээгүүр өнгөрөх” баярыг тэмдэглэсээр ирсэн. (Энэ түүхийг Египетээс гарсан нь 12:1-42-т үзэж болно).

Есүсийг энэ дэлхийн хүмүүсийн өмнө Бурханы Хурга гэж танилцуулсан нь ямар гайхалтай вэ! Тэрээр ямар ч өө сэвгүй, гэм нүгэлгүй төгс хурган тахил болон ирсэн бөгөөд ингэснээр Түүний урссан цус бид бүхний зүрх сэтгэлийн хаалган дээгүүр урсаж, Бурханы шүүлт бидний гэм нүглийн “дээгүүр өнгөрсөн” юм. Еврей 9:22 бидэнд хэлэхдээ: “...цус урсгахгүйгээр ямар ч уучлал байхгүй ажээ”. Левит 17:11 дээр: “... цус бол амийн төлөө эвлэрүүллийг хийдэг” гэж байдаг. Олон жилийн турш тахилд өргөгдсөн бүхий л хурганууд нь Есүсийг онцлон заасан бөгөөд Тэр Бурханы Хурга болж, Түүнийг Аврагчаа болгон хүлээн авсан хүн бүрийн зүрх сэтгэлийн хаалган дээр Өөрийн цусаа урсгахаар иржээ. “Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Миний үгийг сонсоод, Намайг илгээгч Түүнд итгэгч нь мөнх амьтай болох бөгөөд хэзээ ч яллагдахгүй. Харин үхлээс өнгөрч амь руу шилжинэ. (Иохан 5:24)

Исаиа 53:7 дээр “ Тэрээр алагдахаар хөтлөгдөх хурга шиг” гэж хэлжээ. Есүс энэ дэлхийн гэмийн төлөө нас барсан. Тэрээр Бурханы Хурга болон ирээд таны төлөө цусаа урсаж, таны бүх гэм нүглийг авсаных нь төлөө та юунд талархахгүй байна вэ? Бурхан энэ цусыг хараад бидний ямар ч гэм нүглийг бус, харин эдгээрийг Өөртөө тээн бидний өмнөөс шийтгэл амссан Христийн төгс тахилыг хардаг. Бурханыг магтагун!

*Та гэрийн дарлалаас чөлөөлөгдөхийг хүсэж байна уу?*

*Тэгвэл Христийн цусанд хүч чадал, хүч чадал бий.*

*Та муу ёрын хүчийг ялахыг хүсэж байна уу?*

*Тэгвэл Христийн цусанд гайхалтай хүч чадал бий.*



**ЦАГААТГАЛ гэдэг нь Бурхантай хамт Нэг болохыг хэлж байгаа юм. Учир нь Есүсийн цус биднийг гэм нүглээс маань цэвэрлэдэг.**

### ТҮҮХ 3. ЕСҮСИЙГ ТАНЬЖ МЭДЭХ НЬ.



John 1:35-49

Дараа өдөр нь Иохан хоёр шавьтайгаа дахиад л зогсож байлаа. Есүсийн явж байхыг тэр хараад Бурханы Хургыг харагтун! гэсэнд хоёр шавь нь түүний хэлэхийг сонсоод Есүсийг дагав. Есүс эргэж тэдний дагаж байгааг хараад тэднээс

- Та нар юу эрнэ вэ? гэж асуусанд, тэд Түүнд

- Рабби (орчуулбал Багш аа), Та хаана буудаллаж байна вэ? гэв.

Есүс тэдэнд

- Ир, та нар харна гэж айлдсанд тэд Түүний буудаллаж байгаа газарт очиж үзээд, тэр одор Түүнтэй хамт буудаллав. Учир нь тэгэхэд ойролцоогоор аравдугаар цаг болж байлаа. Иоханы хэлснийг сонсоод Есүсийг дагасан хоёрын нэг нь Симон Петрийн дүү Андрей байжээ. Андрей эхлээд өөрийн ах Симоныг олоод, түүнд - Бид Мессиаг (грекээр Христ) оллоо гээд, түүнийг Есүс уруу авчрав. Есүс түүн уруу хараад Симонд

- Чи бол Иоханы хүү Симон байна. Чамайг Кеф (грекээр Петр) гэж нэрлэх болно гэлээ. Дараа өдөр нь Есүс Галил уруу явахаар завдан байхдаа Филиппийг олоод, түүнд - Намайг дага гэв. Филип, Андрей, Симон нарын хот болох Бетсайдаас иржээ. Филип Натанаелийг олоод

- Бид Мосегийн Хуульдаа бичсэн болон эш үзүүтэгчдийн бичсэн тэр хүн болох Иосефийн хүү, Назарийн Есүсийг оллоо гэсэнд Натанаел Түүнд

- Назараас ямар нэгэн сайн юм гарч чадна гэж үү? гэхэд, Филип

- Ирж харчлаа гэв. Есүс Өөр уруу нь ирж яваа Натанаелийг хараад, түүний тухай

- Дотроо заль мэхгүй, жинхэнэ Израиль хүнийг харагтун гэж айлдав. Натанаел Есүсээс

- Та намайг яаж мэднэ вэ? гэж асуухад Тэр

- Филип чамайг дуудахаас өмнө, иижрийн модны дор байхад чинь Би чамайг харсан гэлээ. Натанаел

- Рабби, Та бол Бурханы Хүү мөн. Та бол Израилийн Хаан мөн гэж Түүнд хэлэв.



## Ирээд Үз.

Иохан “Бурханы Хургыг харагтун” гэж хэлэхэд түүний хоёр дагалдагч нь Есүсийг мэдэхийн тулд Түүнийг ихэд сонирхож байлаа. Тэд бүр гэрийг нь олж очихоор шийдэв. Есүс тэднийг урин “Ирээд үзэгтүн” гэв. Есүс тэдэнтэй ямар гайхалтай яриа өрнүүлснийг та төсөөлж байна уу! Тэд Есүсээс маш их зүйлсийг сурсан байх ёстой. Учир нь нэн удалгүй уг хоёр эрчүүдийн нэг болох Андрей өөрийн ах Петрт “Бид Мессиаг оллоо” гэж хэлэв!

Мессиа гэдэг нь “тослогдсон Нэгэн” гэсэн утгатай. Энэ хүн нь Изриалийг удирдах Бурханаас илгээгдсэн эш үзүүлэгч, тахилч эсвэл хаан байж болно. Хуучин Гэрээний үед олон эш үзүүлэгчид нэгэн “онцгой хүн” ирнэ гэдгийг зөгнөж байжээ. Мосе хүртэл Түүний тухай ингэж бичсэн байна. Бурхан Мосед хандан “**Би тэдний ах дүү нарынх нь дундаас чам шиг нэгэн эш үзүүлэгчийг гаргаж, Өөрийнхөө үгийг тэдний аманд тавина. Миний тушаах бүхнийг тэр тэдэнд хэлнэ**” (Дэд хууль 18:18). Тиймээс Есүс тэдэнд “**Эцэгийн Надад зааснаар Би эдгээрийг ярьдаг**” (Иохан 8:28б). Тэд хичнээн их баярласан бол!

Та Есүсийг үнэхээр сонирхож байна уу? Түүний тухай илүү их зүйл мэдэхийг хүсэж байна уу? Та Есүс хэн юм бол гэж гайхаж байна уу? Тэгвэл өнөөдөр Есүс танд “Ир тэгээд үз” гэж хэлж байна. Хайснаар ямар нэг юм олддог. Есүс “**Хай, тэгвэл олдоно**” (Матай 7:7) гэж хэлсэн байдаг. Хэрэв та Есүс дээр *ирвэл* Түүнийг *харах* болно! Хэрвээ та Есүстэй цаг өнгөрөөж, Өөрийнхөө үгээр дамжуулан тантай ярихыг нь зөвшөөрөх юм бол Тэр танд үнэхээр Өөрийгөө хэн болохыг харуулна. Та өөрийнхөө төлөө Түүнийг таньж мэдэж чадна гэсэн үг! “**Би тэдэнд Намайг мэдэх зүрхийг өгнө. Учир нь Би бол ЭЗЭН. Тэд Над руу бүх зүрх сэтгэлээрээ буцаж ирэх тул, тэд Миний хүмүүс, Би тэдний Бурхан болно.** (Иеримиа 24:7)

## Есүсийн Тухай Гэрчлэл.

Есүс дээр ирээд Түүнийг хэн бэ гэдгийг мэдсэн хүн бусдад Түүний тухай ярьж өгөхийг хүсэх хэрэгтэй! Есүс биднийг Өөрийнх нь тухай мэдэж байгаа зүйлсээ бусадтай хуваалцаасай гэж

хүсдэг. Та Түүний найзын хувьд бусад хүмүүсийг "Ирээд Үз" гэж хэлж болно. Та Есүсийг мэддэг, мөн Түүнээс суралцдаг бол энэ сайн мэдээг бусадтай хуваалцаж байна уу?

**Таны хувьд Есүс хэн бэ гэдгийг доор бичнэ үү:**

---

---

Та өнөөдөр өөрийн гэрчлэлээ бусадтай хуваалцах боломж гаргаж өгөхийг Бурханаас гуйгаарай.

Ингэснээр дахин нэг хүн "ирж үзэж" чадна.

#### **ТҮҮХ 4. ЕСҮС ГЭРЛЭЛТЭНД БАЯР ХӨӨРИЙГ АВЧИРДАГ.**



##### **Иохан 2:1-11**

Гуравдугаар өдөр Галилын Кана хотод нэгэн хурим болоход Есүсийн эх тэнд байв. Есүс болон шавь нар нь бас хуриманд уригдсан байлаа. Дарс хүрэлцэхгүй болоход Есүсийн эх Түүнд - Тэд дарсгүй болов гэлээ. Есүс - Эмэгтэй, Надад ч, танд ч ямар хамаа байна? Миний цаг хараахан болоогүй байна гэжээ. Эх нь зарц нарт хандан - Тэр та нарт юу гэж айлдана, түүнийг нь хий гэв. Тэнд хоёр

эсвэл гурван метр тас багтаамжтай усны зургаан чулуун торх байсан агаад тэдгээрийг нудейчүүдийн ариусгалын ёслолд зориулдаг ажээ. Есүс тэдэнд - Торхнуудыг усаар дүүргэ гэж айлдсанд тэд торхнуудыг амсарт нь хүртэл дүүргэв. Есүс - Одоо утгаад найрын ахлагчид аваачиж өг гэсэнд, тэд аваачиж өгөв. Найрын ахлагч дарс болсон усыг амсаад, тэр дарс хаанаас бий болсныг мэдээгүй учир (харин ус утгасан зарц нар мэдэж байв) шинэ хүргэнийг дуудаж, түүнд - Хүн бүр эхлээд сайн дарсаа гаргаад, хүмүүсийг согтсоны дараа муухнаа гаргадаг. Гэтэл чи сайн дарсаа одоо хүртэл хадгалсан байжээ гэж хэлэв. Есүс Өөрийн тэмдгүүдийн эхлэлийг Галилын Кана хотод үйлдэж, алдраа илэрхийлсэнд шавь нар нь Түүнд итгэсэн юм.



## Хийх Зүйлс.

Дээр түүхэнд гарсан үгнүүдийг ашиглан дутууг нөхөж бич.

1.           Есүсийн           зарц           нарт           хандан  
“ \_\_\_\_\_

\_\_\_\_\_” гэв. (5)

2. Есүс зарц нарт торхнуудыг усаар дүүргэ гэж хэлэхэд тэд торхнуудыг \_\_\_\_\_ нь хүртэл дүүргэв. (7)

### Дуулгавартай Байдал нь Баяр хөөрийн Түлхүүр.

Есүсийн эх нь Түүнийг урьд өмнө хэзээ ч гайхамшиг үйлдэж байхыг хараагүй байж болох юм. Гэвч тэр Есүс туслахаар *ямар нэгэн юм* хийнэ гэдгийг мэдэж байсан. Энэхүү гэрлэх ёслол дээр хэрэглэгдэж байсан дарс нь өнөөдрийн хэрэглэгддэг дарснаас шал өөр. Энэ нь зүгээр л усан үзэмнээс гаргаж авсан маш гоё амттай шүүс байсан юм. Гүйгээд гарчихмаар ямар ичмээр юм бэ!

Магадгүй та итгэгч байх. Та ямар нэг юмыг дуусгадаг уу? Өдөр өнгөрөхөөс өмнө таны тэвчээр алга болчихдог уу? Яг одоо зүрх сэтгэл чинь хайр, баяр хөөргүй хоосон байна уу?

Есүс танд юу хэрэгтэй байгааг чинь мэднэ. Тэр таны амьдралыг гайхамшигтайгаар ивээхийг хүсэж байна! Тэр таныг итгэлийн амьдралдаа баяр хөөр, амар тайван, хайрыг хангалттай авч чадаагүйгээсээ болж ичгүүр дотор амьдраасай гэж хүсдэггүй. Есүс ингэж амласан байдаг:

**“Түүнд итгэгч нь ичгэвтэр байдалд орохгүй”** (Ром 9:33) *Гэвч энд таны мэдэх ёстой нэг нууц байгаа!* Дуулгавартай байдал нь ивээлийн түлхүүр юм. **“Есүс танд юу гэж хэлнэ, та түүнийг нь хий.”** Биднийг дуулгавартай дагах үед Есүс гайхамшигаа үйлддэг. Учир нь бид Түүнд итгэж байгаа эсэхээ дуулгавартай байдлаараа илэрхийлдэг.

Хэрэв хэн нэгэн танд буруу зүйл хийсэн бол та түүнийг (Матай 6:14-15) мартсан уу (Матай 6:20)? Та тэнгэрт баялгийг хурааж байна уу (Матай 6:20)? Магадгүй та Бурханы ажилд юу



ч өгч чадахгүй гэж бодож байж болох юм. Гэвч Есүс таны хэрэгцээг мэднэ. Та дуулгавартай байн Түүнд итгэ. **“Би та нарын төлөө тэнгэрийн цонхыг нээж, та нарын төлөө ивээлийг хальтал асгах эсэхийн талаар намайг одоо үүгээр шалга гэж түмэн цэргийн” ЭЗЭН айлдаж байна.**

(Малахи 3:10б).

Бурхан танд өнөөдөр **“Сүнсээр дүүрэн бай,”** гэж хэлж байна. (Ефес 5:18). Христэд итгэгч хүмүүс Түүний Сүнсээр өдөр бүр дүүрэхгүй л бол баяр хөөрөөр дүүрэн амьдарч чадахгүй.

Магадгүй та Христэд итгэдэггүй хүн байж болох юм. Хэрэв амьдрал чинь уйтгар гунигаар дүүрэн байгаа бол та Есүсийн тушаалыг дуулгавартай даган Түүн дээр ирж Түүнийг бүх л амьдралдаа хүлээж ав. Тэрээр хэлэхдээ: **“Би тэднийг амьтай, бялхсан амьтай байлгахын тулд ирсэн юм.”** (Иохан 10:10).

Зарц нар нь Есүсийг бүрэн дүүрнээр дагасан юм. Тэд торхнуудыг хагас юм уу эсвэл бараг дүүрэн биш харин “амсарт нь хүртэл” дүүргэсэн юм. Бурханыг бүх зүрх сэтгэлээрээ дагах үед баяр хөөр, ивээл нь ирдэг. **“Та нар юу ч хийсэн, хүмүүсийн төлөө бус, Эзэний төлөө мэт чин сэтгэлээсээ хийгтүн. Ингэхдээ та нар Эзэнээс өв залгамжлалын шагналыг хүлээн авна гэдгээ мэдэн хийгтүн. Учир нь чи Эзэн Христэд үйлчилж байгаа юм.** (Колоссай 3:23-24).

Есүсийн танд хэлсний дагуу Түүнийг дуулгавартай дагах хэрэгтэй зүйл бий юу? Яагаад та өнөөдөр хийж болохгүй гэж?

Дагалдагчид Есүс гайхамшиг үйлдэхийг хараад тэдний итгэл өсөж “Түүнд итгэсэн”. Та Бурханы үгийг дуулгавартай дагаж Түүний юу хийхийг харвал таны итгэл ч гэсэн өсөх болно.

Итгэл нь бидний биен дэх булчинтай адил юм. Булчингаа хөдөлгөж, дасгалжуулах тусам энэ нь хүчтэй болдог. Тиймд бүгдээрээ өдөр бүр итгэлийн алхам хийцгээе. **“Зөвт хүн итгэлээр амьдарна”** (Ром 1:17).

**ИТГЭЛ = Бүгдийг орхих, Түүнд итгэх**

## ТҮҮХ 5. ЕСҮС СҮМИЙГ ЦЭВЭРЛЭСЭН НЬ



John 2:13-22

Иудейчүүдийн Дээгүүр Өнгөрөх баяр ойртож байсан бөгөөд Есүс Иерусалим уруу очив. Тэрээр сүмийн дотор үхэр, хонь, тагтаа худалдаалагчид, мөн мөнгө солигчдын сууж байхыг хараад, дээсээр шилбүүр хийж, хонь үхэр бүгдийг нь сүмээс туун гаргаад, мөнгө солигчдын зооснуудыг тараан хаяж ширээг нь хомруулээд, тагтаа худалдаж байсан хүмүүст

- Энэ юмнуудаа зайлуул. Миний Эцэгийн гэрийг наймааны газар болгохоо зогсоо гэлээ. Шавь нар нь “Таны гэрийн төлөөх зүтгэл Намайг залгих болно” хэмээн бичигдсэн байдгийг санацгаав. Тэгтэл Иудейчүүд Түүнд

- Энэ бүхнийг үйлдсэн Та бидэнд ямар тэмдгийг үзүүлэх вэ? гэв. Есүс тэдэнд

- Энэ сүмийг устга. Би үүнийг гурван өдрийн дотор босгоно гэсэнд иудейчүүд

- Энэ сүмийг барихад дочин зургаан жил шаардагдсан байтал, үүнийг Та гурван өдрийн дотор босгоно гэж үү? гэв. Гэтэл Есүс Өөрийн биеийн сүмийн тухай айлдсан ажээ. Тэгээд Есүсийг үхэгдээс амилахад үүнийг Тэр айлдсаныг шавь нар нь санаж, Судар болон Есүсийн айлдсан үгэнд итгэцгээв.

### Есүс Юу Мэдэж Байсан бэ?

“Дээгүүр Өнгөрөх” гэдэг нь ямар утгатай болохыг санаж байна уу? Бид үүний талаар 10-р хуудсан дээр ярилцсан шүү дээ. Есүс дээгүүр өнгөрөх баярыг тэмдэглэхээр Иерусалимд ирэхэд тэндхийн сүм үнэхээр аймшигтай байлаа! Бурханыг магтахад зохистой бус харин хөл үймээн ихтэй худалдааны газар болсон байв. Тэр сүмд Бурханы оршихуй огт байхгүй байсанд Есүс ихэд уурлажээ.

Тухайн үеийн хүмүүс Бурханд тахил өргөх амьтан худалдаж авах хэрэгтэй байсан нь үнэн юм. Харин худалдаачид амьтдыг өндөр үнээр худалдаж хүмүүсийг шулж байсан төдийгүй сүмд энэ үйл ажиллагаагаа явуулж байсан юм! Есүс үүнийг хараад тэднийг бүгдийг нь сүмээс хөөж гаргасанд нь гайхах зүйл алга. Марк 11:17 дээр үүний тухай өгүүлсэн байдаг. Есүс тэдэнд хандан

**“Миний гэр бол бүх үндэстний залбирлын гэр гэж нэрлэгдэнэ гэж бичигдээгүй гэж үү? Гэтэл та нар түүнийг дээрэмчдийн үүр болгожээ” гэв.**

Есүс Иудейн ахлагчдад Өөрийнхөө сүмийг цэвэрлэх эрх нь энэ сүмийг устгаад гурван өдрийн дотор дахин барьснаар батлагдана гэж айлджээ! Иудейчүүд Есүс Өөрийнхөө биеийн тухай ярьж байгааг мэдэхгүй байгаа тул мэл гайхав. Есүс мөн эдгээр Иудейчүүд Өөрийг нь цовдлохыг болон гурван хоногийн дараа Тэрээр үхлээс дахин амилахаа ч мэдэж байлаа.

### **Есүсийн Бие нь Бурханы Сүм байсан.**

Олон жилийн өмнө Соломон хаан “Бурханы алдраар дүүрсэн” маш үзэсгэлэнтэй нэгэн сүмийг бариулжээ. Учир нь Изриалийн ард түмэн хуурамч шүтээнүүдэд үйлчилдэг байсан тул Бурханы алдар сүмийг орхиж, сүм нь устгагдсан байлаа. Сүүлд Бурханыг эргэж ирүүлэх хүсэлтэй хүмүүс байсан учир сүм дахин баригдсан байна. Тэр үед Бурхан: “...бүх үндэстнүүдийн эд баялагтэй (Мессиа) хамт ирнэ. Би энэ өргөөг цог жавхлангаар дүүргэх болно” (Хаггай 2:7). Одоо сүмийг цэвэрлэхээр Есүс ирчихсэн бөгөөд Өөрийн биеийг Бурханы орших сүм болгожээ!

**“ Учир нь бүх Бурханлаг бүрэн дүүрэн нь Түүн дотор биет хэлбэрээр оршдог юм.” (Колоссой 2:9).**


**“...Махан биеэр илчлэгдсэн Тэр нь...” (1Тимот 3:16).**

**“Харагтун, онгон бүсгүй Хүүхэдтэй болж Хүү төрүүлнэ. Тэгээд тэд Түүнийг Иммануел (орчуулбал “Бидэнтэй хамт буй Бурхан”) гэж нэрлэнэ гэсэн юм” (Матай 1:23).**

**“Үүнийг энэ үеийн удирдагчдаас хэн нь ч мэдсэнгүй. Хэрэв тэд үүнийг мэдсэн байсан бол алдрын Эзэнийг**

**цовдлохгүй байх байсан”.** (1 Коринт 2:8). 4-р Түүх дээр Есүс хэрхэн Өөрийн алдрыг илчилж эхэлсэнийг санаж байна уу? (Иохан 2:11). Иудейн ахлагчид ЭЗЭН Бурхан өөрсдийнх нь дунд, Есүсийн бие дотор байгааг болон Есүс Өөрийн сүмийг цэвэрлэх бүрэн эрхтэй гэдгийг нь мэддэггүй байсан.

### **Өнөөдөр Бурханы Сүм Хаана байдаг вэ?**



**“Та нар өөрсдөө Бурханы сүм мөн бөгөөд Бурханы Сүнс та нарын дотор оршдог гэдгийг мэддэггүй юм уу? (1Коринт 3:16).**

Есүс Өөрийг нь үнэхээр зүрх сэтгэлдээ хүлээж авсан хүний дотор Ариун Сүнс болон амьдардаг! Бидний бие махбод бол Түүний орших сүм юм. Ямар гайхалтай вэ?

**“Та нарын бие бол Бурханы та нарт өгсөн, та нарын дотор байдаг Ариун Сүнсний сүм мөн гэдгийг та нар мэддэггүй юм уу? Учир нь та нарыг үнээр худалдан авсан юм. Тиймээс биеэрээ Бурханыг алдаршуулагун”.** (1 Коринт 6:19-20).

Бидний хувьд ариун амьдрах нь ямар чухал юм бэ! Бид биеэрээ гэм хийж болохгүй. Учир нь бид Христийг амьдралдаа хүлээж аваад Түүнтэй холбогдсон тул Түүний өмнө итгэмжит байх хэрэгтэй. Бурхан Өөрийнхөө сүмийг цэвэрлэх бүрэн эрхтэй. Тэрээр бидний амьдралын ямар хэсэг нь Түүнд таалагдахгүй байна түүнийгээ биднээс цэвэрлэж хаях нь Түүний эрх. Тиймд бүгдээрээ Түүгээр үргэлж цэвэрлүүлж байя. Тэр биднийг Өөрийнхөө Үгээрээ дамжуулан биднийг цэвэрлэдэг.

**“Залуу хүн зам мөрөө хэрхэн цэврээр хадгалах вэ?  
Таны үгийн дагуу сахьснаар...”**

(Дуулал 119:9)

**“Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ.”** (1 Иохан 1:9).

**“Харин Тэр Өөрөө гэрлийн (Түүний Үг) дотор байдагчлан бид гэрлийн дотор явбал, бид биетэйгээ нөхөрлөж, Түүний Хүү Есүсийн цус биднийг бүх нүглээс ангижруулдаг ажээ”.** (1Иохан 1:7).

Бурхан зөвхөн тус тусдаа байлгахаар Христийн сүмийг бий болгоогүй харин Христэд итгэгч бид бүгдээрээ “Христийн нэгэн бие” болохоор дуудагдсан”. **“... бид олуулаа Христ дотор нэг бие болой”** (Ром 12:5а). **“ Тэр мөн бие болох чуулганы тэргүүн мөн.”** (Колоссой 1:18а).

**“Христ Есүс Өөрөө булангийн Чулуу нь ажээ”.** Түүний дотор бүх барилга хамтдаа нийцэн Эзэн доторх ариун сүм болохоор өсөж байна. Та нар ч гэсэн Сүнс дотор Бурханы орших газар болохоор Христ дотор хамтдаа байгуулагдаж байна. (Ефес 2:20.6 -22 )

Хүн бүр Бурхан дотор амьдардаг бол ямар агуу вэ! Бид бусад Христэд итгэгч хүмүүсээ агуу их хайр энэрлээр хайрлаж халамжлах ёстой. Ийнхүү тэднийг хайрлаж байгаагаараа бид Христийг хайрлаж байдаг.

Бүгдээрээ Паултай хамт үүнийг хэлцгээе!”**Христ одоо ч урьдын адил амиар ч бай, үхлээр ч бай бие дотор минь өргөмжлөгдөх болно”.** (Филиппой 1:20.6).

Бүгдээрээ өөрсдийн биеийг энэ дэлхийн амьдралын хүсэл тааллаар Бурханы алдрыг булингартуулдаг “дээрэмчний үүр” болголгүй харин Бурханы сүм болгож өдөр бүр Түүнтэй ярилцан, Түүний оршихуйг мэдэрцгээе.

## ТҮҮ Х 6. ЕСҮС НЭГЭН УДИРДАГЧИД ЯАЖ ДАХИН ШИНЭЭР ТӨРӨХ ТУХАЙ ХЭЛСЭН НЬ



Иохан 3:1-8, 14-21, 36.

Фарисайчуудын дотор Никодем гэгч хүн хүн байлаа. Тэр Иудейчүүдийн удирдагчдын нэгэн байв. Тэр хүн Есүс дээр шинөөр нрээд Түүнд

- Рабби, Таныг Бурханаас ирсэн Багш гэдгийг чинь бид мэднэ. Учир нь Бурхантай хамт байхгүй л бол, хэн ч Таны үйлддэг тэмдгүүдийг үйлдэж чадахгүй гэв. Есүс хариуд нь

- Үнэнээр үнэнээр Би чамд хэлье. Хэн дээрээс эс төрнө, тэр хүн Бурханы хаанчлалыг үзэж чадахгүй гэхэд Никодем Түүнд

- Настай болсон атлаа хүн хэрхэн төрөх билээ. Хүн эхний хэвлийд хоёр дахиа өрж, төрж чадна гэж үү? гэлээ. Есүс

- Үнэнээр, үнэнээр Би чамд хэлье. Хэн ус болон Сүнснээс эс төрнө,

тэр хүн Бурханы хаанчлалд орж чадахгүй. Махан биеэс төрсөн нь махан бие, Сүнснээс төрсөн нь сүнс болой. “Чи дээрээс төрөх ёстой” гэж Би чамд хэлсэнд чи бүү гайх. Салхи дуртай газраараа үлээдэг. Чи дууг нь сонсовч, салхийг хаанаас ирж, хааш оддогийг чи мэддэггүй. Сүнснээс төрсөн хүн бүр үүнтэй адил байдаг гэж айлдав.

Мосе цөлд тэр могойг өргөсөн шиг, Хүний Хүү ч бас өргөгдөх ёстой. Энэ нь Түүнд итгэгч хүн бүрийг мөнх амьтай байлгахын тулд билээ.

Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм. Бурхан Өөрийн Хүүгээ ертөнцийг яллахын тулд биш, харин Түүгээр дамжуулан ертөнцийг аврахын тулд ертөнц рүү илгээсэн билээ. Түүнд итгэдэг хүн яллагдахгүй. Харин үл итгэдэг хүн аль хэдийн ялагдсан. Учир нь тэр хүн Бурханы цорын ганц Хүүгийн нэрд итгээгүй юм. Тэрхүү ялалт ийм билээ. Гэрэл ертөнцөд нрэхэд хүмүүсийн үйлс бузар муу учир тэд харанхуйг гэрлээс илүү хайрласан юм. Учир нь өөрийнх нь үйлс ил гарчих вий гэж бузрыг үйлдэгч хүн бүр гэрлийг үзэн ядаж, гэрэл уруу гарч нрдэггүй. Харин

үйлс нь Бурханы дотор үйлдэгдсэн гэдгийг ил харуулахын тулд үнэнийг үйлдэгчид гэрэл уруу ирдэг гэлээ.

Хүүд итгэдэг хүн мөнх амьтай. Харин Хүүд итгэдэггүй хүн мөнх амийг үзэхгүй. Харин Бурханы уур хилэн тэр хүн дээр байдаг.

### Хийх Зүйлс.

А. Дээрхи түүхээс зөв үгийг авч хоосон зайг бөглө.

1. Никодем Иудейчүүдийн нэгэн \_\_\_\_\_ байв. (1-р ишлэл).

Тэр хүн Есүс дээр \_\_\_\_\_ ирээд...(2).

(Есүс "баян ядуу, мэдлэгтэй мэдлэггүй гэж ялгалгүй бүгдийг нь хайрладаг).

2. Никодем Есүсийг Бурханаас ирсэн \_\_\_\_\_ гэж бодож байсан. ... (2).

3. Есүс Никодемд "Бурханыг хаанчлалыг үзэхийг хүсэж буй хүнд \_\_\_\_\_ т \_\_\_\_\_ ёстой" гэж хэлэв.

4. У \_\_\_\_\_ болон с \_\_\_\_\_ төрж чадаагүй хүн Бурханы хаанчлалд орж чадахгүй (5).

5. Махан биеэс төрсөн нь \_\_\_\_\_ (5):

[ "Махан бие" гэдэг нь зөвхөн бидний бие махбод биш харин бидний өөрсдийн маань дотор байдаг бузар хүслүүд юм. (Ром 8:8,9).]

6. Сүнснээс төрсөн нь \_\_\_\_\_ болой (6).

[ Бид энэ ертөнцийн эцэг эхээс төрж гарахдаа мөн ертөнцийн бие махбодтой төрөн гардаг. Харин бид Бурханы сүнсээр төрөх юм бол Бурханаас ирэх сүнслэг зүйлсийг ойлгох чадвартай, амьд сүнстэй болон төрдөг. (1Коринт 2:12, 14).]

7. \_\_\_\_\_ цөлд тэр \_\_\_\_\_ өргөсөн шиг Хүний Хүү ч (Есүс) бас өргөгдөх (загалмай дээр цовдлогдох) ёстой. (14).

8. Бурхан Есүсийг илгээсний шалтгаан нь Тэрээр ертөнцийг үнэхээр \_\_\_\_\_ учраас юм. Есүст \_\_\_\_\_ хэн боловч м \_\_\_\_\_, харин мөнх \_\_\_\_\_ болно (16).

9. Бурхан Өөрийн Хүүгээ ертөнцийг я \_\_\_\_\_ тулд биш (гэвч Тэр нэгэн өдөр шүүх болно), харин Түүгээр дамжуулан ертөнцийг а \_\_\_\_\_ тулд ертөнц уруу илгээсэн билээ (17).



10. Түүнд итгэдэг хүн я \_\_\_\_\_. Харин үл \_\_\_\_\_ хүн аль хэдийн ялагдсан (18).

11. Тэрхүү я \_\_\_\_\_ нь ийм билээ. [Ялалт гэдэг нь Бурханаас тусгаарлагдан мөнхийн шийтгэл амсахыг хэлж байгаа юм]. Гэрэл ертөнцөд ирэхэд хүмүүсийн үйлс \_\_\_\_\_ учир тэд х \_\_\_\_\_ г \_\_\_\_\_ илүү хайрласан юм.

12. ... \_\_\_\_\_ үйлдэгчид гэрэл уруу ирдэг (21). [Энэ нь *сайныг* үйлдэгчид гэрэл уруу ирдэг биш юм]. “**Сайныг үйлддэг хүн алга. Бүр ганц ч алга**” (Ром 3:12). Үнэнийг үйлддэг хүн нь өөрийнхөө гэмийг хүлээн зөвшөөрч Бурханы ариусгалыг хүлээж авдаг хүн юм. “**Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл, Тэрээр итгэмжит зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ.** (1Иохан 1:9).

Б. 6-р мөрөнд дурдагдсан ишлэлүүдийг Библиэс олгоод доогуур нь зур (эсвэл жижигхэн цаасан дээр бич).

**Иохан 3:16 ба Иохан 3:36** зэрэг ишлэлүүдийг цээжил.

### **Дахин Төрөх гэдэг нь Ямар Утгатай вэ?**

Дахин төрнө гэдэг нь “дээрээс төрж” илүү дээр өөр амьдралаар амьдарч эхлэнэ гэсэн үг юм.

Биеийн төрөлт нь хүн төрөлхтний гэр бүлд нэгэн гишүүнийг нэмдэг бол Сүнсний төрөлт нь Бурханы гэр бүлд нэгэн шинэ хүнийг нэмдэг. Сүнс хүмүүсийн дотор ажилладаг, харин бид гаднаа илрэх өөрчлөлтийг нь хардаг. Жишээлбэл: Хулгай хийдэг хүн дахин хулгай хийхгүй байх. Энэ нь салхитай адил юм. Бид салхийг харж чаддаггүй боловч салхи юу хийснийг нь харж чаддаг.

Бурханы сүнсээр төрөөгүй хүний сүнс нь “үхсэн” байдаг (Ефес 2:1, 5). Гэмийн ариусгал нь эхлээд Христийн үхэл буюу бид хуучин амьдралаа үхүүлсэнээр ирдэг. Харин дараа нь Сүнс Христийн дахин амилалтаар дамжуулан биднийг амьд болгож шинэ амьдралыг өгдөг.

Өөрөөр хэлвэл Бурханы хаанчлалд орохын тулд энэ хоёр нь зайлшгүй хэрэгтэй юм. Ариун Сүнс (Есүс Өөрөө Сүнс болон

ирж буй юм) бодитоор бидний биед орж ирэх үед Шинэ төрөлт бий болдог. **“Хэрэв хэн нэгэнд Христийн Сүнс байхгүй бол тэр Түүнийх биш”** (Ром 8:9 б).

Ийнхүү бид Христийн чанар (2Петер 1:4) болох зөв хандлага, зөвийг хүсэх шинэ хүч болон Судрыг ойлгох шинэ оюун ухааныг өвлөн авдаг.

Та Никодемтэй адил байна уу? Магадгүй та үргэлж шашинлаг байдаг нэгэн байх. Эсвэл бүх хуулийг дагадаг хүн ч юм уу. Бүр удирдагч ч байж болох юм. Гэвч та Бурханы Ариун Сүнсээр дээрээс дахин төрж байж л шинэ бүтээл болдог. **“Хэрэв хэн нэгэн Христ дотор байвал тэр хүн шинэ бүтээл мөн. Хуучин юмс нь өнгөрчээ. Харагтун шинэ болсон байна”**(2Коринт 5:17). Хэрвээ та “дахин төрөөгүй” бол Никодемтэй адил яг одоо яагаад Есүс уруу ирж болохгүй гэж?

Есүсийг өөрийнхөө амьдралд орж ирэхийг Түүнээс гуй, тэгвэл та шинэ амьдралтай болж Бурханы гэр бүлийн нэгэн хэсэг болно. **“Хүүтэй хүнд амь бий. Бурханы Хүү байхгүй хүнд амь байхгүй”** (1Иохан 5:12).

### **Мосе Цөлд**

Олон жилийн тэртээ Изриалийн хүүхдүүд Мосегийн удирдлага дор цөлд амьдарч байхдаа тэд хэдэрлэцгээн Бурханы болон Мосегийн эсрэг буруу зүйлсийг ярьцгааж байлаа. Бурханаас тэдэнд бэлтгэсэн замын төлөө тэд гомдоллоцгоосон тул Бурхан тэднийг хазуулахаар тэдний дунд галт могойнуудыг илгээв. Олон хүмүүс үхсэн тул ард түмэн Мосегийн өмнө ирж гэмээ гэмшиж, могойнуудыг зайлуулж өгөхийг Бурханд зуучлан залбирч өгөөч хэмээн тэд Мосегээс гуйцгаажээ. Бурхан тэдний гуйлтыг сонсож нэгэн сонин арга замаар хариулав. Тэрээр Мосед нэгэн хүрэлээр могой хийж түүнийгээ шонд өлгөхийг тушаажээ. Хүрэл могойг харсан хүн бүр тэр тусмаа могойд хатгуулсан үхлүүт хүмүүс ч түүнийг хараад амьдрах байв. (Энэ түүхийг Тооллого 21:4-9-өөс харж болно).

Гэм нь яг галт могойн хазалттай адил. Бидний төлөө гэмийн шийтгэлийг үүрсэн (Тэр Өөрөө хэзээ ч гэм үйлдээгүй) Есүсийг



харахгүй бол бид бас адилхан үхэх болно. Олон Изриалийн ард түмэн цөлд үхсэн бөгөөд харин тэднээс зөвхөн могойг харсан хүмүүс нь л эдгэрсэн юм. Мөн Есүс Никодемд Өөрийг нь харж, шинэ амьдралыг хүлээн авахгүй бол шийтгэгдэх болно гэдгийг сануулжээ.

Хүмүүс “үхсэн” могойг хараад амьдарсан. Үүнчлэн хүмүүс дэлхийн гэмийг Өөртөө үүрэн загалмай дээр цовдлогдсон Нэгэнийг харах ёстой. (Иохан 12:32, 33) Хар тэгээд амьдар! Хүмүүс “хэрхэн” эдгээж буйг нь мэдэхийн тулд хүрэл галт могойг ажиглах шаардлагагүй байсан. Тэд бүгд зөвхөн итгэлээрээ дуулгавартай дагах ёстой байсан бөгөөд тэд үүнийг хийсэн юм.

**Хар тэгээд амьдар, ах дүү нар минь амьдар!  
Хараагаа Есүс уруу чиглүүлэн одоо амьдар;  
Түүний Үгэнд хэлдэг шүү дээ, Халлелүүяа!  
Та зөвхөн “хараад амьдарна” гэсэн үг юм шүү дээ  
Халлелүүяа!**

### **Гэрэлд Ирэх**

Бид Христэд итгэх үед бидний гэм нүгэл илчлэгддэг. Учир нь Есүс бол жинхэнэ гэрэл юм. (Иохан 1:9). Харанхуй үнэнийг нуудаг, харин гэрэл нь аливаа зүйл нь жинхэнээсээ юу болохыг харуулдаг.

Бурханы гэрэлд ирэхгүй байхаар шийдсэн нэгэн нь Бурхан өөрийг нь өөрчлөхийг хүсэж буйг хүлээн зөвшөөрөлгүй өөрийн гэм нүглээ нуухаар шийдсэн хүн юм. Гэмт хүн нь *аль хэдийнэ* тамд унахаар хөтлүүлсэн нэгэн бөгөөд тамаас зугтахын тулд түүнд Есүс хэрэгтэй. Есүст итгээгүй хүмүүс нь одоо Бурханы уур хилэнгийн дор (36-р ишлэл) байгаа бөгөөд Есүсийг хүлээн

авсан хэн боловч Бурханы мөнхийн амьдрал буюу тэнгэрт байгаатай адил амьдралыг эхэлдэг. “Бурхан бол гэрэл, мөн Түүний дотор харанхуй байхгүй гэдэг нь бидний Түүнээс сонссон мэдээ бөгөөд та нарт тунхаглаж байна. Хэрэв бид Бурхантай нөхөрлөдөг гэж яриад, харанхуй дотор алхаж байвал, бид худал хэлж, үнэнийг үйлддэггүй ажээ. Харин Тэр Өөрөө гэрлийн дотор байдагчлан бид гэрлийн дотор явбал, бид бие биетэйгээ нөхөрлөж, Түүний Хүү Есүсийн цус биднийг бүх нүглээс ангижруулдаг ажээ(1Иохан1:5-7).


Хэрэв хүн ариун амьдрахыг хүсвэл гэмээ илчилж уучлуулахыг хүсэх хэрэгтэй. Тиймд Христ уруу очно гэдэг нь нэг талаараа амьдрал нөгөө талаар бодит үхэл мөн. Таны хувь тавилан чинь та Христтэй хамт юу хийсэн бэ гэдэг дээр чинь тулгуурлах болно. Таны гэрэл дотор юу хийснээс чинь шалтгаалан хувь тавилан чинь шийдэгдэнэ гэсэн үг юм. Та гэрэл уруу ирэх үү? Эсвэл үүнээс нуугдах юм уу?



Би Есүсээр дамжуулан  
шинэ амьдрал хүлээн авлаа.

Нэр: \_\_\_\_\_

өдөр: \_\_\_\_\_



**ИТГЭЛ + БУРХАНЫ ҮГ (ЕСҮС) = МӨНХИЙН АМЬДРАЛ**

## ТҮҮХ 7. ЕСҮС АМИЙН УС ӨГӨВ



Иохан 4:5-42

Ингээд Тэр Самарийн Сухар гэдэг хотод ирлээ. Энэ хот нь Иаков өөрийн хүү Иосефтоо өгсөн газрын ойролцоо байв. Иаковын худаг тэнд байжээ. Аянд ядарсан Есүс худгийн дэргэд сууж байв. Энэ нь зургадугаар цагийн үед байлаа. Самарийн нэгэн эмэгтэй ус татахаар тэнд ирэхэд Есүс түүнээс - Надад уух юм өгөөч гэж гуйв. Энэ үед шавь нар нь хүнс худалдан авахаар хот руу явсан байлаа. Өнөөх Самари эмэгтэй - Та Иудей хүн байж Самари эмэгтэй надаас яагаад уух юм гуйна вэ? гэв. (Учир нь иудейчүүд самаричуудтай харьцадаггүй байжээ.) Есүс түүнд - Хэрэв чи Бурханы бэлгийг болон “Надад уух юм өгөөч” гэж байгаа хүн хэн болохыг мэдсэнээн бол чи Түүнээс гуйхад Тэр чамд амийн усыг өгөх байсан гэж айлдсанд, тэр Түүнд

- Эзэн, энэ худаг гүн, Танд утгах юм юу ч алга. Гэтэл та амийн усыг хаанаас авах вэ? Та бидний өвөг Иаковаас агуу гэж үү? Тэр энэ худгийг бидэнд өгсөн юм. Иаков болоод түүний хөвгүүд ч, мал сүрэг нь ч эндээс ундаалсан гэв. Есүс - Энэ уснаас уух хүн бүр дахин цангана. Харин өөрт нь Миний өгөх уснаас хэн ч хэзээ ч цангахгүй. Харин Миний өгөх ус тэр хүний дотор аминд хүртэл оргилох булаг болно гэхэд, эмэгтэй Түүнд - Эзэн, тэр усаа надад өгөөч. Тэгвэл би цангахгүй. Ус утгахаар энд ирэх шаардлагагүй болно гэв. Есүс - Явж, нөхрөө дуудаад энд ир гэж айлдав. Тэр - Тэр Би нөхөргүй гэсэнд Есүс - “Би нөхөргүй” гэж чи зүйтэй хэлэв. Учир нь чи таван нөхөртэй байсан бөгөөд одоо чамтай байгаа хүн нөхөр чинь биш тул чи үнэнээр хэлэв гэв. Эмэгтэй - Эзэн, би Таныг эш үзүүлэгч болохыг харлаа. Бидний өвөг дээдэс энэ уулан дээр мөргөдөг байсан. Харин та нар мөргөх ёстой газар бол Иерусалимд байна гэгцгээдэг шүү дээ гэв. Есүс - Эмэгтэй, Надад итгэ. Та нар энэ уулан дээр ч биш, Иерусалимд ч биш, Энцэгт л мөргөх цаг ирж байна. Та нар мэдэхгүй юманд мөргөдөг бол, бид мэддэг юмандаа

мөргөдөг. Тиймээс ч аврал нудейчүүдээс гарна. Харин үнэн мөргөгчид нь сүнсээрээ, үнэнээр Эцэгт минь мөргөх цаг ирж байгаа бөгөөд одоо ирчихээд байна. Учир нь Эцэг Өөрт нь ийнхүү мөргөгчдийг эрж байна. Бурхан бол сүнс, Түүнд мөргөгчид нь сүнсээрээ, үнэнээр мөргөх ёстой гэж айлдлаа. Тэр эмэгтэй Есүст - Христ гэгч Мессиа ирэхийг би мэднэ. Тэр Нэгэн ирэхдээ бүх зүйлсийг бидэнд мэдүүлж өгнө гэв. Есүс Түүнд

- Чамтай ярьж байгаа Би бол Тэр мөн гэж айлдав.

Тэр үед шавь нар нь ирээд, Түүнийг нэгэн эмэгтэйтэй ярьж байгаад гайхсан боловч хэн нь ч

- Та юу хайна вэ? эсвэл

- Та түүнтэй юу ярилцана вэ? хэмээн асуусангүй. Тэгтэл өнөөх эмэгтэй усныхаа савыг орхин хот руу явж, хүмүүст

- Миний үйлдсэн бүхнийг надад хэлсэн хүнийг ирж үзэгтүн. Тэр Христ биш үү? гэсэнд, хүмүүс хотоос гарч Есүс уруу очиж байв. Энэ үед шавь нар нь Есүсээс

- Рабби, зооглооч гэлээ. Харин Тэр тэдэнд

- Та нарын мэдэхгүй хоол Надад бий гэв. Шавь нар нь

- Түүнд хэн ч идэх юм авчирж өгоогүй биз дээ? хэмээн оор хоорондоо ярилцав. Есүс тэдэнд

- Миний хоол бол Намайг илгээсэн Түүний хүслийг үйлдэн, ажлыг нь гүйцэлдүүлэх явдал мөн. Та нар “Ургац хураалт болтол

дөрвөн сар байна” гэж хэлдэг биш үү? Үзэгтүн, Би та нарт хэлье. Хараагаа дээшлүүлж, талбайг харагтун. Учир нь талбай цайрч хураалтанд бэлэн болжээ. Хураагч хөлсөө хүртэж, мөнх амийн үрийг цуглуулж байна. Тийнхүү тариачин тариа хураагчийн хамт баярлах болно. Учир нь “Нэг нь тарьж, нөгөө нь хураана” гэсэн үг үнэн болох нь энд харагдаж байна. Та нарын хөдөлмөрлөөгүй юмыг хураалгахын тулд Би та нарыг илгээв. Өөр хүмүүс хөдөлмөрлөсөн бөгөөд та нар тэдний хөдөлмөрт оролцсон болно гэж айлдав.

- Өнөөх эмэгтэйн “Миний үйлдсэн бүхнийг Тэр надад хэлсэн” гэж гэрчилсэн үгнээс болж тэр хотоос Самарийн олон хүн Есүст итгэжээ. Тиймээс Самаричууд Есүс уруу очиж, өөрсөдтэйгөө хамт байхыг гуйсанд, Есүс тэнд хоёр хонов. Есүсний үгнээс нь болж улам олон хүн итгэв. Тэд мөнөөх эмэгтэйд

- Одоо бид чиний ярьсанд бнш, харин өөрсдөө сонсоод, энэ Нэгэн бол үнэхээр ертөнцийн Аврагч болохыг мэдлээ гэв.



### Хийх Зүйлс.

А. Дээрхи түүхийг уншаад асуултанд хариул.

1. Есүст ямар мэдрэмжтэй байсан бэ? Тэр үнэхээр хүн байсан уу? (6-р ишлэл)

---

2. Есүс Самари эмэгтэйд юу гэж хэлсэн бэ? (7)

---

3. Есүс түүнтэй уулзахад тэр эмэгтэй яагаад гайхсан бэ? (9)

---

[Самаричууд нь Еврейчүүдийн үр удам ба харь хүмүүс тэй гэрлэсэн Еврей хүмүүс юм. Тэд Изриалийн Бурханыг хүндэлдэггүй харин хуурамч шүтээнүүдэд мөргөдөг байв. Жинхэнэ Еврейчүүд Иерусалимд өөрсдийн сүмийг барих үед Самаричууд тэдэнд туслахаас татгалзжээ. Харин Есүс хүн бүрийг сонирхон тэдний хэрэгцээ бүрт анхаардаг байсан бөгөөд Еврей хүний хувьд нийтийн дунд эмэгтэй хүнтэй уулзах нь ёсгүй байсан боловч Тэрээр Самари эмэгтэйтэй ярилцжээ.]

4. Хэрвээ тэр эмэгтэй юу гуйхаа мэдсэн бол Есүс түүнд юу өгөх байсан бэ? (10)

---

5. Худгийн болон Есүсийн өгөх усны хоорондын ялгаа нь юу байсан бэ? (13,14)

---

6. Тэр эмэгэй талаар Есүс юу мэдэж байсан бэ? (18).

---

[Есүс хүн бүрийн нууцаар хийдэг гэм бүрийг мэддэг.]

7. Есүс тэр эмэгтэйд гэмтэй гэдгийг нь ойлгуулах гэж байхад тэр ямар сэдвийг ярианд авчирсан бэ? (20) Тэр хүмүүсийн \_\_\_\_\_ ёстой газрын тухай яриу.

[Самаричууд Геризим ууланд оршдог сүмдээ очиж мөргөл үйлддэг байв. Тэд Хуучин Гэрээний зөвхөн эхний 5 номд итгэдэг байсан юм. Та Бурханы өмнө зохистой байхын оронд "шашны" ярианд дурладаг уу?]

8. Үнэнээр мөргөгчид нь Эцэгт хэрхэн мөргөдөг вэ? (23)

---

[Бурханд үнэнээр мөргөхийн тулд бид Сүнсээр дахин төрөх ёстой.]

9. Есүсийг хэн болохыг нь ойлгосон Самари эмэгтэй юу хийсэн бэ? (28, 29) \_\_\_\_\_

---

10. Есүст ямар хоол байсан бэ? (34)

---

---

11. Самаричууд Есүс хэн байсан гэж итгэдэг вэ? (42).

---

Б. Цээжлэх ишлэл: **Иохан 4:24**

### **Итгэл Хэрхэн Өсдөг вэ?**

Самари эмэгтэй Есүсийн түүнд ярьж өгсөнөөс илүү ихийг мэдэж итгэж хүлээж авахын тулд Түүн дээр дахин ирэх нь сонирхолтой байсан уу? 9-р ишлэл: Эхлээд тэр Есүсийг өөртэй нь элэгсэг ярьж буй еврей хүн гэдгийг мэдсэн. **11-р ишлэл:** Эмэгтэй Есүсийг хүндлэн “Эзэн” гэж дуудсан. **19-р ишлэл:** Есүс түүний тухай их зүйл мэдэж байсан тул эмэгтэй Түүнийг эш үзүүлэгч байх гэж бодсон. **29-р ишлэл:** Тэр эмэгтэй Есүсийг амлагдсан Христ тэгч Мессиа гэдэгт итгэсэн. Есүс Библийн дагуу бидэнтэй ярих тусам бидний итгэл Түүний дотор өсөж байдаг! “Тиймээс итгэл нь сонсохоос, сонсох нь Христийн үгээр ирдэг” (Ром 10:17).

### **Амийн Ус гэж юу вэ?**

Самари эмэгтэй амийн усны тухай сонсоод, арьсан хувингаараа 90 футын гүнзгий Иаковын худгаас дахин ус авахааргүй болох нь гэж бодож байлаа. Гэвч Есүс зүгээр нэг усны тухай биш харин гэмээс тааламж авч хоосон орон зайгаа нөхөх гэж оролдож байдаг зүрх сэтгэлийнх нь цангааг мөнхөд тайлж чадах ханамжын тухай ярьж байсан юм. Түүний ярьж



байсан *амийн* ус нь Бурханаас бэлэг болгон өгсөн мөнхийн амь буюу Түүний амь амьдрал байлаа. Бид Ариун Сүнсээр дүүрэх үедээ баяр хөөр, амар тайвны дүүрэн оргилох булаг бидний дотроос *ундран гарч* буйг мэдэрч чадна!

Самари эмэгтэй энэ усыг хүсэмжилж байсан боловч эхлээд Есүс түүнийг сэтгэлийг нь хатгах хэрэгтэй байсан юм. Учир нь тэр Есүсээс амийн усыг авахаасаа өмнө гэмээ гэмшиж, гэмт амьдралаасаа эргэх хүсэлтэй байх ёстой байсан юм.

### **Энэ Түүхийн Юу нь Бурханы Төлөө Ажиллах Ёстой гэж Заадаг вэ?**

1. Хүн бүр энэ баярын мэдээг сонсоод Христийн авралд итгэх хэрэгтэй. Бид хэн нэгнийг гологдсон юм уу эсвэл үл хүлээн зөвшөөрөгдсөн нэгэн шиг үлдээх ёсгүй. Есүс хэнийг ч голоогүй юм.

2. Энэ дэлхийн сүнсний "талбай" цайраад аль хэдийнэ ургац хураахад бэлэн болчихсон байна. Харин бид эргэн тойрон уруугаа хараагаа өндөрсгөн хичнээн олон хүн жинхэнэ үнэнээр өлсөж, үүнийг хүлээж авахад бэлэн байгааг харах ёстой.


3. Нэг нь тарих хэрэгтэй. (Есүсийн тухай бусдад ярь, суртчилгааны хуудас тараа, Бурханы Үгийг заа). Нөгөө нэг нь хураах хэрэгтэй. (хэн нэгэнд Христийг үнэхээр таниул)

Бид хоёуланг нь хийх хүсэлтэй байх хэрэгтэй бөгөөд тарих, хураах хоёр нь хоёулаа баяр хөөрийг авчирдэг.

4. Өдөр бүр бид Бурханы хүслийг биелүүлж, ажлаа төгсгөх үед хоолноос авч чадахааргүй тийм гайхалтай сэтгэл ханамжыг авдаг.

5. Есүсийн тухай найз нартаа ярьж өгөх нь чухал бөгөөд тэдэнд Есүсийг таньж мэдэхэд нь туслах хэрэгтэй.

## ТҮҮХ 8. ЕСҮС НЭГЭН ТҮШМЭЛИЙН ХҮҮГ ЭДГЭЭВ.



Иохан 4:46-53

Есүс усыг дарс болгож байсан Галилын Кана хотод дахин очив. Хааны нэгэн түшмэл тэнд байсан богөөд түүний хүү нь Капернаумд овчтэй байлаа. Түшмэл Есүсийг Иудейгээс Галилд ирсэнийг сонсоод, Түүн уруу очиж,  
- Ирж, миний хүүг эдгээгээч гэж гуйв.

Учир нь хүү нь үхлийн эрмэг дээр байлаа. Есүс – Хүмүүс та нар хэрвэ тэмдэг, гайхамшгуудыг үзэхгүй бол ер итгэхгүй гэж айлдав. Хааны түшмэл Түүнд,

- Эзэн, хүүг минь үхэхээс омно ирээч гэлээ. Есүс

- Яв. Чиний хүү амьд байна гэхэд тэр хүн Есүсийн айлдсан үгэнд итгээд харихаар явав. Тийнхүү тэрээр буцаж явтал, боолууд нь түүнтэй учирч, хүү нь амьд байгааг дуулгалаа. Түшмэл хүүгээ аль цагт сайжирч эхэлснийг тэднээс асуусанд

- Өчигдөр долдугаар цагт түүний халуун буусан гэв. Тэгээд эцэг нь “Чиний хүү амьд байна” гэж Есүсийн айлдсан цаг яг мон болохыг мэдээд, тэр өөрөө болон бүх гэр бүл нь итгэжээ.

### Бурханы Үгийн Хүч.

Бурхан ямар нэгэн юмыг хэлэх үед энэ нь биелэлээ олдог. Тэрээр тэнгэр газрыг бүтээж, түүн дотор орших бүх зүйлсийг Үгээрээ бий болгосон шиг түшмэлд хандан “Яв, чиний хүү амьд байна” гэж хэлэхэд тэр нь ёсоор нь болсон.

Есүс хэлэхдээ Библи дээр байдаг бүх амлалт биелэлээ олно гэжээ. (Матай 5:18). Та Бурханы Үгэнд итгэдэг үү? Хэрвээ итгэдэг бол дээрхи түүхэнд гарсан хүн шиг итгэлийн үйлдэл хийдэг үү?

Хэрвээ бидний зүрх сэтгэл дотор Есүс амьдарч байгаа бол бидний үг ч гэсэн хүч чадалтай. Марк 11:22, 23 дээр Есүс тэдэнд хариулан “ Бурханд итгэгтүн. Үнэнээр Би та нарт хэлье. Хэн боловч энэ ууланд хандан “Өргөгдөж, тэнгист

хаягдагтун” гэж хэлэхдээ зүрхэндээ эргэлзэлгүй, харин хэлж байгаа нь бүтнэ гэдэгт итгэвэл тэр чинь ёсоор болно.” Бид Бурхан дотор итгэлээр ярихад энэ нь хүчирхэг байдаг. Та ямар хэлбэрээр нь ярьдаг вэ? Урам өгдөг үү, тайвшруулдаг уу, итгэл өгдөг үү эсвэл хайрын үгээр ярьдаг уу?

**Энэ Түүх нь Залбирлын Тухай Юуг Бидэнд Заадаг вэ?**

Есүс өнөөдөр бидний залбиралд хариулдаг уу? Еврей 13:8 бидэнд хэлэхдээ “Есүс өчигдөр ч, өнөөдөр ч, хэвээрээ бөгөөд мөнхөд хэвээрээ байна”. Бид гуйлтаар л Түүний өмнө очих ёстой гэдгээ мэддэг. “Над уруу ирэх хүнийг Би огт хөөж гаргахгүй” (Иохан 6:37.6). Тэр бидэнд “Гуй, тэгвэл та нарт өгнө. Хай, тэгвэл та нар олно. Тогш, тэгвэл та нарт нээгдэнэ” (Матай 7:7).


Дараа нь бид Тэр бидний залбиралд хариулна гэдэгт итгэх ёстой. “Итгэлгүйгээр таалагдана гэдэг нь боломжгүй юм. Учир нь Бурхан уруу ирж буй хүн Тэр байдаг гэдэгт болон Өөрийг нь хайгч хүмүүст Тэр Шагнагч нь болдог гэдэгт итгэх ёстой”. (Еврей 11:6).

Бид Есүсийн өгсөн залбирлынхаа хариултанд сэтгэл хангалуун байх ёстой. Түшмэл Есүсийг өөрийнхөө байшинд очуулахыг хүссэн боловч Тэр очилгүй харин түүнд хандан “Яв, Чиний хүү амьд байна” гэж айлджээ. Есүс таны хүссэн гуйлтанд чинь хариулахгүй байж болох боловч хамгийн сайныг үргэлж таны төлөө хийдэг бөгөөд энэ нь Түүний Үгийн дагуу байдаг.

Итгэл нь бидэнд үргэлж чөлөөлөлтийг авчирдаггүй,(Еврей 11:35-39-ийг судал) харин ямар нэгэн чиглүүлэг болон амар тайвныг өгдөг. “Юунд ч бүү санаа зов. Харин аливаа зүйлд залбирлаараа болон гуйлтаараа талархалтайгаар хүсэлтээ Бурханд мэдүүл. Бүх оюун ухаанаас дээгүүрх Бурханы амар тайван нь Христ Есүс дотор та нарын зүрх бодлыг тань хамгаална”. (Филиппой 4:6,7).

Таныг Бурханд итгэх үед Түүний хүч чадал таны итгэлийг хүчирхэгжүүлдэг бөгөөд таны гэр бүлийн хүмүүс хүртэл түшмэлийн гэр бүл бүгдээрээ Бурханд итгэсэн шиг Түүнд итгэх болно.

## ТҮҮХ 9. ЕСҮС ӨВЧТЭЙ ХҮНИЙГ ЭДГЭЭВ.



Иохан 5:1-9, 14-18

Үүний дараа нь иудейчүүдийн нэгэн баяр болж байхад нь Есүс Иерусалем уруу очив. Иерусалемийн хонинны хаалганы дэргэд еврейгээр Бегзада гэдэг цөөрөм байдаг. Тэнд таван саравч байдаг бөгөөд тэдгээрийн дотор өвчтэй, сохор, доголон, хатингар олон хүн хэвтэж байлаа. [Тэд ус хөдлөхийг хүлээж байв. Учир нь Эзэний тэнгэр элч тодорхой үед цөөрөмд бууж, усыг хөдөлгөхөд, ус хөдөлсөний дараа түрүүлж орсон хүн ямар ч өвчнөөр өвчилсөн байлаа ч өвчнөөсөө ангижирдаг байжээ.] Гучин найман жил өвчтэй байсан нэгэн хүн тэнд байв. Тэнд хэвтэж буй хүнийг Есүс

харж, удаан хугацаагаар тийм байсныг нь мэдээд, түүнээс

- Чи эрүүл болохыг хүсэж байна уу? гэж асуухад моноох өвчтэй хүн

- Ээзи, ус хөдлөх үед намайг цөөрөмд оруулах хүн байдаггүй. Харин намайг очсоор байтал өөр хүн надаас өмнө орчихдог гэсэнд Есүс түүнд

- Бос. Дэвсгэрээ аваад, яв гэж айлдав. Тэр өдөр амралтын өдөр байлаа.

Дараа нь Есүс түүнийг сүмд олоод

-Харагтун, чи эрүүл болжээ. Чамд илүү муу юм тохиолдохгүйн тулд дахиж нүгэл бүү үйлд гэв. Тэр хүн Иудейчүүд дээр очиж, өөрийг нь эдгээсэн хүн Есүс болохыг тэдэнд хэллээ. Есүс эдгээр зүйлсийг Амралтын өдөр үйлдэж байсан тул иудейчүүд Түүнийг хавчих болов. Харин [Есүс] тэдэнд

-Миний Эцэг одоо болтол ажилласаар байна. Би Өөрөө ч ажиллаж байна гэж айлдав. Үүнээс болж иудейчүүд Түүнийг алахыг улам санаархах болжээ. Учир нь Есүс Амралтын өдрийг зорчсон төдийгүй, мон Бурханыг Өөрийнхөө Эцэг хэмээн, Өөрийгөө Бурхантай адилтгасан юм.

### Хийх Зүйлс.

Өгүүлбэрүүдийн хоосон зайг нөхөж бич.

1. \_\_\_\_\_ жил өвчтэй байсан нэгэн хүн тэнд байв. (5).

2. Есүс түүнээс маш чухал асуулт асуусан. "Чи \_\_\_\_\_ болохыг хүсэж байна уу?" (6).

3. Есүс түүнд боломжгүй зүйл хийхийг тушаажээ. \_\_\_\_\_. Дэвсгэрээ аваад \_\_\_\_\_ гэж айлдав.(8).

4. Дараа нь Есүс түүнийг сүмд олоод түүнд - Харагтун, чи эрүүл болжээ. Чамд илүү муу юм тохиолдохгүйн тулд \_\_\_\_\_ гэв. (14).

5. Еврейчүүд Есүсийг хоёр гол шалтгааны улмаас алахыг санаархав. (а). Тэр \_\_\_\_\_ төдийгүй, [Энэ өдөр Еврейчүүд ямар ч хийх ёсгүй гэж үздэг байхад Есүс өвчтэй хүнийг эдгээжээ.] (б). мөн Бурханыг Өөрийнхөө Эцэг хэмээн, Өөрийгөө \_\_\_\_\_ юм (18).

### Чи Эрүүл Болох Хэрэгтэй Юу?

Магадгүй таны бие, оюун ухаан сэтгэл хөдлөл чинь илүү сайн хүчтэй болох хэрэгтэй. Магадгүй танд Бурханд үйлчлэхэд саад болдог муухай зуршил байгаа байх. Магадгүй таны дотор дургүйцэл, хорсол байгаан улмаас та дотроосоо идэгдэж байж болох юм.

Есүс таны энэ байдлыг хараад **"Чи эрүүл болохыг хүсэж байна уу?"** хэмээн танаас асууж байна. Танд ямар нэгэн шалтгаан байгаа учраас та эрүүл биш байгаа. Магадгүй та гэр бүлийнхэн дотроо ганцаараа итгэгч байх. Эсвэл таны эргэн тойрон дахь нөхцөл байдлууд бүгд таны эсрэг байгаа юм шиг санагдаж байгаа байх. Гэвч ямар ч асуудал Есүсийн хувьд юу ч биш. Тэр таныг ямар ч байсан *шууд* бүрэн эдгээж чадна. Харин Есүс явж чаддаггүй өвчтэй хүнд, "Бос, Дэвсгэрээ аваад алх" гэж тушааж байсан шиг танаас боломжгүй мэт санагдах зүйлс хийхийг шаардаж болох юм. Юу ч байсан гэлээ та Есүсийн тушаалыг дуулгавартай дагах юм бол Тэр танд хүчийг өгч та бүрэн эдгэрэх болно. Үүний дараа Тэрээр таныг ялалттай амьдралаар удирдан дагуулах болно.

## ТҮҮХ 10. ХОЁР АМИЛАЛТ

Иохан 5: 24-29

Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Миний үгийг сонсоод, Намайг илгээгч Түүнд итгэгч нь мөнх амьтай болох бөгөөд яллагдахгүй. Харин үхлээс амь уруу шилжив. Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Үхэгсэд Бурханы Хүүгийн дууг сонсох цаг ирж байгаа бөгөөд одоо ирчихээд байна. Сонсогчид нь амьдрах болно. Учир нь Эцэгт Өөрт нь амь байдгийн адил мөн Хүүд өөрт нь

амь байлгахыг Тэр Хүүдээ соёрхжээ. Тэр бол Хүний Хүү мөн тул шүүлтийг гүйцэтгэх эрх мэдлийг Тэр Түүнд өгөв. Үүнд бүү гайхагтун. Учир нь булшинд байгчид бүгдээрээ Түүний дууг сонсои, гарч ирэх цаг ирж байна. Сайн үйлийг үйлдсэн хүмүүс нь амийн амилалт уруу, муу үйлийг үйлдсэн хүмүүс нь ялын амилалт уруу гарч ирнэ.

### Бодох Хэрэгтэй Зарим Зүйлс

Есүс бидний зүрх сэтгэлийн хаалгыг тогшоод зогсож байна, хэрэв бид Түүнийг амьдралдаа орж ирэхийг зөвшөөрөх юм бол *бид мөнхийн улсад амьдрах итгэл найдвартай болох* бөгөөд энэ нь гайхамшигтай зүйл биш гэж үү! Бид нар хэзээ ч яллагдахгүй гэдгээ болон бид аль хэдийнэ үхлээс амь уруу шилжсэн гэдгээ мэдэх болно. Ийм юм яаж болдог юм бол гэж та гайхаж байна уу? Учир нь Есүст *Өөрт нь амь байдаг* (26). *Христгүй хүмүүс Бурханы өмнө тааламжгүй* (Ром 8:8), байдаг тул тэд булшнаас дахин амилуулагдаад Бурханаас зөвхөн шүүлт болон мөнхийн тусгаарлалтыг л хүлээж авна.

### Хийх Зүйлс

Таны аврал чухам юу болохыг дахин санахын тулд Иохан 5:24-р ишлэлийг цээжил. Та Бурханы Үгийг сонсоод Түүнд итгэж (Түүнд дуулгавартай байх нь Түүнд итгэж байгаагаа илэрхийлж буй хэрэг юм) байгаа бол, Сатан таны оюун ухаанд эргэлзээ бий болгохыг бүү зөвшөөр. Бурхан таныг Өөрийнх нь гэдгийг *мэдээсэй* гэж хүсдэг. Хэрвээ Бурхан та хоёрын дундуур ямар нэгэн юм орж ирэх юм бол Тэр үүнийг танд маш тодорхой харуулж өгөх болно. Тиймд та тэр зүйлээсээ гэмшиж, түүнийгээ орхих хэрэгтэй. Бурхан дахин босгодог бол харин Сатан *буруушаадаг*.

## ТҮҮХ 11. ЕСҮС БОЛ АМЬДРАЛЫН ТАЛХ.

Иохан 6:5-14, 35, 47-51, 53-56, 63

Есүс харцаа дээшлүүлэн, Өөр уруу нь үй олон хүн ирж буйг хараад, Филипт

- Тэднийг хооллох талхыг бид хаанаас худалдаж авах вэ? гэлээ. Есүс Филипнийг сорихын тулд тийн асуужээ. Учир нь Есүс юу хийхээ Өөрөө мэдэж байлаа. Филип Түүнд

- Хүн бүр жаахан авлаа ч гэсэн хоёр зуун денарын талх тэдэнд хүрэлцэхгүй шүү дээ гэв. Шавь нарын нэг болох Симон Петрийн дүү Андрей Есүст хандан

- Энд таван арвайн талх, хоёр загастай хүүхэд байна. Гэвч тэр нь энэ олон хүнд юу болох вэ? гэсэнд Есүс

- Хүмүүсийг суулга гэв. Тэр газар нь их зүлэгтэй газар бөгөөд таван мянга орчим эрчүүд сууцгаасан байв. Тэгээд Есүс талхнуудыг авч, талархал өргөөд, сууцгаасан хүмүүст тарааж өгөв. Мөн загасыг ч тэдний хүссэнээр өгчээ. Хүмүүс цадсаны дараа Тэр шавь нартаа

- Юу ч хаяхгүйн тулд үлдэгдлийг нь цуглуул гэв. Хүмүүсийг хооллосон таван арвайн талхны үлдэгдлийг тэд цуглуулахад арван хоёр сагс дүүрчээ. Хүмүүс Есүсийн үйлдсэн тэмдгийг үзээд

- Ертөнцөд ирэх ёстой өнөөх Эш үзүүлэгч үнэхээр энэ мөн хэмээн ярилцах болжээ.

Би бол амийн талх байна. Над уруу ирдэг хүн өлсөхгүй, Надад итгэдэг хүн хэзээ ч цангахгүй. Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Итгэдэг хүн мөнх амьтай. Би бол амийн талх байна. Та нарын өвөг дээдэс цөлд манна идсэн бөгөөд тэд нас барцгаасан. Энэ нь тэнгэрээс бууж ирэх талх бөгөөд үүнээс идэгч нь үхэхгүй. Би бол тэнгэрээс бууж ирсэн амьд талх байна. Хэрэв хэн нэгэн энэ талхнаас идвэл, тэр мөнхөд



амьдарна. Ертөнцийн амийн төлөө Миний өгөх талх бол Миний махан бие юм гэж айлдлаа.

Есүс тэдэнд - Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Хэрэв та нар Хүний Хүүгийн махыг идэхгүй, цусыг нь уухгүй л бол та нарын дотор байхгүй. Миний

махыг идэж, цусыг уусан хүн монх амьтай бөгөөд Би түүнийг эцсийн өдөрт амилуулна. Учир нь Миний мах бол жинхэнэ хоол, Миний цус бол жинхэнэ ундаа мон. Миний махыг идэж, цусыг уусан хүн

Миний дотор байж, Би ч түүний дотор оршин байна.

Сүнс бол амь өгдөг, мах бол ашиггүй юм. Миний та нарт хэлсэн үгс бол сүнс ба амь билээ.

### Хийх Зүйлс

Дараах ишлэлүүдийг цээжил: **Иохан 6:35, Иохан 6:63.**

#### Энэ Түүх Бидэнд Юу Зааж Байна вэ?

1. Есүс бидний хэрэгцээнд санаа тавьдаг. Тэр аль хэдийнэ бидний хэрэгцээг хангахаар төлөвлөчихсөн байдаг боловч Өөрт нь итгэж буй эсэхийг шалгахыг хүсдэг. Учир нь Есүс бидэнд хэрэгтэй байгаа бүх зүйл дээрээ Өөрт нь найдаж, Өөрийг нь хараасай гэж хүсдэг.

2. Тэр бүү хэл Есүс Өөрт нь байгаа жижиг зүйлсэд ч гэсэн талархаасай гэж хүсдэг. Бурхан бидэнд хэлэхдээ: **“Бүх зүйлд талархлаа илэрхийл. Учир нь энэ бол та нарын төлөөх Христ Есүс доторх Бурханы хүсэл мөн”** (1 Тесаллоник 5:18).

3. Есүс бүх асуудлыг шийдэж чадах төдийгүй бидний бүх хэрэгцээг хангалттайгаар өгч чадна. **“Эдүгээ, бидний дотор ажилладаг хүчний дагуу гуйж, бодох бүхнээс минь илүү хэмжээлшгүй бялхлаар үйлдэх чадвартай Түүнд ...”** (Ефес 3:20).

4. Бурхан дэмий үрэх дургүй. Өөрийнх бидэнд өгсөн бүх зүйлсээс **“нэгийг нь ч хаялгүй”** бүгдийг нь хэрэглээсэй гэж хүсдэг.

Тэр мөн биднийг цагийг ухаалаг зарцуулаасай гэж хүсдэг. **“Цагийг авар. Яагаад гэвэл өдрүүд нь бузар булай аж. Тийм учраас бүү мунхаг бай. Харин Эзэний хүсэл юу болохыг ухаар”** (Ефес 5:16, 17).

Түүнчлэн Тэрээр бас бидэнд өгөгдсөн бэлэг авьяас болон талантуудаа хамгийн сайнаар ашиглаасай хэмээн биднээс хүсдэг. **“Эзэн нь түүнд Сайн байна итгэмжит боол минь! Чи цөөн юманд итгэмжтэй байсан тул чамд ихийг**



хариуцуулья. Эзнийхээ баяр баясгаланд ор гэжээ” (Матай 25:21).

Мөн Есүс бас биднийг мөнгийг ухаантай зарцуулаасай гэж хүсдэг. “Газар дээр эд баялаг бүү хураа. Тэнд хивэн хорхой болоод зэв идэж сүйтгэдэг, хулгайч эвдэж ороод хулгайлан авдаг аж. Харин тэнгэрт эд баялгийг өөрсөддөө хураа. Учир нь тэнд хивэн хорхой болоод зэв идэж сүйтгэдэггүй, хулгайч ч эвдэж ордоггүй, хулгайлдаггүй. Та нарын эд баялаг хаана байна, зүрх сэтгэл чинь бас тэнд байх болно” (Матай 6: 19-21).

5. Дагалдагч нар нь Есүсээс хүнсийг хүлээн аваад, олон түмэнд тарааж өгчээ. Үүнчлэн бид өдөр бүр Есүсээс сүнслэг хоол хүлээн авах бүртээ бид эргэн тойрондоо “амийн талх” хэрэгтэй байгаа хүмүүстэйгээ хуваалцах боломжтой болдог.

### Хоёр Төрлийн Талх

Цугларсан олон хүмүүсийг өлсөж байхад нь Есүс хооллосон тул тэд маш их баярлацгаав. Тэгээд тэд Есүсийг өөрсдийнхөө хаан болгохыг хүсэв. Учир нь тэд дахин хоолтой болохын тулд ажиллах ёстой хэмээн хэзээ ч санаа зовохгүй юм. Гэвч Есүс тэдний өвөг дээдэст нь юу тохиолдсоныг тэдэнд сануулав. Изриалийн ард түмэн Египетийн боолчлолоос чөлөөлөгдөөд Бурханы амласан газар уруу явж байхдаа цөлд ихэд өлсөцгөөж байсан тул Бурхан тэднийг хооллохын тулд өдөр бүр тэнгэрээс тэдний дээр талхан “бороо” оруулж байжээ!



Ямар агуу гайхамшиг болоо вэ! (Египетээс гарсан нь 16:4-35). Хүмүүс энэ шинэ төрлийн хоол нь юу байсныг хараахан мэдэхгүй байлаа. Тиймд тэд үүнийгээ “Юу юм бол?” гэсэн утгатай манна хэмээн нэрлэжээ.

Харин хожим нь Бурхан яагаад энэ гайхамшигийг үйлдэх болсоноо Изриалийн ард түмэнд илчлэн харуулжээ. “Эзэн Бурхан чинь чамайг энэ дөчин жилийн турш цөлд удирдсан бүх л зам мөрийг дурсан сана. Энэ нь чиний зүрхэнд юу байсныг, Түүний тушаалыг дагах эсэхийг чинь мэдэхийн тулд, чамайг номхтгож, шалгаж сорихын тулд байсан юм. Хүн зөвхөн талхаар амьдардаггүй, харин хүн Эзэний амнаас гарах үг бүхнээр амьдардаг гэдгийг чамд ойлгуулахын тулд Тэрээр чамайг номхтгон, чамайг өлсгөж, чиний мэддэггүй, чиний өвөг дээдэс ч мэддэггүй байсан “манна”-гаар чамайг хооллож байсан. (Дэд хууль 8:2,3).

Тэр ч бүү хэл Бурхан олон жилийн турш гайхамшигтай арга замаар тэнгэрээс Изриалийн ард түмнийг маннагаар хангаж байлаа. Энэ манна нь бие махбодид тэжээл болохуйц талх байв. Ард түмэн маннаг идсэн хэдий ч насан өндөр болж, үхдэг байлаа. Мөн Есүс тэр өдөр үй олон түмнийг хооллохдоо зөвхөн тэдний бие махбодийг нь цагтах талх өгсөн юм. Хэдийгээр тэд талх идээд цадсан ч гэлээ мөн адилхан хөгшрөөд үхэх л байсан.

*Харин Есүст гайхалтай мэдээ байсан юм!* Одоо Есүс нэгэн шинэ төрлийн “талхыг” өгөхөөр санал болгож байна. Үүнээс идсэн хүмүүс үхэхгүй. Мэдээж тэдний бие махбодь нь үхэх боловч харин тэд өөрсдөө хэзээ ч үхэхгүй бөгөөд Христ дахин ирэх сүүлчийн өдөрт тэдний бие мах бодийг үхэгсдээс амилуулна. Есүс “Өөрийгөө” хүмүүст “Би бол талх” хэмээн тунхаглаж байсан юм. Учир нь Тэр үнэхээр тэдний сүнснийх нь амийн талх байв. Есүс энэ дэлхийд Өөрийн амийг өгөхөөр яг тэнгэрээс манна бууж ирж байсантай адил тэнгэрээс бууж ирсэн юм. Хэн амийн талхыг “идэж”, сүнсэндээ хүлээн авна, тэр хүн хэзээ ч үхэхгүй.

Яаж бид Есүс хэмээх “Амийн талхыг” идэх вэ? Яаж бид Түүний цусыг уух вэ? Бидний авралын төлөө загалмай дээр цовдлогдсон Христийн золилтыг бид хүлээн авах хэрэгтэй. Мөн бид Тэрээр Бурханы Хурга болон ирээд Түүний цус нь бидний бүх гэм нүглийг бүрхсэн гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Түүнчлэн бид Түүний амь-өгөгч Сүнсийг зүрх сэтгэлдээ хүлээн авч, мөн Түүний амьдрал бэлэглэгч үнэн үгэнд суралцан, Түүнийг дуулгавартай дагах хэрэгтэй. Харин бид Христийн амийг өөрсөддөө тээж явахын тулд өдөр бүр бие махбодоо хооллох нь зөв юм.

**Та сүнсээрээ өдөр бүр Есүсийн биенээс “идэж” цусыг нь “уух” хэрэгтэй:**

1. Өдөр бүр Бурханы Үгийн гэрэл дотор яв. Хэрвээ та гэм хийх юм бол Бурханы өмнө гэмээ хүлээн зөвшөөрч гэмш. Тэгвэл Христийн цус таныг цэвэрлэх бөгөөд та Түүнтэй үргэлжлүүлэн сайн харилцаатай хэвээрээ үлдэнэ.(1:7,9).

2. Өдөр бүр Есүсээс Ариун Сүнсээрээ дүүргэж өгөөч-гэж гуй. Юу ч хийсэн та өөртэйгөө хамт байгаа Ариун Сүнсний хүч чадалд итгэж Түүнээс танд өгөгдөж буй Библийн дагуух зааврын дагуу үйлд. Учир нь Бурханы Үг бол бидэнд амь билээ. Мөн та өдөр бүр хэсэг хугацаанд Бурхантай ганцаархнаа чангаар ярилцаж, дараа нь Түүний тухай өдрийн турш бодсон хэвээр бай. Та өөрийнхөө оюун санаанд байгаа бүх зүйлсээрээ Түүнтэй ярилцаж болно. Дараа нь та өөрийгөө улам бүр Есүстэй адил болоод байгаагаа мэдэх болно.

Хэрвээ та эдгээр зүйлсийг хийвэл Бурхан танд нэгэн гайхамшигт амлалтыг өгч байна:

**“Тэгээд ЭЗЭНээс эмээдэг хүмүүс бие биентэйгээ ярихад ЭЗЭН анхаарал тавин сонссон.**

**ЭЗЭНээс эмээдэг болон Түүний нэрийг үнэлдэг хүмүүсийн төлөө дурсгалын ном Түүний өмнө бичигдсэн билээ. “Би Өөрийн эзэмшлийг байгуулах өдөр тэд Минийх байх болно. Өөрт нь үйлчилдэг хүүгээ өршөөдгийн адил Би тэднийг өршөөх болно” гэж түмэн цэргийн ЭЗЭН айлдаж байна. (Малахи 3:16, 17).**

## Бурханы Үг бол Таны Сүнсний Хоол

Ихэд олон жилийн өмнө Иов ийнхүү хэлж байжээ: “Би Түүний уруулын тушаалаас холдоогүй. Би Түүний амнаас гардаг үгсийг өөрт минь хэрэгтэй хоолноос ч илүүгээр нандигнасан. (Иов 23:12).


Иеримиа ингэж тунхаглажээ: “Таны үгс олдсон бөгөөд би тэднийг идсэн билээ. Таны үгс надад баяр хөөр болон зүрх сэтгэлийн минь таашаал болсон билээ. Учир нь түмэн цэргийн Бурхан ЭЗЭН, би Таны нэрээр дуудагдсан билээ. (Иеримиа 15:16).

Дуулал бичигч нь ийн өгүүлжээ: “Таны үг амтлахад минь ямар чихэрлэг вэ! Миний аманд зөгийн балаас ч илүү чихэрлэг! (Дуулал 119:103).

Петер ийнхүү гуйжээ: “Нялх хүүхдүүд шиг үгийн цэвэр сүүг хүс. Ингэснээр та нар авралд өсөх юм: Хэрэв та нар үнэхээр энэрлийг амссан юм бол... (1Петер 2:2,3).

Тиймд өдөр бүр Бурханы Үгийг “идэцгээе”!

## ТҮҮХ 12. ЕСҮС УСАН ДЭЭГҮҮР АЛХСАН НЬ



Иохан 6:16-21

“Орой болоход шавь нар нь нуурын зүг буугаад, завинд сууцгаасны дараа, нуурыг гатлан

Капернаумыг зүглэв. Хэдийнээ харахуй болсон авч, Есүс тэдэн дээр ирээгүй л байлаа. Хүчтэй салхинаас болж нуур давалгаалж эхлэв. Шавь нар нь хорин тав эсвэл гучин стадиа орчим газар сэлүүрдээд байтал Есүсийн нуурын дээр алхан, завь уруу нь дөхөхийг хараад тэд айцгаалаа. Гэвч Есүс тэдэнд

- Би байна. Бүү ай! гэж айлдав. Тэд Есүсийг завиндаа оруулахыг хүсжээ. Тэр даруй завь нь очих газартаа хүрсэн байлаа.

### Бодох Зүйлс

Та шуурган дунд амьдарч байна уу? Яг одоо таны амьдрал харанхуйгаар дүүрч, Есүс хаана байгаа нь мэдэгдэхгүй хол байгаа юм шиг санагдаж байна уу? Тэгээд та шуурган дундуур

тэмцэж, өөрийнхөө сул дорой хүчээр нөгөө талд нь гарахыг оролдон байна уу? Хэрэв та тийм байгаа бол Есүс таныг халамжилдаг гэдгийг мэдэгтүн. Тэр таныг мэддэг, мөн таныг харж байгаа төдийгүй таны найдваргүй болсон нөхцөл байдал уруу чинь дөхөж байна. Тиймд бүү ай. Өөрийн асуудал болон нөхцөл байдалдаа Есүсийг баяртайгаар оролцуулан Түүнд бүх асуудлуудаа даатга. Тэрээр давалгаалсан их усыг тань номхтгож таныг нөгөө эрэг дээр аюулгүйгээр хүргэж өгөх болно. **“Үхлийн харанхуйн хөндийгөөр туулавч Би хор хөнөөлөөс айхгүй, Учир нь Та надтай хамт байна. Таны саваа, таны таяг намайг тайвшруулдаг”.**

(Дуулал 23:4).

### ТҮҮХ 13. ЕСҮС ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ЯРИВ

Иохан 8:31-37, 42, 47

“Есүс Өөрт нь итгэсэн нудейчүүдэд

- Хэрэв та нар Миний үгэн дотор байвал үнэхээр Миний дагалдагчид байна. Тэгээд та нар үнэнийг ойлгож, үнэн та нарыг чөлөөлнө гэсэнд тэд Түүнд

- Бид Абрахамын удам бөгөөд хэзээ ч хэнд ч боолчлогдож байгаагүй. “Та нар эрх чөлөөтэй болно” гэж Та юунд хэлнэ вэ? гэв. Есүс тэдэнд

- Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Нүгэл үйлдэгч бүр нүглийн боол мөн. Боол гэрт мөнхөд байдаггүй, харин хүү л мөнхөд байдаг. Иймээс хэрэв Хүү та нарыг чөлөөлбөл та нар үнэхээр эрх чөлөөтэй болно. Та нар бол Абрахамын үр удам мөн гэдгийг


Би мэднэ. Гэвч та нарын дотор Миний үг байх зайгүй учир та нар Намайг алахыг оролдож байна.

Есүс тэдэнд

- Хэрэв Бурхан та нарын Эцэг байсан бол, та нар Намайг хайрлах байсан. Учир нь Би Бурханаас гарч ирсэн билээ. Өөрийн санаагаар ирээгүй, харин Тэр Намайг илгээсэн юм.

Бурханы хүн нь Бурханы үгсийг сонсдог. Та нар Бурханых биш учир эдгээрийг сонсдоггүй гэлээ. Иохан 7:17

Хэрэв хэн нэгэн нь Түүний хүслийг үйлдэхийг хүсэж байвал тэр нь энэ сургаал Бурханаас ирсэн үү, эсвэл Би Өөрөөсөө ярьж байна уу гэдгийг мэднэ.



### Хийх Зүйлс

Хоосон зайг нөхөж бич.

1. Хэрэв та нар Миний үгэн дотор \_\_\_\_\_ үнэхээр Миний \_\_\_\_\_ байна (8:31).
2. \_\_\_\_\_ та нарыг чөлөөлнө (8:32).
3. Нүгэл үйлдэгч бүр нүглийн \_\_\_\_\_ мөн (8:34).
4. \_\_\_\_\_ та нарыг чөлөөлбөл та нар үнэхээр эрх чөлөөтэй болно (8:36).
5. Есүс тэдэнд - Хэрэв Бурхан та нарын Эцэг байсан бол, та нар Намайг \_\_\_\_\_ байсан (8:42).
6. \_\_\_\_\_ хүн нь Бурханы үгсийг сонсдог (8:47).
7. Хэрэв хэн нэгэн нь Түүний \_\_\_\_\_ үйлдэхийг хүсэж байвал тэр нь энэ сургаал Бурханаас ирсэн үү, эсвэл Би өөрөөсөө ярьж байна уу гэдгийг \_\_\_\_\_ (7:17).

### ТҮҮХ 14. ЕСҮС БОЛ ДЭЛХИЙН ГЭРЭЛ



Иохан 8:12

Тэгээд Есүс тэдэнд дахин  
- Би бол ертөнцийн гэрэл мөн.  
Намайг дагадаг хүн харанхуй  
дотор явахгүй, харин амийн  
гэрэлтэй болно гэж айлдав.

Иохан 9:1-9, 13-25, 33-38

Есүс явж өнгөрөхдөө, төрөлхийн  
сохор хүнийг харжээ. Шавь нар нь  
Түүнээс

- Рабби, хэн нүгэл үйлдсэнээс энэ  
хүн сохор үлдсэн юм бэ? Энэ хүн  
үү? Түүний эцэг эх үү? хэмээн  
асуусанд Есүс

- Энэ хүн ч, эцэг эх нь ч нүгэл  
үйлдсэнээс болоогүй. Харин энэ нь  
Бурханы ажлуудыг түүгээр  
харуулахын тулд юм. Намайг  
Илгээгчийн ажлыг Би өдөр  
байхад хийх ёстой. Хэн ч  
ажиллаж чадахгүй шөнө ирж  
байна. Би ертөнцөд байгаа үедээ

ертөнцийн гэрэл байна гэж хариулав. Ингэж хэлээд, Тэр газар нулимж, шүлсээрээ шавар зуурч, тэр хүний нүдийг шавраар шаваад,

- Яв, Силоамын (орчуулбал Илгээгдсэн) цооромд угаа гэж хэлэхэд өнөөх хүн явав. Тэгээд угаагаад, хараатай болон эргэн иржээ. Урьд түүнийг гуйлгачин байсныг харсан хүмүүс болон хоршүүд нь

- Энэ чинь суучихаад гуйлга гуйдаг ногоо хүн биш үү? гэхэд зарим нь

- Тэр мөн байна гэгцгээв. Бусад нь  
- Үгүй, түүнтэй тостэй юм байна гэсэнд тэр оорөө

- Тэр чинь би байна гэж хэлэв. Урьд нь хараагүй байсан өнөөх хүнийг тэд фарисайчууд уруу авч ирэв. Есүс шавар зуурч, түүний харааг оруулсан өдөр нь Амралтын өдөр байжээ. Тэгтэл фарисайчууд түүнээс хэрхэн хараатай болсныг нь дахин асуусанд тэр

- Тэр миний нүдийг шавраар шавсан. Би угаагаад, тэгээд л харж байна гэхэд фарисайчуудын зарим нь

- Тэр Амралтын одрийг сахьдаггүй учир Бурханаас ирсэн хүн биш гэв. Харин зарим нь

- Нүгэлт хүн тийм тэмдгүүдийг хэрхэн үйлдэж чадах билээ? гэлээ. Тэгээд тэдний дунд хагарал гарав. Тиймээс тэд сохор эрд дахин

- Тэр хүн чиний нүдийг нээсэн учраас Түүний тухай чи юу хэлэх вэ? гэхэд тэр

- Тэр бол эш үзүүлэгч гэв.

Тэгтэл хараатай болсон хүний эцэг эхийг дуудах хүртэл нудейчүүд түүнд сохор байж байгаад хараатай болсонд нь итгэсэнгүй. Тэд эцэг эхээс нь

- Сохор төрсөн гэж та нарын ярьдаг хүү чинь энэ мөн үү? Тэгвэл одоо тэр яаж харж байна? гэж асуув. Эцэг эх нь тэдэнд

- Энэ бидний хүү мөн гэдгийг болон сохор төрснийг нь бид мэдэж байна. Харин тэр одоо тэр яаж харж байгааг бид мэдэхгүй. Нүдийг нь хэн нээснийг нь ч бид мэдэхгүй. Өөрөөс нь асуу. Тэр насанд хүрсэн хүн. Тэр оорөө хэлг гэв. Түүний эцэг эх нудейчүүдээс айсан тул тэгж хэлжээ. Учир нь Есүсийг Христ мөн гэж хүлээн зөвшөөрсөн хүн синагогөөс хөөгдөх ёстой хэмээн нудейчүүд нэгэнтээ шийдсэн байлаа. Тиймээс түүний эцэг эх нь “Тэр насанд хүрсэн хүн, Өөрөөс нь асуу” гэжээ. Фарисайчууд сохор байсан хүнийг хоёр дахь удаагаа дуудаад, түүнд  
- Бурханд алдрыг өргө. Тэр хүн нүгэлтэйг бид мэднэ гэсэнд тэр  
- Тэр нүгэлтэн эсэхийг би мэдэхгүй. Би нэг л юмыг, урьд нь сохор байснаа, одоо харж байгаагаа л мэдэж байна гэв.... Хэрэв энэ хүн Бурханаас ирээгүй

юм бол Тэр юу ч хийж чадахгүй байсан гэж тэр хэллээ. Тэд - Чи нүглүүд дотроо төрсөн атлаа бас биднийг сургана уу? гээд түүнийг хөөн гаргав. Иудейчүүдтэр хүнийг хөөн гаргасныг Есүс сонсоод, түүнийг олж

- Чи Хүний Хүүд итгэж байна уу? гэхэд тэр - Эээн минь, Тэр хэн юм бэ? Би Түүнд итгэе гэв. Есүс - Чи Түүнийг харсан, Одоо чамтай ярьж байгаа нь Тэр мөн гэлээ. Тэр Эээн минь, би итгэж байна гээд Түүнд мөргөв.

### Хэн Үүнийг Хэлсэн Бэ?

1. "Хэн ч ажиллаж чадахгүй шөнө ирж байна" гэж хэн хэлсэн бэ? \_\_\_\_\_ (4-р ишлэл).
2. "Энэ чинь суучихаад гуйлга гуйдаг нөгөө хүн биш үү?" гэж хэн хэлсэн бэ? \_\_\_\_\_ (8).
3. "Тэр Бурханаас ирсэн хүн биш" гэж хэн хэлсэн бэ? \_\_\_\_\_ (16). [Фарисайчууд Еврейн шашинтай хэсэг бүлэг хүмүүс байв. Тэд Мосегийн буюу уламжилж ирсэн хуулийг маш чанд мөрддөг хүмүүс ажээ.]
4. Еврейчүүдээс айсны улмаас "Тэр насанд хүрсэн хүн, өөрөөс нь асуу" гэж хэн хэлсэн бэ? \_\_\_\_\_ (21-23). [Синагогоос хөөгдөнө гэдэг нь тухайн үеийн хүмүүст маш хэцүү явдал байлаа. Учир нь тэд яг уяман өвчтэй хүн шиг хөөгдөж, гадуурхагдах бөгөөд хэн ч түүнтэй хамт хооллох юм уу эсвэл хамтарч ажилладаггүй байв.]
5. "Хэрэв энэ хүн Бурханаас ирээгүй юм бол Тэр юу ч хийж чадахгүй байсан гэж хэн хэлсэн бэ? \_\_\_\_\_ нь (33).
6. "Чи Хүний Хүүд итгэж байна уу?" гэж хэн асуусан бэ? \_\_\_\_\_ (35).
7. "Би Түүнд итгэе" гэж хэн хэлсэн бэ? \_\_\_\_\_ (38).

### Есүс Гэрлийг Авчирдаг

Есүс сохор хүнийг хараатай болгох үед түүний амьдралд гэрэл орж ирсэн. Гэвч үүнээс илүү зүйл нь Тэрээр харанхуй амьдралдаа тэмтчин яваа бүх хүмүүсийн сүнснийх нь нүдийг нээхээр аль хэдийнэ ирчихсэн гэдгээ харуулахыг хүсдэг.



Олон жилийн өмнө Бурхан нэгэн эш үзүүлэгчээр дамжуулан энэ дэлхийд гэрлийг авчрах Нэгэнийг илгээнэ хэмээн амлаж байжээ. Бурхан Есүсийг ийнхүү хэлж байжээ:

**“Би бол ЭЗЭН. Би чамайг зөвт байдалд дуудсан. Би бас чиний гараас чинь атгаад, чамайг харгалзана. Би чамайг ард түмэн гэрээ болгож, үндэстнүүдэд гэрэл хэмээн томилно. Энэ нь сохрын нүдийг нээж, гяндангаас хоригдлуудыг чөлөөлж, харанхуйд суугчдыг шоронгоос гаргахын тулд юм”** (Исаиа 42:6,7). Исаиа Есүсийн ирэх өдрийг харсан нь энэ ажээ: **“Харанхуйд алхаж яваа хүмүүс агуу их гэрлийг үзнэ. Харанхуй газарт амьдарч байгаа хүмүүс дээр гэрэл тусна.** (Исаиа 9:2).

Есүс дэлхийн гэрэл байх тухай тунхаглаж байхад еврейчүүд Түүнийг Бурханы тухай ярьж байна гэдгийг мэдэж байв. Учир нь Бурхан гэрэл юм. Дуулал 27:1 дээр:

**“Эзэн бол миний гэрэл болон миний аврал юм”** гэж хэлдэг. **“Хэдийгээр би харанхуйд амьдравч ЭЗЭН миний гэрэл юм”** (Мика 7:8.б). Давид Бурханд **“Эзэн минь, Та миний гэрэл учраас ЭЗЭН харанхуйг минь гэрэлтүүлдэг”** хэмээн талархажээ. (2Самуел 22:9). Бид Есүсийг таньж мэдэх үедээ Бурханыг таньж мэдэж байдаг. **“Хэрэв та нар Намайг мэдсэн бол Миний Эцэгийг ч мөн мэдэх байсан.** (Иохан 14:7а).

**“Харанхуйгаас гэрэл гэрэлтэг”** гэж айлдсан Бурхан бол Христийн нүүрэн дэх Бурханы алдрын мэдлэгийн гэрлийг өгөхөөр бидний зүрхэнд гэрэлтсэн Нэгэн мөн” (2Коринт 4:6). Та энэхүү гэрлийг хүлээн авсан уу?

### **Гэрэл Дотор Алхах**

Христийг дагадаг хүмүүс харанхуй дотор бус, гэрэл дотор алхдаг юм. **“Учир нь та нар урьд нь харанхуй байсан. Харин одоо та нар Эзэн дотор гэрэл ажээ. Гэрлийн хүүхдүүд шиг яв”** (Ефес 5:8).

**“Хар санаатны зам нь харанхуй мэт буюу. Тэд юунд мэдэрч байгаагаа үл мэднэ”** (Сургаалт үгс 4:19). **“Харин шударга зөв хүмүүсийн жим болбоос үүрийн гэгээ мэт агаад, Тэр нь өдрийг авчрах хүртэл улам тод гэрэлтсээр байх болно”** (Сургаалт үгс 4:18).

Бурханы Үг бол гэрэл. “Таны үг бол миний хөл дэх дэнлүү. Миний зам дахь гэрэл юм. (Дуулал 119:105). “Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг. Тэдгээр нь энгийн хүмүүст ухаарлыг хайрладаг” (Дуулал 119:130). Өдөр бүр бид Бурхан дээр ирэх бүрдээ Түүнийг сонсож, юу хэлснийг нь дуулгавартай дагах ёстой. Үүнийг л “гэрэл дотор алхах” гэж хэлээд байгаа юм. *Бурханы хэлснийг хэрэгжүүлвэл гэрэл дотор алхаж байна* гэсэн үг. Та “бие биенээ хайрла” гэсэн Есүсийн тушаалыг санаж байна уу? “Харин ах дүүгээ үзэн яддаг нэгэн бол харанхуйн дотор байгаа бөгөөд харанхуй дотор алхаж, харанхуй нүдийг нь сохолсон тул хаашаа яваагаа ч мэддэггүй. (1Иохан 2:11).

Хамгийн хурдан сохор болох арга бол үргэлж харанхуй дотор алхах юм. Газар доор нүүрс зөөлгөн ашиглаж буй лууснуудаа долоо хоногт дор хаяж нэг удаа ч болов гэрэлд гаргахгүй бол тэд сохордог. Үүнчлэн бид гэрэл дотор үргэлж явахгүй бол Сатан бидний сүнсний нүдийг хууран, бидний оюун санаа болон зүрх сэтгэлийг сохлох болно.

### Бид нар Дэлхийн Гэрэл

“Бүхнийг гоморхолгүйгээр, маргалгүйгээр хийцгээ. Ингэснээр та нар гэрэл мэт үзэгдэн дунд нь амьдардаг буруу, гажууд үеийнхний дотор өөрсдийгөө гэм зэмгүй, буруугүй Бурханы хүүхдүүд гэдгээ батлах юм” (Филиппой 2:14, 15). Бурхан биднийг “харанхуйгаас Өөрийн гайхамшигт гэрэл уруу дуудсан Түүний давуу чанаруудыг тунхаглуулахын” тулд сонгосон юм. (1Петр 2:9). Та эргэн тойрондоо гэрэл нь болж чадаж байна уу? Хэрэв үгүй бол, Паул биднээс хичээнгүйлэн гуйж байна. “Тиймээс харанхуйн үйлсийг хажуу тийш тавьж, гэрлийн зэвсгүүдийг агсацгаая” (Ром 13:12).

Бид Эзэнийг эргэн ирэхэд бэлэн байх хэрэгтэй. Хэрэв бид сэргэг бөгөөд гэрэл дотор алхаж байх юм бол бэлэн байж чадна. “Учир нь та нар бүгдээрээ гэрлийн хөвгүүд бөгөөд өдрийн хөвгүүд юм. Тиймээс бид бусдын адил унталгүй, харин

сэргэг бөгөөд эрүүл ухаантай байцгаая” (1Тесалоник 5:5-6).

Есүс шинэ тэнгэр, шинэ газар болон шинэ Иерусалемын тухай ингэж хэлжээ: “Хотод дээрээс нь гэрэлтүүлэх нар, сар хэрэггүй ажээ. Учир нь Бурханы цог жавхлан түүнийг гэрэлтүүлсэн бөгөөд дэнлүү нь Хурга байлаа” (Илчлэлт 21:23). Есүс мөнхөд биднийг гэрэлтүүлнэ гэдэг нь гайхалтай биш гэж үү!

### **Гэрэл Байгаа Үед Ажиллах нь**

Есүсийг эргэн иртэл бид энэхүү харанхуй дэлхийд маань гэрэл байгаа дээр нь ажиллах хэрэгтэй. Учир нь нэг л өдөр энэ газар дэлхий маань үгүй болно. (Матай 5:18). Харин гэрэлд ирээгүй хүмүүс нь мөнхийн мөнхөд гаднах харанхуйд хаягдана(Матай 22:13). Тиймд бүгдээрээ “тэдний нүдийг нээлгэж, тэднийг харанхуйгаас гэрэл уруу, Сатаны эрхшээлээс Бурхан уруу эргүүлэхийн тулд” ажиллацгаая! (Үйлс 26.18).

Нэгэн удаа еврейчүүд Есүсээс: “Бид Бурханы ажлуудыг хийхийн тулд юу хийх вэ?” гэж асуужээ. Есүс тэдэнд: “Та нар Бурханы илгээсэн Нэгэнд итгэх нь Түүний ажил мөн” гэж хариулав. (Иохан 6:28-29). Есүс мөн шуудхан хэлсэн байдаг: “Хэрэв та нар “Би байдаг” гэдэгт итгэхгүй бол та нар нүглийнхээ дотор үхнэ. (Иохан 8:24).

Эхлээд бид өөрсдөө мөнхийн амийг хүлээж авахын тулд Гэрэлд ирэх ёстой. Дараа нь бид бусад хүмүүсийг Гэрэлд авчрахын тулд Есүстэй хамтарч ажиллах хэрэгтэй. “Та нар мөхөж устах хоолны төлөө бус, харин мөнх аминд хүргэх хоолны төлөө ажилла. Үүнийг Хүний Хүү та нарт өгөх болно. Учир нь Түүний дээр Эцэг Бурхан Өөрийн тамгаа дарсан юм гэлээ” (Иохан 6:27).

Дээрхи түүхэн дээр гарсан сохор хүнийг санаж байна уу? Тэр Есүс өөрт нь юу хийж өгсөнийг бусдад зоригтойгоор ярьж байсан. Үүгээр ч зогсохгүй сүнснийх нь нүд нь, сохорогсод түүнийг хөөсөн боловч Есүс түүнд санаа тавин, Өөрийгөө улам илүү ихээр илчилж харуулахын тулд түүн дээр очсон байна. Мөн Есүс танд ч гэсэн ийнхүү үйлдэхийг хүсэж байна!

## ТҮҮХ 15. ЕСҮС БОЛ САЙН ХОНЬЧИН



Иохан 10:1-16; 27-33

Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Хонины хашаанд үүдээр нь оролгүй, оор газраар давж ордог хүн бол хулгайч, дээрэмчин мөн. Харин үүдээр нь ордог хүн нь хонин сүргийн хоньчин мөн. Сахиул тэр хүнд үүдийг нээдэг бөгөөд хонин сүрэг түүний дууг сонсдог. Тэр өөрийн хоньдыг нэрээр нь дуудаж, тэднийг гадагш дагуулж гарна. Тэр оорнийхнийгоо бүгдийг гаргаад, түрүүнд нь явдаг. Хонин сүрэг түүний дууг таньдаг тул түүнийг дагадаг. Тэд гадны хүнийг ер дагахгүй, харин түүний дууг ер танихгүй учир түүнээс зугтана гэж айлдав. Есүс энэ сургаалт зүйрлэлээр тэдэнд яривч, Түүний ярьсан нь юу байсныг тэд ойлгосонгүй. Тэгээд Есүс дахин тэдэнд

- Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Би бел хонины үүд. [Надаас урьд] ирэгсэд бүгд хулгайч, дээрэмчид юм. Харин хонин сүрэг тэднийг сонсоогүй. Би бол үүд мөн. Хэрэв хүн Надаар орвол, тэр аврагдах болно. Орж, гарч, гэжээлээ олно. Хулгайч зөвхон хулгайлан алж, сүйтгэхээр ирдэг. Би тэднийг амьтай, бялхсан амьтай байлгахын тулд ирсэн юм. Би бол сайн хоньчин мөн. Сайн хоньчин хоньдынхоо толөө амиа өгдог. Хөлсний хүн бол хоньчин биш, хонин сүрэг ч түүнийх биш учир чоно ирэхийг хараад тэрээр хонин сүргийг орхин зугтдаг. Чоно хоньдыг цолмөж, тараадаг. Тэр хөлсний хүн бөгөөд хонин сүрэгт санаа тавьдаггүй тул зугтдаг. Би бол сайн хоньчин мөн. Би Өөрийнхийгөө мэдэх бөгөөд Өөрийнхөн маань намайг мэднэ. Би Эцэгээ мэдэхийн адил Эцэг минь намайг мэддэг юм. Би хоньдын толөө Өөрийн амийг өгнө. Энэ хашаан дахь хонин сүргээс өөр хонин сүрэг Надад бий. Би тэднийг бас авчрах ёстой. Тэд миний дууг сонсоно. Тэгээд тэд нэг хоньчинтой нэг хонин сүрэг болно.

Миний хонин сүрэг дууг минь сонсдог. Би тэднийг мэддэг бөгөөд тэд Намайг дагадаг юм. Би тэдэнд мөнх амийг өгнө. Тэд хэзээ ч мөхөхгүй бөгөөд тэднийг хэн ч Миний гараас булаахгүй. Тэднийг

Надад өгсөн Миний Эцэг бүхнээс агуу бөгөөд тэднийг хэн ч Эцэгийн гараас булааж чадахгүй. Би болон Эцэг нэг юм гэж айлдлаа. Иудейчүүд Түүн уруу чулуудахаар дахин чулуу шүүрцгээв. Есүс тэдэнд - Эцэгээсээ олон сайн үйлсийг Би та нарт үзүүлсэн. Тэдгээрийн

алинаас нь болж та нар Над уруу чулуу шиднэ вэ? гэхэд иудейчүүд Түүнд - Сайн үйлсийн чинь төлөө биш, харин Бурханыг доромжилсоны чинь төлөө бид Тан уруу чулуу шиднэ. Учир нь Та хүн байж, Өөрийгөө Бурхан болгож байна гэв.

### **Энэ Бүлгээс Авч Үзэх Зарим Хичээлүүд**

1. *Зөвхөн Есүс бол авралын хаалга юм.* Бид Түүний дуу хоолойг сонсож, Түүнийг дагаснаар л Түүний хонин сүрэг болдог. Тэрээр таныг нэрээр чинь дууддаг бөгөөд таныг удирдан, бэлчээж, Өөрийнхөө амийг таны төлөө өгдөг. “Бид бүгдээрээ хонь мэт төөрч, хүн бүр өөрийн замаар явав. Харин Эзэн бидний гэмийг нь бүгдийг нь Түүнд тохов” (Исаиа 53:6). Та өөрийн замаас эргэж Түүнийг дагахаар шийдсэн үү?

2. *Зөвхөн Есүс бол жинхэнэ Хоньчин.* “Учир нь Эзэн бол бидний Бурхан бөгөөд Бид Түүний хариулдаг хүмүүс, Түүний мутрын хонин сүрэг юм. (Дуулал 95:7а). “ЭЗЭН Өөрөө бол Бурхан гэдгийг мэдтүгэй. Биднийг бүтээсэн нь Тэр бөгөөд бид өөрсдөө бус юм. Бид Түүний ард түмэн, Түүний бэлчээрийн хонин сүрэг” (Дуулал 100:3).

3. *Хэрэв бид Түүний хонь байвал, Тэр биднийг, бид Түүнийг мэдсэн байдаг.* “Харин, ЭЗЭН, Та намайг мэддэг билээ. Та намайг хардаг билээ. Та миний Тан уруу хандах зүрхийг шалгадаг билээ” (Исаиа 12:3а). *Та Есүсийг таны Хоньчин гэдгийг мэддэг үү?* Хэрэв мэддэг бол та өөр нэгнийг бус, зөвхөн Түүнийг л дагах болно. *Харин Хоньчин маань таныг мэдэх болов уу?* “Тэргүүн Хоньчин үзэгдэх үед”, олон хүн Түүнд “Эзэн минь, Эзэн минь, бид Таны нэрээр эш үзүүлж, Таны чөтгөрүүдийг хөөж, Таны нэрээр олон гайхамшгуудыг үзүүлж байсан биш бил үү? гэж хэлэх болно. Тэгэхэд нь Есүс тэдэнд “Би та нарыг огт танихгүй юм байна. Ёс бусыг

үйлдэгч та нар Надаас зайл” гэж хэлэх болно. (Матай 7:23). Бид өөрсдийн замаар явж байгаа бол Есүсийн хонь байж чадахгүй. Ариусгалгүйгээр нэг ч хүн Эзэнийг үзэхгүй. (Еврей 13:14).

4. Бид Есүсийнх болвол мөнхөд бүрэн бүтэн болдог. Түүний гараас хэн ч биднийг хэсэгчлэн булааж чадахгүй. Энэ амлалт нь зөвхөн “Агуу Хоньчин” болох Их Эзэн Есүс Христийг дагадаг хүмүүст өгөгдсөн амлалт юм.

5. Есүсийг дагадаг хүн танихгүй хүнээс зугтдаг. Учир нь Сатан хулгайлж, алж, сүйтгэхээр ирдэг хулгайчтай адил юм.

6. Есүс Бурхан гэдгээ батлан харуулсан. Есүс Өөрийгөө сайн Хоньчин, мөн Тэр болон Түүний Эцэг хоёр хоёул нэг юм хэмээн тунхаглаж байхад нь еврейчүүд Түүнийг Өөрийгөө Бурхантай адилгаж байна гэж боджээ. Хэрэв тэд Бурханыг дагадаг байсан бол Есүсийг өөрсдийнх нь Хоньчин гэдгийг ойлгох байсан. Исаиа ингэж зөгнөжээ: “Үзэгтүн, Эзэн БУРХАН хүч чадалтайгаар ирж, ... хоньчин мэт сүргээ хариулж, Өөрийн мутарт хургануудаа цуглуулан цээжиндээ тэврээд, хургатай хонийг алгуур хөтөлнө”

(Исаиа 40:10, 11).

### Хоньчины Дуулал

#### Дуулал 23

Эзэн бол миний хоньчин, Надад дутах зүйл нэг ч үгүй. Тэр намайг ногоон бэлчээрт хэвтүүлж, Дөлгөөн усны дэргэдүүр хөтөлдөг. Тэр миний сэтгэлийг сэргээдэг. Тэр Өөрийнхөө нэрийн төлөө Зөвийн замаар намайг хөтөлдөг. Үхлийн харанхуйн хөндийгөөр туулавч Би хор хөнөөлөөс айхгүй, Учир нь Та надтай хамт байна. Таны саваа, Таны таяг намайг тайвшруулдаг. Та миний дайснуудын өмнө надад ширээ засдаг. Та миний толгойг тосоор тосолсон. Аяга минь дүүрч бялхдаг. Саян сайхан хийгээд хайр энэрэл Насан туршид намайг лавтай яа дагана. Би ЭЗЭНИЙ өргөөнд мөнхөд оршин суух болно.



## БҮЛЭГ 16. ЕСҮС БОЛ ДАХИН АМИЛАЛТ БА АМЬ ЮМ

Иохан 11:1-7; 17-46

Бетаны Лазар гэгч эр өвчтэй байлаа. Бетан бол Марта, түүний дүү Мариа хоёрын тосгон болой. Мариа бол Эзэнийг тосоор тослоод, Түүний хөлийг үсээрээ арчсан тэр эмэгтэй байв. Түүний ах Лазар нь өвчтэй байв. Тиймээс эгч дүүс Есүст хүн илгээж

-Эзэн минь, хараач, Таны хайрладаг хүн овдов хэмээн хэлүүлэв. Үүнийг сонсоод Есүс - Энэ овчин үхэл уруу биш, харин үүгээр Бурханы Хүү алдаршуулагдахын тулд, Бурханы алдрын төлөө юм гэлээ. Марта, түүний охин дүү болон ах Лазарыг нь Есүс хайрладаг байлаа. Лазарын өвдсөнийг сонсоод, Есүс байсан газраа хоёр хонов. Дараа нь Тэр шавь нартаа – Бүгдээрээ дахиж Иудей уруу явцгаая гэв.

Есүс ирээд, Лазар булшинд дорвон хоног байсныг мэдэв. Бетан Иерусалимаас холгүй арван таван стадио ормын тэртээ байдаг аж. Ахаасаа хагацсан Марта, Мариа нарыг тайтгаруулахаар олон нудейчүүд тэднийд иржээ. Тэгтэл Марта Есүсний ирж байгааг дуулаад, угтахаар гарав. Харин Мариа гэртээ суусаар үлдлээ. Марта Есүст

- Эзэн, Та энд байсан бол миний ах үхэхгүй байх байсан. [Тийм

боловч] одоо Та Бурханаас юу ч гуйсан, Бурхан танд өгнө гэдгийг би мэдэж байна гэв. Есүс түүнд -Чиний ах амилна гэхэд Марта Түүнд

-Эцсийн өдрийн амилалтад тэр амилна гэдгийг би мэднэ гэв. Есүс Мартад

-Би бол амилалт ба амь мөн. Амьд богөөд надад итгэгч бүхэн хэзээ ч үхэхгүй. Чи үүнд итгэж байна уу? гэж асуув. Марта

- Тийм ээ, Эзэн. Та Бурханы Хүү болох Христ, ертөнцөд ирэх Нэгэн мөн гэдэгт би итгэсэн гэлээ. Үүнийг хэлээд тэр явж, дүү Мариагаа дуудаад, сэмхэн

- Багш энүүхэнд байна. Чамайг дуудаж байна гэхэд Мариа үүнийг сонсоод ухасхийн босож, Түүн уруу очив. Есүс төсгөнд хараахан хүрч очоогүй агаад харин Мартатай уулзсан тэр газраа л байж байлаа. Тэгтэл гэрт нь Мариатай байж, тайтгаруулж байсан нудейчүүд түүнийг ухасхийн босож гарч явахыг хараад араас нь дагав. Тэд түүнийг булшин дээр очин уйлахаар явлаа хэмээн боджээ. Мариа Есүсний байсан газар ирж, Түүнийг хараад Есүсний холд унаж,

- Эзэн, хэрэв Та энд байсан бол миний ах үхэхгүй байх байсан гэлээ. Есүс түүний уйлахыг болон

түүнтэй хамт ирсэн иудейчүүдийн уйлахыг хараад сүнс нь гүнээ шаналж, сэтгэл нь хөдөлж,

-Та нар түүнийг хаана тавьсан бэ? гэж асуухад тэд Түүнд

-Эээн, ирээд үз гэлээ. Есүс уйлав. Тэгтэл иудейчүүд – Тэр түүнд ямар их хайртай байсныг хараач гэцгээж байлаа. Харин тэдний зарим нь

- Сохор хүний нүдийг нээсэн энэ хүн түүнийг мөн үхүүлэхгүй байж чадаагүй юм байх даа гэв. Есүс дахнад л дотроо гүнээ шаналж, булш уруу хүрч ирэв. Энэ нь агуй байсан бөгөөд амыг нь хадаар тагласан байлаа. Есүс

-Хадыг зайлуул гэхэд талийгаачийн дүү Марта Түүнд

-Эээн, тэр үхээд дөрөв хонож байгаа тул одоо өмхий үнэр орсон байгаа гэж хэлэв.

Есүс Мартад - “Хэрэв чи итгэвэл Бурханы алдрыг харна” гэж Би чамд хэлээгүй бил үү? гэлээ. Тэгээд тэд хадыг зайлуулав. Есүс дээшээ харан

- Аав аа, Та Намайг сонссонд Танд Би талархаж байна. Та Намайг

үргэлж сонсдогийг Би мэдсэн. Та Намайг илгээсэн гэдэгт итгүүлэхийн тулд тойрон зогсох хүмүүсийн төлөө Би үүнийг хэллээ гэв. Тэр ийн айлдаад, чанга дуугаар

- Лазар, гараад ир гэж хашхирав. Үхсэн хүн гар, хөл нь оршуулгын боолтоор боолттой, нүүр нь алчуураар ороолттой чигээрээ гарч ирэв. Есүс тэдэнд

- Тайлж, түүнийг явуул гэв. Мариагийн ирсэн иудейчүүдээс олон хүн Есүсийн хийсэн зүйлийг хараад, Түүнд итгэжээ. Харин тэдний зарим нь фарисайчууд уруу очиж, Есүсийн хийсэн зүйлийг тэдэнд хэлшгээв.



### Бодох Зүйлс

Есүс Өөрийн найз нараа маш ихээр хайрласан гэдгийг мэдэх нь сайхан биш байна гэж үү? Хэрэв та Есүсийн юу хэлсэнийг нь хийдэг бол бас л Түүний найз нь мөн. (Иохан 15:14). Энэ түүхээс үзэхэд Есүсийн найз нарт маш хэцүү явдал тохиолдсон байна. Лазар ах нь үхчихлээ. Анхандаа энэ нь Есүс түүнд санаа тавиагүйгээс болсон юм шиг харагдаж байв. Та ямар нэгэн хэцүү байдалтай тулгарах үед чинь Бурхан санаа



тавихгүй байгаа юм шиг санагддаг уу? Бурхан хэзээ ч унтаа юм шиг байдаггүй. Харин Түүнд үргэлж төлөвлөгөө байдаг. Бид үргэлж Бурханд агуу их алдрыг авчрах ямар нэгэн зүйлийг хийнэ хэмээн Түүнд итгэсээр байх ёстой.

Бурхан танд ч гэсэн зориулсан төлөвлөгөө бий. Тэрээр таныг Өөрийн Хүү Есүс Христтэй адилхан болгохыг хүсэж байна. **“Бурханыг хайрладаг, Түүний зорилгын дагуу дуудагдсан хүмүүст сайны төлөө Бурхан бүх юмыг хамтдаа ажиллуулдаг гэдгийг бид мэднэ. Тэр Өөрийнхөө Хүүг олон ах дүүсийн дунд ууган нь байлгахын тулд, урьдаас мэдсэн хүмүүсээ Тэр бас Түүний дүртэй адил болгохоор урьдаас тогтоосон юм”** (Ром 8:28,29)

Тэгвэл яагаад бид хэцүү үеүүдийг туулах ёстой гэж? **“Ингэснээр та нарын итгэлийн баталгаа нь – галаар тунгаагдах боловч мөхөх алтнаас ч - илүү үнэтэй байн, Есүс Христийн илчлэлт дээр магтаал, алдар, хүндэтгэлд хүрэх юм.** (1Петр 1:7).

Есүс Марта, Мариа болон бид нарт ч мөн Өөрт нь итгэдэг хүн хэзээ ч үхэхгүй гэдгийг заахыг хүссэн юм. Есүст итгэдэг хүмүүс үхэхдээ **“биеэсээ холдон явдаг”** бөгөөд **“Эзэнтэй хамт байдаг”**.

Мөн Есүс үхсэн хүнийг зөвхөн нэрээр нь дуудаад л амьдруулж чадна гэдгээ батлан харуулсан. [Лазар өөрийг нь дуудаж буй Есүсийн дууг сонсоод амьдарсан]. Есүс энэ дэлхийд дахин ирэхэд **“Үхэгсэд Бурханы Хүүгийн дууг сонсох бөгөөд сонсогчид нь амьдрах болно”** (Иохан 5:25).


Харин одоо Есүс таны зүрх сэтгэлийн хаалгыг тогшиж байна. **“Харагтун, Би үүдэн дээр зогсоод тогшиж байна. Хэрэв хэн нэгэн нь Миний дууг сонсоод хаалгаа нээвэл, Би түүний дотор орно”** (Илчлэлт 3:20). Түүний дууг сонсоод хаалгаа Түүнд нээн өгч Түүнийг дотроо урьж оруулсан хүмүүс шинэ бүтээл болдог. **“Та нар өөрсдийн нүгэл, хилэнц дотор үхсэн байв”** (Ефес 2:1). **“Түүнчлэн та нар өөрсдийнхөө нүгэлд үхсэн боловч Бурханд Христ Есүсээр амьд байгаа хэмээн тооц. Тиймээс биеийнхээ тачаангуй хүслүүдэд дуулгавартай байх ёстой хэмээдэг үхлийн биед чинь нүгэл**

бүү ноёрхог. Биеийнхээ эрхтнүүдийг зөвт бус байдлын зэвсэг болгон нүгэлд бүү өргө. Харин Бурханд өөрсдийгөө үхэгсдээс амьд болгогсад мэт, мөн биеийнхээ эрхтнүүдийг зөвт байдлын зэвсэг болгон Бурханд өргө” (Ром 6:11-13).

### **Энэ Гайхамшиг Дуулгавартай байдлыг Шаардсан**

Та зөвхөн гайхамшиг л болохгүй бол ямар ч найдваргүй нөхцөл байдалтай тулгардаг уу? Бурханыг алдаршуулахын төлөө Есүс таны амьдралд олон хэцүү зүйлсийг зөвшөөрч болох боловч Мариа Марта хоёрт хайртай шиг танд ч мөн хайртай гэдгийг та бүү мартаарай: Тэр таныг хүлээгээгүй байхад чинь гайхамшиг төлөвлөсөн байж болох юм. Харин энэ гайхамшигт дуулгавартай байдал хэрэгтэй байсан гэдгийг анхаараарай. Есүс “Чулууг зайлуул” гэж айлдахад, хэдийгээр энэ нь үнэхээр тэнэг юм шиг санагдсан ч гэсэн тэд дуулгавартай дагасан юм. Үүний дараа Лазар булшнаас гараад ирэх нь тэр. Тэгтэл Есүс тэдэнд “Түүний боолтыг тайлаад, явуул” хэмээн айлдав.

Бид Бурханы хүч чадлын алдрыг харахын тулд биднээр хийлгэхийг хүсэж буй Ариун Сүнсний өчүүхэн зааварт ч гэсэн дуулгавартай байх ёстой. Бид дөнгөж 2%-ийн буруутай байсан ч бусдаас уучлалт гуйх хэрэгтэй л бол үүнийгээ хийх ёстой. Энэ нь магадгүй холдуулж өнхрүүлэх ёстой чулуу ч байж болох юм, хэрэв бид дуулгавартай л байх юм бол Есүс хүмүүсийн зүрх сэтгэлд гайхамшигаа үйлдэж чадна. Түүнийг гайхамшиг үйлдэх үед бид бүрэн чөлөөлөлтийг авч чадаагүй хүмүүст саад болж буй тэдгээр зүйлсээсээ салахад нь хайраар туслах хэрэгтэй. Есүс гайхамшиг үйлдэн найз нартаа тусалсан нь гайхалтай байгаагүй гэж үү?



## ТҮҮХ 17. ЗӨВЛӨЛ ЕСҮСИЙГ АЛАХААР ТӨЛӨВЛӨВ

Иохан 11:47-53

Тэгтэл ахлах тахилч нар болон фарисайчууд зовлолдож

- Бид юу хийх вэ? Энэ хүн олон тэмдгийг үйлдэж байна. Хэрэв бид Түүнийг ингээд орхивол, бүх хүмүүс Түүнд итгэнэ. Тэгвэл Ромчууд ирж, манай орныг болон үндэстнийг маань устгана даа гэжгээв. Харин тэдний нэг болох тэр жил тэргүүн тахилч болсон Канаф тэдэнд - Та нар юу ч мэдэхгүй, мөн бүх үндэстнээрээ мөхөхгүйн тулд ард түмний төлөө

нэг хүн үхэх нь дээр гэдгийг ч бодохгүй байна гэж хэлэв. Тэр энэ үгсний өөрийн санаагаар хэлээгүй. Харин тэр жилийн тэргүүн тахилч байсан учир тэрээр Есүсийн үндэстнийхээ төлөө үхэх тухай болон Түүний зөвхөн үндэстнийхээ төлөө бус, харин Бурханы тарсан хүүхдүүдийг бөөгнүүлж нэгтгэхийн төлөө үхэх тухай эш үзүүлжээ. Энэ одрөөс тэд Есүсийг алахаар төлөвлөв.

### Хааныг Эсэргүүцсэн нь

Еврейн зөвлөл Есүсийн гайхамшгуудыг харсан бөгөөд Абрахамыг бий болохоос өмнө Түүнийг Өөрийгөө Эцэгтэйгээ хамт “нэг” байсан хэмээн сургаж байсан сургаалыг нь ч хүртэл сонссон. Гэсэн хэдий ч тэд Есүс Израилийн амлагдсан Хаан байсан гэдэгт нь итгэсэнгүй.

Энэ үйл явдалд Еврейн удирдагчид өөрсдийн эрх мэдэл байр сууринаасаа буух хүсэлгүй байгаа нь харагдаж байна. Тэд Есүсийн сургаалт зүйрлэл дээр гардаг албатууд шиг байсан юм. Албатууд “Энэ хүн биднийг захирахыг бид үл хүснэ” (Лук 19:14) гэж хэлцгээж байжээ. Тиймд Еврейн удирдагчид үндэснийхээ аюулгүй байдлыг хангах үүднээс нэг хүнийг (Есүсийг) үхүүлэхээр шийджээ. Гэвч хэрэв Есүс Өөрийн амийг өгөх хүсэлгүй байсан бол тэд юу ч хийж чадахгүй байх байсан.

Дэлхийн эхлэлээс өмнө Есүсийг илгээх Бурханы зорилго нь зөвхөн Израил үндэстнийг бус харин бүх л дэлхийг аврахын тулд байсан юм. “Гэвч Түүнийг няцалж, өвтгөх нь Эзэний таалал байв. Хэрэв Тэр Өөрийгөө нүглийн төлөөх тахил болгон өргөвөл, Тэр үр удмаа үзэж, Өөрийн өдрүүдийг уртасган, ЭЗЭНий хүсэл нь Түүний гарт цэцэглэх болно” (Исаиа 53:10).

## ТҮҮХ 18. ҮНЭТ БЭЛЭГ БОЛСОН ТОСНЫ ТУХАЙ ТҮҮХ



Иохан 12:1-8

Тэгээд Дээгүүр Өнгөрөх баяраас зургаан өдрийн өмнө Есүс Бетанд иржээ. Тэнд Есүсийн үхлээс амилуулсан Лазар байлаа. Тэд тэнд Есүст зоог бэлдэж, Марта үйлчилж байв. Харин Есүстэй хамт тухлан сууж байсан

хүмүүсийн нэг нь Лазар байв. Тэгтэл Мариа маш үнэтэй цэвэр нардын нэг литра үнэрт тос аваад, Есүсийн хөлийг тослож, үсээрээ хөлийг нь арчив. Гэр нь тосны анхилам үнэрээр дүүрлээ. Харин Есүсийн шавь нарын нэг буюу Түүнийг барьж өгөхийг бодож байсан Искарнотын Иудас

- Яагаад энэ тосыг гурван зуун денараар зарж, ядууст өгсөнгүй вэ? гэв. Тэрээр ядуусын төлөө санаа тавьсандаа бус, харин хулгайч байсан болохоор тэгж хэлжээ. Тэр мөнгөний хүүдийг барьж, дотор нь хийснийг авчихдаг байжээ. Түүнийг орхи. Миний оршуулгын өдөрт зориулж Мариа үүнийг хадгалаг. Учир нь та нар үргэлж ядуустай цуг байна. Харин та нар Надтай үргэлж цуг байхгүй гэж айлдав.

### Есүс Бүх Хүндэтгэлийг Авах Зохистой нь

Есүс Лазарыг үхлээс амилуулахад Еврейн зөвлөл Түүнийг үхэх ёстой хэмээн үзжээ. Гэвч Есүсийн найз нар маш их баяртай, магтаалаар дүүрэн байсан бөгөөд Түүнийг хүндэтгэх онцгой оройн зоог барьжээ. Энэ үед Мариа Есүсийг жинхэнэ хэн бэ гэдгийг мэдэж байсан юм. Түүний Есүсийг хайрласан хайр нь Түүний хөлийг үнэт тосоор тосолж байснаас харагдаж байсан бөгөөд уг үнэт тос нь түүний 300 өдөр ажилласан ажлынх нь хөлстэй эн тэнцэж байв. Мариа Есүсийн хэлж байсан үгнээс Тэрээр цөөн хэдэн өдрийн дотор цовдлогдох гэж байгааг нь ойлгожээ. (Матай 6:22).

**“Бидний Эзэн ба Бурхан минь, Та алдар, хүндэтгэл, хүчийг авах нь зохистой. Учир нь Та бүх юмсыг бүтээсэн билээ. Таны хүслийн улмаас тэдгээр нь оршсон бөгөөд бүтээгдсэн юм” (Илчлэлт 4:11).**

Хүн төрлөхтөн дотроос аврагдсад, хэл, хүмүүс болон үндэстнүүд дээш авагдахдаа арван мянган удаа арван мянган тэнгэр элч нартай хамт Есүсийг магтах болно гэсэн дүр зургийг Иохан бидэнд харуулсан билээ. Тэд чанга дуугаар **“Нядлуулсан Хурга хүч, баялаг, мэргэн ухаан, сүр хүч, хүндэтгэл, алдар ба магтаалыг авбал зохистой”** гэцгээж байлаа (Илчлэлт 5:12). Есүс бидний өгч чадах бүх л магтаал хүндэтгэлд зохистой!

### **Бид нар Есүст Бэлэг Өгч Чадна.**

Бид нар Есүст магтаал талархалаа өргөхийн тулд юу хийх хэрэгтэй вэ? Паул хэлэхдээ **“Иймд ах дүү нар аа, өөрсдийн биеэ Бурханд тааламжит амьд, ариун тахил болгон өргөхийг Бурханы өршөөлөөр та нараас хичээнгүйлэн гуйя. Энэ нь та нарын сүнслэг мөргөл нь мөн. Энэ үеийн явдалд бүү нийцэгтүн. Харин Бурханы хүсэл юу болохыг, тухайлбайл сайн, тааламжит, төгс төгөлдөр хүслийг батлахын тул оюун ухаанаа шинэчлэн өөрчлөгдөгтүн”** (Ром 12:1,2). Тиймд өөрсдийн биеэ Түүнд тааламжит амьд тахил болгон өргөцгөөе. Дэлхийн зүйлсийг бодохын оронд Түүний Нэр, Түүний Үг болон Түүний үйлсийн талаар бодохын тулд өөрсдийн оюун ухаанаа Түүнд өгцгөөе.

Мэдээж, зарим хүмүүс Бурханд үйлчилсэнээр амьдрал болон авьяас чадвараа дэмий үрж байна гэж бодож болох юм. Иудас Мариагийн золиосолсон бэлэг нь дэмий үрэгдэж байна гэж бодоогүй гэж үү? Гэвч өнөөдөр Иудас хаана байгаа вэ? **“Шударга зөв хүний тухай дурсамж нь ерөөлтэй бол Хар санаатны нэр ой гутаана”**(Сургаалт үгс 10:7). **“Зөв шударга хүн мөнхөд дурсагдах болно”**(Дуулал 112:6.б).

Бид Христэд итгэгч ахан дүүсээ хайрлаж байхдаа тэдний дотор байгаа Христийг хүндэлж байдаг. Та итгэгч эцэг эх, хань

ижил, үр хүүхдүүдтэйгээ Есүстэй харилцдаг шигээ харилцдаг уу? Бид мөн дайснаа хүндэлж байвал Есүсийг хүндэлж байна гэсэн үг. Учир нь Есүс биднийг ийнхүү үйлд хэмээн биднээс хүссэн. (Матай 5:44).

“Христ биднийг хайрласан бөгөөд Өөрийгөө бидний төлөө “Бурханд анхилуун үнэрт өргөл ба тахил болгон өргөсний адил хайр дотор яв”(Ефес 5:2). “[Тиймд] Түүгээр дамжуулан Бурханд Түүний нэрийг хүлээн зөвшөөрдөг уруулын үр жимс буюу магтаалын тахилыг үргэлж өргөцгөө”(Еврей 13:15).

## ТҮҮХ 19. ДАРУУ ХААНЫ ТҮҮХ



Иохан 12:12-16

Маргааш нь баярт ирсэн үй олон хүн Есүсийг Иерусалим уруу ирж явааг сонсоод , далдуу модны

мочрийг барьж, Түүнийг угтахаар гарч,

- Хосанна! Эзэний нэрээр Ирэгч, Израилын Хаан ерөөлтэй ээ! гэж хашхиралдаж байлаа. Есүс залуу илжиг олж унасан байв. Энэ нь “Сионы охин оо, бүү ай! Харагтун, Хаан чинь илжигний дудран унаад ирж байна” гэж бичигдсэнчлэн болов. Шавь нар нь эдгээр зүйлсийг анхандаа ойлгоогүй ажээ. Харин Есүсийг алдарших үед эдгээр нь Түүний тухай бичсэн байсныг, мөн хүмүүс Түүнд эдгээрийг үйлдсэн гэдгийг нь санажээ.

**Есүс Өргөмжлөгдсөн Хаан Болох Болно.**

Хуучин Гэрээний үеийн нэгэн эш үзүүлэгч ингэж хэлжээ: “Сионы охин оо, үлэмж ихээр баярлагтун! Иерусалемын охин оо, Ялалтын уухай хадаагтун! Үзэгтүн, хаан чинь чам

уруу очиж байна. Тэр бол зөв шударга, ялагдашгүй, даруу бөгөөд илжиг унажээ” (Зехариа 9:9). Тийм ээ Есүс эгэл хүн, Аврагч мөн зэрц болон энэ дэлхийд ирнэ гэж эш үзүүлэгчдээр дамжуулан урьдаас хэлүүлж байсан бөгөөд Түүний амьдрал, үхэл ба дахин амилалтын тухай эш үзүүллэг нь биелэгдсэн. Гэхдээ үүнээс гурав дахин илүү эш үзүүллэг Түүнийг 1000 жилийн турш Өргөмжлөгдсөн Хаан болон хаанчлахаар энэ дэлхий дээр ирэх үед биелэх болно. “Учир нь Эзэн өөрөө тушаалын үгтэй, тэргүүн тэнгэр элчийн дуу Бурханы бүрэн дуунаар тэнгэрээс бууж ирнэ. Тэгээд Христийн дотор үхэгсэд амилах болно. Дараа нь амьд хийгээд үлдсэн бид тэдэнтэй хамт агаар мандалд Эзэнтэй уулзахаар үүлэн дотор өргөгдөж, тийнхүү Эзэнтэй үргэлж хамт байх болно”(1Тесалоник 4:16,17).

“Тэр үед Эзэн Есүс хүчирхэг тэнгэр элч нарынхаа хамт дүрэлзэх гал дотор тэнгэрээс илчлэгдэн, Бурханыг мэддэггүй ба бидний Эзэн Есүсийн сайн мэдээг дагадаггүй хүмүүсээс өшөө авах ажээ” (2Тесалоник 1:7б,8).

### **Түүнийг Ирэхэд Та Бэлэн Байна уу?**

Бурхан үргэлж амлалтаа биелүүлдэг. Тэрээр Өөрийн дахин ирэх өдрийг хойшлуулсан нь олон хүмүүсийг аврагдахын тулд байлаа. “Ерөөлийг өвлүүлэх зорилгын үүднээс та нарыг дуудсан тул та нар мууг муугаар, эсвэл доромжлолыг доромжлолоор хариулахын оронд ерөөгтүн” (2 Петер 3:9). Гэвч Тэр удахгүй ирнэ! Харин та бэлэн үү: ариун амьдарч, бусдыг Түүн рүү аваачиж байна уу? “Учир нь “Амиа хайрлаж, сайн өдрүүдийг үзэхийг хүсдэг хүн Бузар муугаас хэлээ, заль мэхийн үгсээс уруулаа хорьж болиул. Тэгээд бузар муугаас эргэж, сайныг үйлд. Амар тайвныг хай, түүнийг мөшгө!” (2 Петер 3:10,11).

## ТҮҮХ 20. УЛААН БУУДАЙН ҮРНИЙ ТҮҮХ



Иохан 12:24-26

Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье.  
Хэрэв улаан буудайн үр газар

унаад үхэхгүй бол тэр ганцаараа  
үлдэнэ. Харин хэрвээ тэр үхвэл  
олон үр бий болгоно. Өөрийн  
амийг хайрлагч хүн түүнийгээ  
алдана. Энэ ертөнцөд өөрийн  
амийг үзэн яддаг хүн түүнийгээ  
мөнх аминд хүртэл хамгаалах  
болно.

### Үхэх гэдэг нь Ямар Утгатай вэ?

Дахин амилах хүчийн өмнө үхэл байдаг. Энэ нь Христэд ч гэсэн, бид нарт ч гэсэн үнэн юм. Элч Паул бидэнд Христийн төлөө үхэх нь ямар утгатайг харуулсан. “Гэвч миний хувьд ололт байсан бүх юмсыг би Христийн төлөө гарз хохирол болгон тооцов.... Ингэхдээ би Түүнийг болон Түүний амилалтын хүч, зовлонгуудын нөхөрлөлийг таньж мэдэн, Түүний үхэлтэй адилхан болгогдож, үхэгсдээс амилуулагдахад хүрмээр байна”(Филиппой 3:7, 10a).

Христийг дуулгавартай дагана гэдэг нь зарим хүслүүдээ үхүүлэх ёстой гэсэн үг. Бид өөрсдийгөө үхүүлэх үед бидний дотроос Христийн хүч ажиллаж байдаг. Бидний хуучин хүн Христтэй хамт цовдлогдсон ба харин дуулгавартай байдал дотор шинэ хүн маань итгэлээр амьдардаг гэдгийг бид санах хэрэгтэй. “Би Христтэй хамт цовдлогдсон. Амьд байгаа нь би биш, харин миний дотор Христ амьд байна. Эдүгээ би махан биендээ амьд байгаа нь намайг хайрлаж, миний төлөө Өөрийгөө тушаасан Бурханы Хүүд итгэх итгэлээр амьдарч буй хэрэг юм” (Галат 2:20). “Учир нь хэрэв та нар махан биеийн дагуу амьдарвал үхэх ёстой. Харин та нар Сүнсээр биеийн үйлсийг үхэлд хүргэвэл амьдрах болно” (Ром 8:13).

Та өөрийнхөө амьдралд юуг үхүүлэх ёстой байна тэр зүйл дээрээ Ариун Сүнсээр удирдуулахыг зөвшөөрөх хэрэгтэй. Энэ нь таны зарим буруу зуршил, буруу хандлага байж болох юм.



Та эдгээр зүйлсээ үхүүлэхээр шийдэж, Бурханыг дуулгавартай дагах үед Түүний хүч чадал таны амьдралд шинэ зүйл бий болгох гэж байгааг та олж харах болно. Өөрөөр хэлбэл таны амьдралд шинэ зуршил, шинэ хандлага бий болж, ялалтаар дүүрэн амьдрахад чинь хүч өгөгдөнө гэсэн үг юм. **“Учир нь Өөрийн сайн тааллын дагуух зүйлсийг үйлдүүлж, хүсүүлэхийн тулд та нарын дотор ажиллаж буй нь Бурхан юм”** (Филлиппой 2:13).

## ТҮҮХ 21. ЕСҮС ЖИШЭЭ БОЛОН ТУШААЛУУДААР ЗААН СУРГАВ.

Иохан 13:3-17; 34, 35


Эцэг нь бүх юмаа Өөрийнх нь мутарт өгснийг болон Бурханаас ирээд Бурхан уруу буцан явж байгаагаа Есүс мэдээд, зоогийн ширээнээс босож, гадуур хувцсаа тайлаад, алчуур авч бүслэв. Тэгээд саванд ус хийж, шавь нарынхаа хөлийг угаагаад, бүсэлсэн алчуураараа арчиж эхлэв. Есүс Симон Петр уруу ирэхэд Петр Түүнд

-Эзэн та миний хөлийг угаах гэж үү? гэв. Есүс түүнд хариулан

-Чи Миний юу хийж байгааг одоо мэдэхгүй. Харин чи хожим ойлгоно гэлээ. Петр түүнд

-Та миний хөлийг хэзээ ч угаахгүй шүү гэсэнд Есүс

-Хэрэв Би чамайг угаахгүй бол чи Надад хамаагүй болно гэлээ. Тэгтэл Симон Петр Түүнд – Эзэн, зөвхөн хөлийг минь ч биш, бас гар, толгойг минь угаагаач гэж хэлэв. Есүс



- Биеэ угаасан хүн хөлөө л угаах хэрэгтэй. Тэгвэл гүйцэд цэвэрхэн байна. Та нар цэвэр байна. Гэхдээ та нар бүгдээрээ биш шүү гэлээ. Учир нь Есүс Өөрийг нь барьж өгөх нэгнийг мэдэж байсан тул “Та нар бүгдээрээ биш шүү” гэж айлджээ. Тэгээд Тэр тэдний хөлийг угаасны дараа гадуур хувцсаа авч, дахин тухлан суугаад тэдэнд

- Та нарт Би юу хийж өгснийг мэдэж байна уу? Та нар намайг Багш, Эзэн гэж дууддаг. Та нар

зөв ярьж байна. Учир нь Би үнэхээр мөн. Тэгвэл Би Эзэн, Багш байтлаа та нарын хөлийг угаасан бол та нар мөн нэг нэгнийхээ хөлийг угаах ёстой. Учир нь Миний та нарт юу хийснийг та нар бас хийх хэрэгтэй гэж Би ийм жишээ үзүүлсэн юм. Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Боол нь эзнээсээ агуу биш, мөн илгээгдэгч нь илгээгчээсээ агуу биш

юм. Хэрэв та нар эдгээрийг мэдэж үйлдвэл ероолтэй.

Би та нарт бие биеэ хайрлагтун, Би та нарыг яаж хайрласны адил та нар мөн бие биеэ хайрлагтун гэсэн шинэ тушаал өгч байна. Хэрэв та нар бие биеэ хайрлах юм бол үүгээр чинь бүх хүн та нарыг Миний шавь нар мөн гэдгийг мэдэх болно гэж хэллээ.

### Хийх Зүйлс.

Есүс жишээгээр ямар хоёр зүйлийг харуулсан бэ?

1. Есүс тэдэнд “Тэгвэл би Эзэн, Багш байтлаа та нарын \_\_\_\_\_ бол та нар мөн нэг нэгнийхээ \_\_\_\_\_ ёстой (14).

2. Тэр бас “Би та нарыг яаж \_\_\_\_\_ адил та нар мөн бие биеэ \_\_\_\_\_” гэсэн шинэ тушаал өгч байна гэжээ (34).

### Баяр хөөрийн Нууц.

Хэрэв бид Есүсийн жишээг дагаж бусдад үйлчлэх юм бол баяр хөөртэй байх болно гэж Тэр хэлсэн байдаг. Бүтээгч Эзэн маань бидний өмнө бөхийж, Өөрийн дагалдагчдын хөлийг угаан зарц болон үйлчилсэн нь ямар агуу дүр зураг вэ! “Өөр хоорондоо Христ Есүст байсан тийм бодолтой бай! Тэрээр хэдийгээр Бурханы мөн чанараар оршин байсан боловч, Бурхантай тэгш байх явдлыг хадгалах зүйл гэж үзсэнгүй, харин Өөрийгөө хоослож, боолын дүрийг авч, хүнтэй адил болжээ. Хүн төрхийг олсон Тэрээр үхэлд ч төдийгүй загалмайн үхэлд ч дуулгавартай байснаараа Өөрийгөө даруу болгов. Тиймээс ч Бурхан Түүнийг үлэмжийн дээдээр өргөмжилсөн....” (Филиппой 2:5-9а).

Бусдад үйлчлэх боломжыг хайж, тэдний хэрэгцээнд санаа тавьцгаая. Хэрэв бид үүнийг хийвэл бид баяр хөөртэй байх болно. Учир нь Тэр Өөрөө бидний төлөө үүнийг үйлдсэн юм.

## ТҮҮХ 22 ГАЙХАМШИГТ ТАВАН АМЛАЛТ

### 1. Иохан 14:1-3, 6

Та нар зүрхээ бүү зовоо. Бурханд итгэ, мөн Надад итгэ. Миний Эцэгийн гэрт орон байр олон бий. Хэрэв тийм биш байсан бол Би та нарт хэлэх байсан. Би та нарт орон байр бэлдэхээр явна. Хэрэв Би явж та нарт орон байр бэлдвэл, дахин ирж, та нарыг Өөртөө авна. Би хаана байна, та нар мөн тэнд байх болно. Есүс – Би бол зам, үнэн, амь мөн. Хэн ч Надаар дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй.

### 2. Иохан 14:12

Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Надад итгэдэг хүн Миний хийдэг ажлуудыг бас хийх бөгөөд



эдгээрээ агуу ажлуудыг ч хийх болно. Яагаад гэвэл Би Эцэгтээ очно.

### 3. Иохан 14:13, 14

Та нар Миний нэрээр юуг ч гуйсан, Эцэг Хүүгээрээ алдаршуулагдахын тулд Би түүнийг хийнэ. Хэрэв та нар Миний нэрээр юуг ч Надаас гуйвал, Би түүнийг чинь хийнэ.

### 4. Иохан 14:15-17

“Хэрэв та нар Намайг хайрладаг бол, Миний тушаалуудыг сахь. Би Эцэгээсээ гуйхад, Тэр та нарт оор Туслалчийг өгнө. Тэр нь та нартай үүрд хамт байна. Тэр бол үнэний Сүнс мөн бөгөөд Түүнийг харахгүй, мэдэхгүйгээсээ болж, ертөнц Түүнийг хүлээж авч чадахгүй. Харин та нар Түүнийг мэднэ. Яагаад гэвэл Тэр та нартай хамт үргэлж байх бөгөөд та нарын дотор байна.

### 5. Иохан 14:17

Амар амгаланг Би та нарт үлдээнэ. Би Өөрийн амар амгалангаа та нарт өгнө. Ертөнцийн өгдгөөс оор юмыг Би та нарт өгч байна. Та нар зүрхээ бүү зовоо. Бүү ай.

1. Есүс Өөрийг нь дагадаг хүмүүст **байр бэлдэнэ** хэмээн амласан. (Иохан 14:1-3,6).

2. Есүс Эцэг уруугаа очих байсан учраас итгэгчдэд **агуу хүч** өгөхөөр амласан. Учир нь Түүний Сүнсийг авсан итгэгч хүмүүс Есүс энэ дэлхийд ирээд хийж байсан ажлуудаас нь ч илүү агуу ажлуудыг хийхийн тулд байсан юм. (Иохан 14:12).

3. Есүс Өөрийнхөө хүмүүст **гуйлтын онцгой эрхийг** өгөхөөр амласан. (Иохан 14:13,14).

4. Есүс бүх дагалдагчиддаа **гайхалтай оршихуйгаа** өгөхөөр амласан. Ариун Сүнс бууж ирсэнээр Есүс дагалдагчидтайгаа зөвхөн хамт байгаад зогсохгүй тэдний дотор амьдрах юм. (Иохан 14:15-17).

5. Есүс энэ дэлхийн өгч чадахааргүй тийм **агуу их амар тайвныг** өгөхөөр амласан. (Иохан 14:27). Бид хэзээ ч айх хэрэггүй. "Учир нь **та нарын дотор байгаа Тэр бол дэлхийд байгч нэгнээс агуу**" (1Иохан 4:4).

### **Хийх Зүйлс**

А. Есүс тантай ярьж байгаа юм шиг та эдгээр ишлэлүүдийг дахиад нэг анхааралтай унш. Тэгээд цаасан дээр Есүс болон Ариун Сүнс *таны* төлөө хийх болно гэж Түүний хэлсэн амлалтуудыг доош нь жагсааж бич.

Б. Иохан 14-р бүлгээс танд хамгийн онцгой байсан гурван ишлэлийг сонгоод цээжил. Лавлаж харахын тулд энд бич.

## ТҮҮХ 23. ДАРСНЫ ТҮҮХ.



### Иохан 15:1-11

Би бол усан үзмийн жинхэнэ мод, Эцэг минь усан үзэм тарналагч билээ. Миний дотор байгч жимс ургуулдаггүй мөчир бүрийг Тэр авч хаяна. Жимс ургуулдаг мөчир бүрийг их жимстэй болгохын тулд Тэр тайрч арчилдаг. Миний хэлсэн үгнээс болж та нар хэдийнээ цэвэр болжээ. Миний дотор байгтун. Би ч та нарын дотор байна. Усан үзмийн модонд холбогдохгүй юм бол мөчир өөрөөсөө жимс ургуулж чадахгүйн адил хэрэв та нар Миний дотор байхгүй бол тийм байх болно. Би

бол усан үзмийн мод, та нар бол мөчрүүд. Хүн Миний дотор байж, Би мөн түүний дотор байвал, тэр хүн их жимс ургуулна. Учир нь Надаас салангид хүн байвал та нар юу ч хийж чадахгүй. Хэрэв хэн нэг нь Миний дотор байхгүй бол мөчир мэт хаягдаж, хувхайрна. Хүмүүс тэдгээр мөчрүүдийг түүж, галд хаяхад шатна. Хэрэв та нар Миний дотор, Миний үгс та нарын дотор байвал та нар юу хүссэнээ гүй. Тэгвэл та нарын голөө биелэх болно. Та нарын их жимс ургуулсанаар Эцэг минь алдаршуулагдана. Ийнхүү та нар Миний шавь нар байх болно. Эцэг Намайг яаж хайрласан шиг Би бас та нарыг хайрласан. Миний хайр дотор байгтун. Би Эцэгийнхээ тушаалыг сахьж, Түүний хайр дотор байдгийн адил та нар Миний тушаалыг сахивал Миний хайр дотор байх болно. Миний баяр баясгалан та нар дотор байж, та нарын баяр баясгалан нь дүүрэн болохын тулд энэ бүхнийг Би та нар т хэлэв.

### Христ дотор Тэвчих

Хэрвээ бид Христэд итгээд Түүнээс уучлал, ариусгал болон шинэ амьдралыг хүлээн авсан юм бол цаашид Христэд амьдралынхаа турш Ариун Сүнсээр үргэлж удирдуулан амьдрах ёстой. Бид өөрсдийнхөө хүчинд найдаж өөрсдийн авьяас чадвараар амьдарч чадна гэж хэзээ ч бодож болохгүй.

Пууль хэлэхдээ: “Та нар тийм мунхаг гэж үү? Сүнсээр эхэлж, одоо та нар махан биеэр төгс болгогдож байна гэж үү?” (Галат 3:3).

Заримдаа Есүс биднийг ариутгах юм уу эсвэл тайрах хэрэгтэй байдаг. Энэ нь бид хэцүү зовлонтой, шалгалтын үе мөчүүдтэй тулгардаг гэсэн үг юм. Учир нь Тэр биднийг улам илүү их үр жимсийг гаргаасай гэж хүсдэг. “Бүх сахилга нь тухайн үедээ баяр хөөртэй бус, харин уй гашуутай мэт санагдавч дараа нь энэ нь түүгээр сургагдсан хүмүүст зөвт байдлын амар амгалан бүхий үр жимсийг төрүүлж өгдөг” (Еврей 12:11).

### **Сүнслэг Үр Жимс гэж Юу вэ?**

Пууль хэлэхдээ : “Харин Сүнсний үр жимс нь хайр, баяр баясгалан, амар тайван, тэвчээр, энэрэл, сайхан сэтгэл, итгэлтэй байдал, дөлгөөн зан, өөрийгөө захирах байдал нь юм” (Галат 5:22, 23) гэжээ. Та Есүсээс өөрийгөөгөө ариусгаж, өдөр бүр Ариун Сүнсээр дүүрэхийг Түүнээс гуйвал та амьдралдаа улам их үзэсгэлэнтэй үр жимсүүдийг гаргах болно.

Зөвт байдлын үр жимсэнд талархагч болон дуулагч зүрх, даруу сүнс, бусдад Есүсийг таниулах, Бурханы ажилд өөрийгөө зориулах, цагийг дэмий үрэхгүй байх, Бурханы үгийг зоригтойгоор ярих ба гуйлтын хариултыг харах зэрэг нь ордог.

### **Чухал Анхааруулга.**

Хэрэв бид үргэлж Христ дотор байхгүй бол хатсан, тасдагдсан, шатаагдсан мөчир болно шүү хэмээн Есүс бидэнд анхааруулж байна. Христ дотор үргэлж үр жимсийг гарган амьдардаг хүмүүс бол Түүний дагалдагчид юм. (6, 8-р ишлэл). Элч Иуда бидэнд ингэж сануулсан байдаг :

“Юу гэвэл, Эзэн Египетийн нутгаас ард түмнийг аварсны дараа итгээгүй хүмүүсийг устгасан юм”(Иуда 5).

Бид өөрсдөө үр жимс гаргаж чадахгүй тул яг толинд харж байгаа юм шиг Бурханы Үгнээс өөрсдийгөө олж харах хэрэгтэй. “Та нар итгэл дотор байгаа эсэхээ шалга, өөрсдийгөө

**батал... Есүс Христ та нарын дотор байгаа..."** (2Коринт 13:5). Хэрвээ бидний дотор Есүсийн үг байвал бид Түүний юу хэлсэнийг нь дуулгавартай дагаж, Түүний хайр дотор үргэлж амьдарч чадна. (Иохан 15:10). Хэрэв бид Христийн Сүнс бидний дотор байгаа гэдгийг мэдэх юм бол юунаас айх хэрэггүй болно. Учир нь бид Түүнийх гэдгийн *баталгаа нь* Ариун Сүнс юм. Мөн хайр нь маш чухал шалгуур болж чаддаг гэдгийг санагтун. **"Бурхан бол хайр мөн. Хайрын дотор байгч нэгэн нь Бурханы дотор байж, Бурхан түүний дотор байна"**(1Иохан 4:16.б). Бурхан таныг яаж хайрлаж байна, яг тэр хайр дотроо яв!

## **ТҮҮХ 24. БИД НАЙЗУУД БОЛОХООР СОНГОГДСОН!**

Иохан 15:12-27

Би та нарыг яаж хайрласан шиг та нарбие биеэ хайрлагтун. Энэ бол Миний тушаал. Нөхдийнхөө төлөө амиа зориулахаас оор агуу хайр байхгүй. Хэрэв та нар Миний тушаасныг хийвэл, та нар Миний ноход мөн. Би та нарыг боолууд хэмээн дахиж дуудахгүй. Учир нь Эзэнийхээ юу хийж байгааг боол мэддэггүй юм. Харин Би та нарыг анд нөхөд хэмээн дуудав. Учир нь

Би Эцэгээсээ сонссон бүхнээ та нарт мэдүүлсэн билээ. Та нар Намайг сонгоогүй, харин Би та нарыг сонгосон. Та нарыг явж, үр жимс ургуулж, та нарын үр жимс үүрд байгаасай гэсэндээ Би та нарыг төмилсөн. Ингэснээр Миний нэрээр та нар Эцэгээс юуг ч гуйсан Тэр та нарт огох юм. Би та нарт үүнийг тушаая. Та нар бие биеэ хайрлагтун.

## **ТҮҮХ 25. ЕСҮС БИДЭНД ХАВЧЛАГЫГ ХҮЛЭЭН АВАХ ТУХАЙ ЗААСАН**

Иохан 15:18-25

Хэрэв ертөнц та нарыг үзэн ядвал, та нараас омнө Намайг үзэн ядсаныг нь мэдэгтүн. Хэрэв та нар

ертөнцийнх байсан бол, ертөнц өөрийнхнийгөө хайрлахсан. Харин та нар ертөнцийнх биш,

гагцхүү Би та нарыг ертөнцөөс сонгосон юм. Тиймээс ертөнц та нарыг үзэн яддаг. “Боол эзнээсээ илүү агуу биш” гэж Би та нарт хэлсэнийг санагтун. Хэрэв тэд Намайг хавчсан бол, та нарыг бас хавчих болно. Хэрэв тэд Миний үгсийг сахьсан бол, та нарынхыг бас сахих болно. Харин тэд Миний нэрээс болж та нарт энэ бүгдийг хийх болно. Учир нь тэд Намайг илгээсэн Нэгэнийг мэдэхгүй юм. Хэрэв Би ирж, тэдэнд хэлээгүйсэн бол тэд гэм

буруугүй байх байсан. Харин одоо тэд өөрсдийн нүгэлд шалтаг байхгүй боллоо. Намайг үзэн яддаг хүн Миний Эцэгийг ч мөн үзэн яддаг. Хэрэв Би оор хэний ч хийгээгүй ажлуудыг тэдний дунд хийгээгүйсэн бол, тэд гэм буруугүй байх байсан. Харин одоо тэд Намайг болон Эцэгийг минь үзээд, хоёуланг минь үзэн ядаж байна. Харин “Тэд шалтгаангүйгээр Намайг үзэн ядсан” гэж тэдний Хуульд бичигдсэн үг биелэгдэхийн тулд тэд үүнийг үйлдсэн.

### Иохан 16:1-3, 33

Та нарыг бүдрэхэе хамгаалахын тулд эдгээр зүйлсийг Би та нарт хэлтээ. Тэд та нарыг санаагоос хооно. Харин та нарыг алах хүн бүр өөрийгөө Бурханд үйлчилж байна гэж бодох цаг ирж байна. Тэд Эцэгийг болон Намайг

мэдээгүй учраас тийм юм хийх болно.

Миний дотор та нарыг амар амгалан байг гэж Би та нарт эдгээр зүйлсийг хэлтээ. Ертөнцөд та нар зөв юмтой байна. Гэвч зоригтой байгтун. Би ертөнцийг ялсан гэж айлчлаа.

### Хийх Зүйлс

1. Христэд итгэгчид \_\_\_\_\_ биш учраас ертөнц тэднийг үзэн яддаг. (15:19).
2. Есүс “Намайг үзэн яддаг хүн Миний \_\_\_\_\_ ч мөн үзэн яддаг. (15: 23).
3. Тэр ч бүү хэл Есүс дэлхий дээр байх хугацаандаа олон гайхамшигт үйлс хийж байхад тэд Намайг болон Эцэгийг минь \_\_\_\_\_, хоёуланг минь \_\_\_\_\_ байна. (15: 24).
4. Үнэндээ ертөнц Түүнийг \_\_\_\_\_ үзэн ядсан юм. (15: 25).
5. Харин та нарыг \_\_\_\_\_ хүн бүр өөрийгөө \_\_\_\_\_ үйлчилж байна гэж бодох цаг ирж байна. (16: 2).
6. Тэд Эцэгийг болон Намайг \_\_\_\_\_ учраас тийм юм хийх болно. (16: 3).



7. Ертөнцөд та нар зовлонтой байна. Гэвч зоригтой байгтун. Учир нь Есүс ертөнцийг \_\_\_\_\_ юм. (16: 33).

## ТҮҮХ 26. ЕСҮС БИДНИЙ ТӨЛӨӨ ЗАЛБИРДАГ

Иохан 17:1-8, 15-26

Ингэж хэлээд, Есүс тэнгэр өөд мэлмий оргон

- Аав аа, цаг нь ирлээ. Таныг Хүү чинь алдаршуулахын тулд Хүүгээ алдаршуулаач. Таны Надад өгсөн бүх хүнд Хүү чинь мөнх амийг огөхийн тулд бүх махан биенийг захирах эрхийг Та Надад хэлсэн билээ. Цорын ганц үнэн Бурхан Таныг болон Таны илгээсэн Есүс Христийг мэдэх нь мөнхийн амь мон. Хий гэж Надад өгсөн ажлыг тань гүйцэтгэн Би таныг газар дээр алдаршуулав. Одоо, Ааваа, ертөнцийг бүтээхээс өмнө Тантай хамт Надад байсан сүр жавхлангаар Та Намайг Өөрийнхоо хамт алдаршуулаач. Ертөнцоос Таны Надад өгсөн хүмүүст Би Таны нэрийг илэрхийлээн. Тэд Таных байсан бөгөөд Та тэднийг Надад өгсөн. Тэд Таны үгийг сахьсан юм. Таны Надад өгсөн алив бүхэн нь Танаас ирсэн гэдгийг одоо тэд мэдэв. Учир нь Таны Надад өгсөн үгсийг Би тэдэнд өгсөн. Тэдгээрийг тэд хүлээн авч, Намайг Танаас гарч ирсэнийг үнэхээр ойлгоод, Таныг Намайг илгээсэн гэдэгт итгэсэн юм.



Би Танаас тэднийг ертөнцоос аваач гэж гуйхгүй, харин тэднийг муугаас хамгаалаач гэж гуйж байна. Би ертөнцийнх биш адил тэд бас ертөнцийнх биш. Үнэн дотор тэднийг ариусгаач. Таны үг бол үнэн мон. Та Намайг ертөнц уруу илгээсний адил Би тэднийг мөн ертөнц уруу илгээв. Тэд бас өөрсдөө үнэн дотор ариусгагдахын тулд Би Өөрийнхоо тэдний толоо ариусгана. Би зовхон тэдний толоо бус, тэдний үгээр дамжуулан Надад итгэх хүмүүсийн толоо гуйж байна. Энэ нь Эцэг Та Миний дотор, Би Таны дотор

байгаатай адил, тэд бүгдээрээ нэг байхын тулд бөгөөд мөн тэд Бидний дотор байж, Таны Намайг илгээсэн гэдэгт ертөнцийг итгүүлэхийн тулд Таны Надад огсон сүр жавхланг Би тэдэнд огсон билээ. Би тэдний дотор, Та Миний дотор байдаг. Ингэснээр тэд төгс нэгдэн, Таны Намайг илгээснийг болон Намайг хайрласны адил тэднийг хайрласныг ертөнц мэдэх болно. Аав аа, Таны Надад огсон хүмүүс бас Миний байх газарт Надтай

хамт байж, Миний сүр жавхланг үзээсэй гэж хүсэж байна. Тэр сүр жавхланг Та Надад огсон билээ. Учир нь ертөнцийн сууриас өмнө Та Намайг хайрласан. Зөвт Аав аа, ертөнц таныг мэдээгүй боловч Би Таныг мэдсэн. Мөн Таны Намайг илгээснийг тэд мэдсэн билээ. Би Таны нэрийг тэдэнд мэдүүлсэн бөгөөд мэдүүлэх болно. Ингэснээр Таны Намайг хайрласан тэр хайр тэдний дотор байж, Би ч гэсэн тэдний дотор байх юм гэлээ.

### **Есүс Таны Төлөө Залбирдаг.**

Месиа “хилэнцтнүүдийн төлөө зуучилсан” хэмээн эш үзүүлэгч Исаиа зөгнөсөн байдаг. (Исаиа 53:12). Учир нь Тэр Өөрийг нь хүлээн авсан бүгдэд мөнх амийг өгөхийг хүссэн юм. Түүнчлэн Есүс Өөрийн дагалдагчдынхаа төлөө залбирч байсан байна. Тэр Петрт хандан “Симон оо, Симон оо, үзтүгэй, чамайг улаан буудай мэт шигшихийн тул Сатан зөвшөөрөл гуйсан. Гэсэн ч итгэл чинь сульдахгүйн тулд Би чиний төлөө залбирсан”(Лук 22:31,32). Тэрээр үхэхийнхээ өмнөхөн хүртэл дагалдагчдынхаа төлөө тэднийг Муу Ёрын Нэгэн болох Сатанаас хамгаалж өгөхийн төлөө залбирч байсан төдийгүй тэдний итгэмжит гэрчлэлийн улмаас ирээдүйд Өөрт нь итгэх хүмүүсийн төлөө ч гэсэн залбирч байжээ. Өөрөөр хэлбэл Тэр таны төлөө залбирч байжээ!

Тэр таны төлөө үргэлж залбирдаг. “Тиймээс Тэр Өөрөөр нь дамжуулан Бурханд ойртогсдыг бүрэн төгс аврах чадвартай. Учир нь Тэр тэдний төлөө зуучлан залбирахын тулд үргэлж амьд байдаг” (Еврей 7:25). Бид ямар гайхалтай Аврагчтай юм бэ? Мөн Тэр биднийг Өөртэйгөө хамт нэг болгохын төлөө болон бие биенийгээ хайрлахын төлөө хэрхэн залбирдаг бол оо! Магадгүй өнөөдөр Түүний залбирал таны амьдралд болон таны гэр бүлд биелэлээ олсон байгаа.

Есүс Гетсемен цэцэрлэгт залбирсаныхаа дараа дагалдагчиддаа хандан “Та нар чинь Надтай хамт ганцхан цаг ч сэргэг байж чадахгүй улс уу?” гэжээ. (Матай 26:40). Та өдөр бүр хувьчлан Есүстэй цагийг өнгөрөөн алдагдсан хүмүүс ба Христийн бие болох Сүмийн төлөө залбирдаг уу? Өдөр бүр бид “нигүүлслийн хаан ширээнд” очиж Түүнтэй уулзах ямар агуу их эрхтэй юм бэ! “Тиймд бид хэрэгцээтэй цагт туслах нигүүлслийг олон, өршөөлийг хүлээн авахын тулд нигүүлслийн хаан ширээнд ойртон очигцоо” (Еврей 4:16).

## ТҮҮХ 27. ЕСҮСТ ӨӨРИЙН АМЬ БА ҮХЛИЙГ ЗАХИРАХ ХҮЧ ЧАДАЛ БАЙСАН

Иохан 10:17,18

Тиймээс Эцэг Намайг хайрладаг. Учир нь Би Өөрийн амийг буцааж авахын тулд амиа огно. Хэн ч Миний амийг Надаас авахгүй. Харин Би Өөрийн санаагаар түүнийг өгнө. Амиа огөх эрх мэдэл Надад бий. Буцааж авах эрх мэдэл ч Надад бий. Энэ тушаалыг Би Эцэгээсээ хүлээн авсан юм гэв.

Иохан 19: 4-11

Пилат дахин гарч ирээд хүмүүст - Харагтун, би Түүнээс ямар ч гэм бурууг олоогүйг та нарт мэдүүлэхийн тулд Түүнийг нааш нь авчирлаа гэв. Есүс үүргэнэн титэм, нил ягаан нөмрөгтэй гарч ирэв. Пилат тэдэнд – Энэ Хүнийг харагтун гэлээ. Тэгтэл ахлах тахилч нар, харуулууд Түүнийг хараад -



Цовдол, цовдол хэмээн хашхиралдлаа. Пилат тэдэнд - Өөрсдөө Түүнийг ав. Та нар цовдол. Миний хувьд Түүнээс ямар ч бурууг олсонгүй гэв. Иудейчүүд түүнд хандан - Бидэн хууль бий. Уг хуулийн дагуу бол Тэр үхэх ёстой. Яагаад гэвэл Тэр Өөрийгөө Бурханы Хүү болгосон юм гэнгээж байлаа. Пилат үүнийг сонсоод улам их айж, дахин ордондоо орж Есүсээ – Та хаанаас ирсэн юм бэ? гэж асуусанд Есүс түүнд юу ч хариулсангүй. Тиймд

Пилаг Түүнд - Та надад хэлэхгүй юм уу? Таныг суллах ба загалмайд цовдлох эрх мэдэл надад байгааг Та мэдэхгүй байна гэж үү? гэлээ. Есүс (түүнд) - Танд

дээрээс эрх мэдэл өгөгдөөгүй л бол, Миний эсрэг байх ямар ч эрх мэдэл баймааргүйсэн. Тиймээс Намайг танд тушаасан хүн нь илүү нүгэлтэй юм гэж айлдав.

### Есүс Үхэх Ёстой Байсан уу?

Есүс үнэхээр Бурханы Хүү болон ирсэнээс хойш Түүнийг алах боломж хүмүүст байсан бол уу? Хэнд ч Түүнийг захирах эрх мэдэл байгаагүй бөгөөд зөвхөн Тэр Өөрөө бидний төлөө үхэж, дахин амилахыг сонгосон юм. Есүс Пилатад хандан: "Миний хаанчлал бол энэ ертөнцийнх биш ээ. Хэрэв Миний хаанчлал энэ ертөнцийнх байсан бол Намайг Иудейчүүдийн гарт өгөхгүйн тулд Миний зарц нар тэмцэх байсан". (Иохан 18:36). Есүс Иудейчүүдэд Өөрийг нь барихыг зөвшөөрсөн юм. Тэр баригдаж байхдаа ингэж хэлжээ: "Арван хоёр легионоос олон тэнгэр элчийг одоохон Өөр уруугаа илгээхээр Би Эцгээсээ гуйж чадахгүй гэж чи бодож байна уу? Тэгвэл энэ нь болох ёстой гэсэн Судар яаж биелэгдэх билээ? гэв" (Матай 26:53,54). Хэрэв Есүс тэр цэцэрлэгт залбирсан бол Түүнд үйлчилж байсан тэнгэр элч нар Түүнийг баривчилсан цэргүүдийг устгаж чадах байсан. Гэвч Есүс Сударт илчлэгдсэн Бурханы зорилгыг мэдэж байсан юм.

Есүс Өөрөө ингэж хэлж байжээ: "Хүний Хүү олон зовлон эдэлж, ахлагчид, ахлах тахилч нар, болон хуулийн багш нарт ад үзэгдэж, алуулна. Тэгээд гурав дахь өдрөө амилна" (Лук 9:22). Дэлхийн эхлэлээс авахуулан Есүс үхэх нь Бурханы зорилго байсныг та харах болно. (Илчлэлт 13:8).

Есүс үхлийг ялан дийлэх нь Бурханы гайхамшигтай төлөвлөгөө байсан юм. "Тийнхүү хүүхдүүд нь цус ба махан биеийн тасархай болов. Түүнчлэн Тэр Өөрөө бас тасархай болсон. Ингэснээр Тэр үхлийн хүч буюу диаволыг үхлээрээ устгаж, бүх насаараа үхлийн айдсаар боолчлогдож байсан тэдгээр хүмүүсийг чөлөөлөх юм" (Еврей 2:14,15). Та үхлээс айдаг уу? Есүс таныг үхлийн айдсаас чөлөөлөхийн тулд үхсэн! Тийм ээ, Есүс таны төлөө Өөрийн амийг золиослохоор сонголт хийсэн юм!

## ТҮҮХ 28. ЕСҮС ЦОВДЛОГДООД БУЛШИНД ОРШУУЛАГДАВ

Иохан 19:17, 18, 30-37

“Иймээс тэд Есүсийг аваад явлаа. Есүс загалмайгаа үүрсээр еврейгээр Голгота буюу Гавлын Газар хэмээх газар уруу явав. Тэнд Түүнийг өөр хоёр хүний хамт хүмүүс цовдолжээ. Есүсийг дунд нь, хоёр талд нь тэднийг цовдлов.

Есүс цууг амсаж – Энэ нь төгслөө гээд, тэргүүнээ гудайлган сүнсээ даатгав. Тэр өдөр нь бэлтгэлийн өдөр байв. Амралтын одор цогцсуудыг загалмай дээр байлгах зохисгүй тул (мөн тэр Амралтын өдөр нь онцгой одор байсан учраас) иудейчүүд, тэдний хөлийг хугалж, тэднийг зайлуулахыг Пилатаас гуйжээ. Цэргүүд ирж, Есүстэй хамт цовдлогдсон эхний хүний болон нөгөө хүнийх нь холийг хугалав. Харин Есүс уруу ирээд Түүний хэдийнээ үхсэн байхыг тэд үзээд, хөлийг нь хугалсангүй. Цэргүүдийн нэг нь Түүнийг хажуу уруу нь жадлахад цус, ус гоожлоо. Харсан хүн нь үүнийг гэрчлэв. Түүний гэрчлэл нь үнэн бөгөөд та

нарыг ч мөн итгүүлэхийн тулд үнэн ярьдаг гэдгээ тэр мэднэ. Судрын “Түүний нэг ч яс хугалагдахгүй” гэсэн нь биелэгдэхийн тулд эдгээр нь болжээ. “Тэд жадалсан хүн уруугаа харах болно” гэж мөн өөр Сударт хэлдэг.



Иохан 19:40-42

Тэд Есүсийн цогцсыг авч, иудейчүүдийн заншил ёсоор анхилуун үнэртэнтэй маалинган даавуугаар ороов. Түүнийг цовдолсон газарт цэцэрлэг байсан бөгөөд тэнд хэнийг ч тавиагүй шинэ хадан булш байлаа.

**Христийн Үхэл нь Санамсаргүй Явдал Байсангүй.**

Библийг ойлгох түлхүүр нь бүх Судар Христ дээр төвлөрсөн гэдгийг ойлгох явдал юм.

“Тэгээд Тэр Мосегээс эхлэн бүх эш үзүүлэгчид, бүх Судар Өөрийнх нь тухай юу хэлснийг тэдэнд тайлбарлав. (Лук 24:27). Тэгээд Тэр тэдэнд ингэж айлдав. – Та нартай хамт байхдаа Миний ярьж байсан үг маань ийм болой. Энэ нь Мосегийн хууль, Эш үзүүлэгчид болоод Дуулал

дахь Миний тухай бичигдсэн бүхэн биелэгдэх ёстой” гэв. (Лук24:27) “Тэгээд Судрыг ухааруулахын тулд тэдний оюун ухааныг нээв. Есүс тэдэнд хандаж - Христ зовлон эдэлж, гурав дахь өдрөө үхэгсдээс амилах болно. Иерусалимаас эхлээд бүх үндэстэнд Түүний нэрээр нүглийн уучлалын гэмшил тунхаглагдах ёстой” гэж бичигдсэн юм. (Лук 24:45-47). Бурханы төлөвлөгөө ямар гайхамшигтай вэ? Хэрвээ танд Библи байгаа бол Хуучин Гэрээний үед Бурхан Өөрийн төлөвлөгөөгөө хэрхэн илэрхийлэн харуулж байсан, Есүс түүнийг нь хэрхэн биелүүлсэнийг доорхи Бичээсүүдээс харж болно. (Есүсийн анхны ирэлтийг харьцуулсан 300-хан эш үзүүллэг байдаг).

Сатан Бурханы бүтээлийг барьцаалан авсан боловч Бурханд үүнээс чөлөөлөх төлөвлөгөө байсан бөгөөд энэ нь хэрэгжсэн юм аа. Аврагдахыг хүсэж буй хүмүүс Сатаны боолчлолоос яг одоо чөлөөлөгдөж болно!

ЕСҮСТ ЗОРИУЛСАН БУРХАНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ	ЭШ ҮЗҮҮЛЛЭГ	БИЕЛЭЛТ
"Эмэгтэйн үр" амласан	Эхлэл 3:15	Галат 4:4
"Абрахамын үр" амласан	Мика 5:2	Матай 2:1
Онгон бүсгүйн төрөлт	Исаиа 7:14	Матай 1:18
Галил дахь үйлчлэл	Исаиа 9:1,2	Матай 4:12-16
Эш үзүүлэгч болно	Дэд хууль 18:15	Иохан 6:14
Тахилч болно	Дуулал 110:4	Еврей 6:20
Хаан болно	Исаиа 9:7	Иохан 18:36, 37
Еврейчүүдийн эсэргүүцэл	Исаиа 53:3	Иохан 1:11, 5:43
Ялгуулсан ирэлт	Зехириа 9:9	Иохан 12:13-15
Найзынх нь урвалт	Дуулал 41:9	Марк 14:10
Гучин мөнгөн зоосоор зарагдсан	Зехириа 9:9	Матай 26:15
Түүнийг яллах худал гэрчлэлүүд	Дуулал 27:12	Матай 26:60,61
Яллагдаж байхдаа чимээгүй байв	Исаиа 53:7	Матай 26:62,63
Жанчуулж алгадуулсан	Исаиа 50:6	Марк 14:65
Гэмтнүүдтэй хамт цовдлогдсон	Исаиа 53:12	Матай 27:38
Гар болон хөл нь хатгагдсан	Дуулал 22:16	Иохан 20:27
Шоолуулж доромжлуулсан	Дуулал 22: 6-8	Матай 27:39, 40
Цуу уулгахаар өгсөн	Дуулал 69:21	Иохан 19:29
Дайснуудынхаа төлөө залбирсан	Исаиа 53:12	Лук 23:34
Хажуу уруугаа жадлуулсан	Зехириа 12.10	Иохан 19:34
Нэг ч яс нь хугараагүй	Дуулал 34:20	Иохан 19:33
Тэр үхэндээ баян хүнтэй хамт байсан	Исаиа 53:9	Матай 27:57-60
Түүний Дахин амилалт	Дуулал 16:10	Матай 28:9
Тэр дээш өргөгдсөн	Дуулал 68:18	Лук 24:50, 51


(Есүсийн үхлийн тухай бүрэн мэдэхийн тулд Матай 26, 27; Марк 14, 15; Лук 22, 23; Иохан 18, 19; Исаиа 53; Дуулал 22-ийг уншаарай).

## ТҮҮХ 29. ЕСҮС ҮХЛЭЭС ДАХИН АМИЛСАН НЬ

Иохан 20:1-9

Долоо хоногийн эхний өдөр эрт харанхуй байхад Магдалын Мариа хадан булш уруу очиж, булшны амнаас хадыг зайлуулсан байхыг харав. Тэгээд Мариа Симон Петр болон Есүсийн хайртай байсан нөгөө шавь уруу нь гүйн ирж

- Тэд булшнаас Эзэнийг авчихжээ. Түүнийг тэд хаана тавьсныг бид мэдэхгүй гэж хэлэв. Тиймээс Петр нөгөө шавийн хамт булш уруу гүйв. Тэд хоёул хамтдаа гүйсэн боловч нөгөөдох нь Петрээс хурдан гүйж, булшинд түрүүлэн ирээд тонгойн хараад, даавуу байхыг л үзсэн боловч дотогш орсонгүй. Араас нь



Симон Петр ч гүйн ирэв. Тэр булш уруу орж, маалинган даавуу болон толгойг ороосон даавууг л харав. Даавуунууд байсан байрандаа эвхээтэй байжээ. Түрүүлэн ирсэн ногоо шавь булшинд орж ирэн, хараад итгэв. Учир нь Тэр үхэгдээс амилах ёстой гэсэн Судрыг тэд ойлгоогүй л байлаа.

### Дахин Амилалт Яагаад Маш Чухал вэ?

Иов олон жилийн өмнө энэ асуултыг асууж байжээ: “Хэрэв хүн үхвэл тэрээр амилах уу?” (Иохан 14:14) Түүний баяртай хариулт нь ийм байв: “Миний хувьд гэвэл, миний Золигч амьд гэдгийг болон эцэст Тэрээр дэлхий дээр байр сууриа эзэлнэ гэдгийг би мэднэ. Арьс минь устгагдсан хойно ч би махан биеэрээ Бурханыг харах болой”. (Иохан 19:25,26). Тиймээ Тэр амьд учраас бид ч гэсэн амьдрах болно. (Иохан 14:19).

“Учир нь Тэр мөхөс байдлаас болж цовдлогдсон боловч Бурханы хүчээр амьд байна. Бид мөн Түүний дотор мөхөс боловч та нарт хандсан Бурханы хүчээр Түүний хамт амьд байх болно” (2Коринт 13:4).

Бүх л баярын мэдээг Пууль хоёр ишлэлд багтаан дүгнэсэн байдаг: “Учир нь би хүлээн авсан дараах зүйлийг та нарт дамжуулсан юм. Энэ бол хамгийн чухал хэрэг байлаа.

Судрын дагуу Христ бидний нүглийн төлөө үхсэн бөгөөд оршуулагдан, Судрын дагуу гурав дахь өдөртөө амилуулагджээ” (1Коринт 15:3,4). Хэрвээ Есүс Христ дахин амилаагүй бол бид юуг ч тунхаглах хэрэггүй байх байсан бөгөөд бид ямар ч найдваргүйгээр өөрсдийн гэм нүгэл дотроо амьдарсаар сүйрэн үхэх байсан. Гэвч Бурханыг магтахад Есүс амьд төдийгүй таны дотор амьдарч чадна! “Мөн үхэгсдээс Есүсийг амилуулсан Нэгэний Сүнс та нарын дотор оршвоос, Христ Есүсийг үхэгсдээс амилуулсан Тэр та нарын дотор оршдог Өөрийн Сүнсээр дамжуулан үхлийн биест чинь амь өгнө” (Ром 8:11).

### Одоо Бид Түүний төлөө Амьдрах ёстой

“Нэг нь бүх хүмүүсийн төлөө үхсэн тул бүгд үхсэн гэж бид ятгагдсан тул Христийн хайр биднийг албаддаг. Тэр бүгдийн төлөө үхсэн учраас амьд байгсад цаашид өөрсдийн төлөө бус, харин өөрсдийнх нь төлөө үхээд, амилуулагдсан Түүний төлөө амьдрах ёстой”. (2Коринт 5:14,15). Христ бидний төлөө үхэх үед бид гэм дотроо үхсэн бөгөөд харин одоо Бурханы хувьд амьд байна. Бид Түүний дотор шинэ бүтээл болсон. Тиймд бид энэ шинэ амьдралаараа өөрсдийнхөө төлөө бус, харин *Түүний* төлөө амьдрах ёстой! Одоо та өөрөөсөө хамааралтай биш болсон. “Учир нь та нарыг үнээр худалдан авсан юм. Тиймээс биеэрээ Бурханы алдаршуулагтун” (1Коринт 6:20).

## ТҮҮХ 30. ЕСҮС МАРЬТ ҮЗЭГДЭВ

### Иохан 20:11- 17

Харин Мариа булшны гадаа зогсоод үйлж байлаа. Тэр үйлсэн чигээрээ булш уруу тонгойн харахад, цагаан хувцастай хоёр тэнгэр элч Есүсийн цогцсыг тавьсан газарт нэг нь толгойн тэнд, нөгөө нь

хөлөн талд сууж байв. Тэд түүнд - Эмэгтэй чи юунд уйлна вэ? гэсэнд тэр – Тэд Эзэнийг минь авчихсан байна. Тэд Түүнийг хаана тавьсныг би мэдэхгүй гэв. Тэр ингэж хэлээд эргэхдээ Есүсийн зогсож байхыг харсан боловч тэр нь Есүс байсныг





таньсангүй. Есүс түүнд – Эмэгтэй чи юунд уйлна вэ? Чи хэнийг

хайна вэ? гэж асуув. Түүнийг цэцэрлэгч байна гэж бодоод тэр Түүнд – Эзэгтэн, хэрэв та Түүнийг авсан бол хаана тавьснаа надад хэлнэ үү? Би Түүнийг авах гэсэн юм гэв. Гэтэл Есүс – Мариа гэлээ. Мариа эргэнгүүтээ Түүнд еврейгээр – Рабуни! (Багш гэсэн утгатай) гэжээ. Есүс – Би дээшээ Эцэгтээ хараахан очоогүй байгаа тул Надад гар бүү хүр. Харин Миний ах дүү нар уруу очиж, тэдэнд “Би Миний Эцэг ба та нарын Эцэгт, Миний Бурхан та нарын Бурханд очно” гэдгийг хэл гэлээ.

### Есүс Эмэгтэйг Хэрхэн Хүндэлдэг вэ?

Харанхуй зовлонтой үед ч тэр гэрэлт баяр хөөртэй үед ч тэр Есүс тэр эмэгтэйчүүдийг хүндэлсэн. Мөн Есүс загалмай дээр зовж байхдаа ээжтэйгээ ихэд уян зөөлөн ярилцаж, ээжийгээ Өөрийн хайрт дагалдагч болох Иоханаас халамжлаж байхыг хүссэн. (Иохан 19: 26,27). Харин дахин амилсаныхаа дараа эхлээд Марь хэмээх өөр нэгэн эмэгтэйд үзэгджээ.

Даруухан бөгөөд дуугүйхэн сүнсээр өөрийгөө чимсэн Бурханд найдагч эмэгтэй нь “Бурханы өмнө асар үнэтэй харагддаг” (1Петер 3:4). Бурхан хүнийг Өөрийнхөө дүр төрхөөр бүтээхдээ Өөрийгөө бүхэлд нь толинд харж байгаа юм шиг эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг төгс бүтээжээ. (Эхлэл 1:27). Сүнслэг зүйлсийн хувьд Бурхан эмэгтэй эрэгтэй хүмүүст хоёуланд нь Христ дээр ирж Түүний өв залгамжлалыг хүлээж авах адилхан боломжыг өгчээ.

“Эдгээрээр дамжуулан Тэр бидэнд үнэтэй бөгөөд гайхамшигт амлалтуудаа соёрхсон. Ингэснээр та нар .....бурханлаг мөн чанарыг хуваалцагч болох юм” (2Петр 1:4). “... эр ч гэж байхгүй, эм ч гэж байхгүй. Учир нь та нар бүгд Христ Есүс дотор нэг болой. (Галат 3:28.6).

Бурхан эмэгтэйчүүдийг маш их хүндэлдэг бөгөөд Тэрээр нөхрүүдэд Христ сүмийг хайрлаж Өөрийн амийг өгсөний адил эхнэрүүдээ хайрла хэмээн тушаасан байдаг. (Ефес 5:25). “Тиймээс нөхрүүд ч эхнэрүүдээ өөрийн бие адил хайрлах ёстой. Эхнэрээ хайрладаг хүн өөрийгөө хайрладаг (Ефес 5:28). Бурхан эхнэр нөхөр хоёрын хоорондын эв нэгдэл, таарамжийг таалдаг бөгөөд харин салалтыг үзэн яддаг. “Учир нь Би салалтыг үзэн яддаг гэж” түмэн цэргийн ЭЗЭН айлдаж байна...” (Малахи 2:16). “Адил сэтгэж, адил хайртай байж, сэтгэлээрээ нэгдэн намайг гүйцэд баярлуул. Юуг ч өрсөлдөх сэтгэлээр эсвэл бардам зангаар бүү хий. Харин даруухнаар бие биенийгээ өөрөөсөө дээр гэж үз. (Филиппой 2:2,3).

## ТҮҮХ 31. ЕСҮС ӨӨРИЙН ДАГАЛДАГЧИДДАА ХАРАГДАВ

Иохан 20:19-22

Долоо хоногийн эхний одор буюу тэр одрийн үдэш, шавь нар нь нудейчүүдээс айснаас хаалгаа түгжсэн байв. Гэтэл Есүс ирээд тэдний дунд зогсож, тэдэнд –Амар амгалан та нартай хамт байх болтугай гэв. Үүнийг айлдаад, Тэр тэдэнд гар хажуугаа үзүүлэв. Шавь нар нь Эзэнийг хараад ихэд баярлав. [Есүс] дахиж тэдэнд - Амар амгалан та нартай хамт байх болтугай. Эцэг Намайг илгээсний адил Би бас та нарыг илгээнэ гэв. Үүнийг айлдаад, Тэр



тэдэн уруу үлээн – Ариун Сүнснийг хүлээн авагтун гэв.

### Хийх Зүйлс


Есүс юу гэж хэлсэн бэ? Хоосон зайг нөхөж бич.

1. \_\_\_\_\_ та нартай хамт байх болтугай” (19).

2. “Эцэг Намайг илгээсний адил \_\_\_\_\_ бас \_\_\_\_\_” гэв. (21).

3. “Ариун Сүнсийг \_\_\_\_\_” (22).

## ТҮҮХ 32. ЭРГЭЛЗЭЖ БАЙСАН ДАГАЛДАГЧ НЬ ИТГЭВ



### Иохан 20:24-29

Харин арван хоёрын нэг болох ихэр гэгддэг Томас Есүсийг ирэх үед тэдэнтэй хамт байгаагүй ажээ. Бусад шавь нар нь түүнд – Бид Эзэнийг харсан гэж ярив. Харин тэр – Түүний гар дахь хадаасны сорвийг үзэж, хадаасны ормонд нь

хуруугаа хийн, Түүний хажуу уруунь хуруугаа хийж үзэхээс нааш би итгэхгүй гэж тэдэнд хэлжээ. Найман өдрийн дараа шавь нар гэрт дахин цуглахад Томас тэдэнтэй хамт байв. Хаалга нь түгжээтэй байсан боловч Есүс ирээд тэдний дунд зогсож – Амар амгалан та нартай хамт байх болтугай гэв. Тэгээд Тэр Томаст – Хуруугаа нааш нь хүргэ, Миний гарыг үз. Гараа нааш нь хүргэ, Миний хажуу уруу хий. Итгэлгүй бус, харин итгэлтэй бай гэхэд Томас Түүнд – Эзэн минь, Бурхан минь гэв. Есүс түүнд – Чи Намайг харсан учраас итгэв үү? Хараагүй атлаа итгэсэн хүмүүс нь ерөөлтэй ээ! гэжээ.

### Онцгой Ерөөл

Хэрэв та Есүсийг нүдээрээ хараагүй хирнээ Түүнд итгэсэн бол илүү ерөөгдөнө гэж Тэрээр хэлжээ. Өнөөдөр Есүс бидний дотор амьдарч байгааг бид Түүний Сүнсээр мэддэг. Бид бас Тэрээр бидэнтэй Библиер дамжуулан ярьдаг гэдгийг ч мэддэг.

Нэг л өдөр та бид нар Түүнийг харах болно. “Түүнийг үзэгдэх үед бид Түүнтэй адил болно гэдгийг мэднэ. Учир нь бид Түүнийг яг байгаагаар нь харах болно” (1Иохан 3:2.6).

“Зүрхэн дотроо цэвэр ариун байгч хүмүүс ерөөлтэй ээ! Учир нь тэд Эзэнийг харах болно” (Матай 5.8). “Харагтун, Тэр үүлсийн хамт ирэх бөгөөд нүд бүр Түүнийг харна. Тэр байтугай Түүнийг жадалсан хүмүүс ч харна. Дэлхийн бүх овгууд Түүнээс болж гашуудах болно (Илчлэлт 1:7). Та Есүсийг харах үедээ баяртай байх уу? эсвэл гунигтай байх уу? Хэрэв Есүс таны Эзэн Бурхан чинь байх юм бол Тэрээр Томаст хэрхэн хандаж байсан шигээ танд хандах болно. Тийм учраас та баяртай байх болно!

## - ТҮҮХ 33. ЕСҮСТ БҮХНИЙГ ХАНГАХ ХҮЧ БИЙ

Иохан 21:2-6; 9-12; 15-17

Симон Петр, ихэр гэгддэг Томас, Галилын Канагийн Натанаел, Зебедеен ховгүүд бас Түүний шавь нараас хоёр өөр хүн цугтаа байв. Симон Петр тэдэнд – Би загас барихаар явлаа гэхэд тэд

– Бид ч бас чамтай хамт явъя гээд завиндаа суув. Тэр шөно тэд юу ч барьсангүй. Үүр цайх үед Есүс эрэг дээр зогсож байлаа. Гэвч шавь нар нь Түүнийг таньсангүй. Есүс тэдэнд

– Хүүхдүүд ээ, та нарт ямар ч загас алга уу? гэхэд тэд

– Алга гэлээ. Есүс тэдэнд – Завинныхаа баруун талд тороо хая. Тэгвэл та нар олз олно гэв. Тэд тороо тийш нь хаясанд, маш их загас торонд нь орсон тул тэд тороо ч татаж чадахааргүй болжээ.

Тэд эрэг дээр гараад, модны нүүрсний гал дээр нь байх загас

болон талхыг харав. Есүс тэдэнд – Нааш ир. Өглөөний хоолоо идэцгээ гэхэд түүнийг Эзэн мон гэдгийг мэдэж байсан шавь нараас нь хэн нь ч -Та хэн бэ? гэж асууж зүрхэлсэнгүй.

Тэднийг оглооний хоолоо идэж дуусахад Есүс Симон Петрт – Иоханы хүү Симон оо, чи Намайг тэднээс илүү хайрладаг уу? гэж асуухад тэр

– Тийм ээ, Эзэн. Миний танд хайртайг Та мэднэ гэж хэлэв. Есүс түүнд

– Миний хургануудыг тэжээ гэлээ. Есүс дахин хоёр дахь удаагаа түүнд

– Иоханы хүү Симон оо, чи Намайг хайрладаг уу гэхэд тэр Түүнд

– Тийм ээ, Эзэн миний Танд хайртайг Та мэднэ гэв. Есүс түүнд – Миний хоньдыг хариул гэлээ.

Есүс Түүнд гурав дахь удаагаа Иоханы хүү Симон оо, чи Намайг хайрладаг уу гэв. “Чи Намайг хайрладаг уу? гэж Есүс гурвантаа асуусан учир Петр гуниглав. Тэр – Эзэн, Та бүх юмсыг мэддэг. Миний Танд хайртайг Та мэднэ гэв. [Есүс] түүнд

– Миний хоньдыг тэжээ гэжээ.



## Ирээд Хоолло.

Есүсийн өглөөний хоолонд урьж байгаа ямар үзэсгэлэнтэй дүр зураг вэ! Есүс Өөрийн дагалдагчдыг элбэг хоолтой газар аваачдаг. Та зөвт байдлын төлөө өлсөж цангаж байна уу? Есүс хэлэхдээ: **“Зөвт байдлын төлөө өлсөж цангагч хүмүүс ерөөлтэй еө! Учир нь тэд хангалуун болох болно”** гэжээ. (Матай 5:6).

Сүнсний өглөөний цайгаа уухын тулд та өглөө бүр Түүний оршихуйд орж сүнсэнд чинь илчлэлт өгдөг Түүний үгээр хоолло. Таныг боолчлолоос чөлөөлсөн Бурхан Эзэн чинь танд хэлж байна: **“Амаа том ангайлга, Би түүнийг дүүргэнэ”** (Дуулал 10.6).

Хэрвээ та Есүст хамаатай бол “ирж хооллох” өөр бас нэгэн урилга байна. Есүс энэ дэлхийд ХААДЫН ХААН, ЭЗДИЙН ЭЗЭН болон дахин ирэхээсээ өмнө бүх итгэгчидтэй мөнхөд байгуулсан нэгдлээ хуримын ёслол болгон тэмдэглэх болно.

Иохан ийнхүү өгүүлжээ. **“Баярлан хөөрч, баясан цэнгэж, Түүнд алдрыг нь өргөцгөөе. Учир нь Хурганы хурим болж, Түүний сүйт бүсгүй өөрийгөө бэлдэв. Тэрээр гялалзсан, цэвэрхэн нарийн маалингаар хувцаслах болжээ. Учир нь тэрхүү нарийн маалинга бол ариун хүмүүсийн зөвт үйлс юм”** (Илчлэлт 19:7,8). Та энэ ёслолд бэлэн үү?

Харин та өөрийнхөө зөвт үйлсийг өмсөх хэрэггүй гэдгийг санаарай. Бурханы нүдэнд **“бидний бүх зөв үйлс нь бохир хувцас мэт харагддаг”**(Исаиа 64:6). Есүс зөвхөн Өөрөө л энэхүү гайхамшигтай найранд өмсөж очих зөвт үйлсийн дээл нь юм. **“Тэр нүглийг үл мэдэгч Түүнийг бидний төлөө нүгэл болгосон юм. Тэгснээр бид Түүний дотор Бурханы хүртээх зөвт байдал болох юм”** (2Коринт 5:21). Ямар гайхалтай өөрчлөлт вэ: Тэр бидний нүглийг аваад оронд нь Өөрийнхөө зөвт байдлыг өгсөн!

## Миний Хонийг Хариул.

Есүс таныг хооллосныхоо дараа, мөн бусдыг хооллоосой гэж танаас хүсдэг. Та энэхүү Иохан номын Библи судлалыг

судлаж сүнсээ хооллосон уу? Хэрэв тийм бол та сурсан зүйлсээ бусадтай хуваалцах ёстой. “**Та нарын дунд байгаа хонин сүргийг хариул.... харин хонин сүрэгтээ үлгэр дууриал болон хариул**”(1Петр 5:2,3). Бид Бурханы үгийг бусдад заах юм уу эсвэл тэдэнд үлгэр дууриал болсоноор ивээл болж чадна. “**Миний та нарт тушаасан бүгдийг сахин биелүүлэхийг тэдэнд заа. Харагтун, үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно... гэж айлдав**” (Матай 28:20).

## Хариултууд.

Та энэхүү Иохан номыг судлах Библи судлалын ном дээр гарсан асуултуудын хариултуудыг доорхи жагсаалтнаас олоод өөрийн хийсэн ажлыг шалган, зөв хариултыг мэдэж болно. Гэхдээ та бүх асуултандаа хариулчихсанахаа дараа энэ хуудаснаас лавлаж хараарай.

### Хуудас 4,5

1. Бурхан
2. Бурхантай хамт
3. амь
4. харанхуй
5. Иохан
6. Өөрийнхөн нь
7. Бурханы хүүхэд
8. цус, махан бие, хүн, Бурхан
9. махан бие
10. бидний дунд
11. дүүрэн, нигүүлсэл, нигүүлслийг
12. Хүү

### Хуудас 8,9

1. цөлд, дуу
2. замыг, шулуун
3. араас, тэргүүн
4. Бурханы Хурга, Ертенцийн, нүглийг
5. Израильд
6. Сүнс, тагтаа

### Хуудас 14

1. Тэр та нарт юу гэж айлдана, түүнийг нь хий.
2. амсарт нь хүртэл

### Хуудас 21,22

1. удирдагч, шөнө
2. багш
3. дахин төрөх
4. ус, Сүнснээс
5. махан бие
6. сүнс
7. Мосе, Могойг
8. хайрласан (хайртай), мөхөхгүй, амьтай
9. яллахын, аврахын
10. яллагдахгүй, итгэгч
11. яллалт, бузар муу, харанхуйг, гэрлээс
12. үнэнийг

### Хуудас 28, 29

1. Тэр ядарсан байлаа.
2. Ус өгөөч
3. Еврейчүүд Самаричуудтай харьцдаггүй байв.
4. амийн ус
5. Хэн энэ худагнаас ууна тэр дахин цангана. Хэн Есүсийн өгсөн уснаас ууна тэр хэзээ ч дахин цангахгүй.
6. Тэр эмэгтэй 5 нөхөртэй байсан ба өөрийн нөхөр биш хүнтэйгээ амьдарч байв.

7. мөргөх
8. сүнсээрээ, үнэнээр
9. хот уруу явж хүмүүст Христийн тухай яриу.
10. Өөрийг нь илгээсэн Бурханы хүслийг үйлдэн, ажлыг нь гүйцэлдүүлэх явдал байв.
11. ертөнцийн Аврагч, Христ

### Хуудас 34

1. эрүүл
2. эрүүл
3. Бос, яв
4. дахиж нүгэл бүү үйлд
5. (а) Амралтын өдрийг зөрчсөн (б) Бурхантай адилтгасан

### Хуудас 42

1. байвал, дагалдагчид
2. үнэн
3. боол
4. Хүү
5. хайрлах
6. Бурханы
7. хүслийг, мэднэ

### Хуудас 44, 45

1. Есүс
2. хөршүүд нь
3. Фарисайчууд
4. эцэг эх нь
5. сохор хүн
6. Есүс
7. сохор хүн

### Хуудас 61

1. хөлийг, угаасан, хөлийг, угаах
2. хайрласны, хайрлагтун

### Хуудас 67

1. ертөнцийнх
2. Эцэгийг
3. үзээд, үзэн ядаж
4. шалтгаангүйгээр
5. алах, Бурханд
6. мэдээгүй
7. ялсан

### Хуудас 77

1. Амар амгалан
2. Би ... та нарыг илгээнэ
3. хүлээн авагтун.